

# “ХҮҮХЭД ХАМГААЛАЛ МИНИЙ НҮДЭЭР”

## ГАР ЗУРГИЙН БОЛОН ЭССЭ БИЧЛЭГИЙН УРАЛДААН

Говь-Алтай аймаг, Хүүхдийг Ивээх Сан
2025 он

**Зөвлөх:** Л.Баян-Алтай
**Бүтээлийг эмхэтгэсэн:** Ц.Баярцэцэг
**Редактор:** Ч.Батпүрэв, Г.Цолмон
**Дизайнер:** Л.Лхагвачимэг

# Гарчиг


| | |
|---|---|
| Өмнөх үг | **4** |
| “Хүүхэд хамгаалал миний нүдээр” гар зургийн уралдааны удирдамж | **7** |
| “Хүүхэд хамгаалал миний нүдээр” эссэ бичлэгийн уралдааны удирдамж | **8** |
| “Хүүхэд хамгаалал миний нүдээр” гар зургийн уралдааны **Шагналт байрны бүтээлүүд** 6-9 насны ангилал | **9** |
| “Хүүхэд хамгаалал миний нүдээр” гар зургийн уралдааны **Бусад бүтээлүүд** 6-9 насны ангилал | **14** |
| “Хүүхэд хамгаалал миний нүдээр” гар зургийн уралдааны **Шагналт байрны бүтээлүүд** 10-13 насны ангилал | **23** |
| “Хүүхэд хамгаалал миний нүдээр” гар зургийн уралдааны **Бусад бүтээлүүд** 10-13 насны ангилал | **28** |
| “Хүүхэд хамгаалал миний нүдээр” гар зургийн уралдааны **Шагналт байрны бүтээлүүд** 14-18 насны ангилал | **50** |
| “Хүүхэд хамгаалал миний нүдээр” гар зургийн уралдааны **Бусад бүтээлүүд** 14-18 насны ангилал | **55** |
| “Хүүхэд хамгаалал миний нүдээр” эссэ бичлэгийн уралдааны **Шагналт байрны бүтээлүүд** 6-9 насны ангилал | **70** |
| “Хүүхэд хамгаалал миний нүдээр” эссэ бичлэгийн уралдааны **Бусад бүтээлүүд** 6-9 насны ангилал | **75** |
| “Хүүхэд хамгаалал миний нүдээр” эссэ бичлэгийн уралдааны **Шагналт байрны бүтээлүүд** 10-13 насны ангилал | **80** |
| “Хүүхэд хамгаалал миний нүдээр” эссэ бичлэгийн уралдааны **Бусад бүтээлүүд** 10-13 насны ангилал | **87** |
| “Хүүхэд хамгаалал миний нүдээр” эссэ бичлэгийн уралдааны **Шагналт байрны бүтээлүүд** 14-18 насны ангилал | **121** |
| “Хүүхэд хамгаалал миний нүдээр” эссэ бичлэгийн уралдааны **Бусад бүтээлүүд** 18 насны ангилал | **127** |



**Л.Баян-Алтай**
Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь Суурин төлөөлөгч

# Өмнөх үг

Хүүхдийг Ивээх Сан нь “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийг Говь-Алтай аймагт 2023 оноос өнөөг хүртэл амжилттай хэрэгжүүлж байна. Уг төслийн хүрээнд тус аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газартай хамтран “Хүүхэд хамгааллын асуудал, шийдэл” чуулга уулзалтыг 2025 оны 10 дугаар сарын 7-8 нд зохион байгуулсан юм. Чуулга уулзалтыг угтаж 2025 оны 09-р сарын 24-ны өдрөөс 10 сарын 02-ны хооронд Говь-Алтай аймгийн хэмжээнд “Хүүхэд хамгаалал миний нүдээр” гар зураг болон эссэ бичлэгийн уралдааныг зарлаж дүгнэсэн билээ. Энэ нь хүүхдүүдийн дуу хоолойг урлаг, уран зохиолоор дамжуулан олон нийтэд хүргэх, тэдний бүтээлч сэтгэлгээг дэмжих, хүүхдийн эрхийн талаарх ойлголтыг түгээхэд чухал ач холбогдолтой байв.

Энэхүү номдоо Говь-Алтайн хүүхэд, багачуудын хүсэл мөрөөдөл, бодол санааг тусгасан 138 хүүхдийн бүтээлийг багтаалаа. “Хүүхэд хамгаалал миний нүдээр” эссэ бичлэгийн уралдаанд 84 хүүхэд, гар зургийн уралдаанд 54 хүүхэд 3 насны ангиллаар оролцсон юм. Бүтээл нэг бүрээс хүүхдүүдийн хүсэл мөрөөдлийг олж харах боломжтой.

Тэд маань хүүхэд хамгааллын өнөөгийн бодит байдлыг өөрсдийн ажигласнаар цаасан дээр буулгасан юм. Мөн эрхээ хамгаалуулах, аюулгүй орчинд амьдрах үзэл бодол, санал санаачилгаа уран сэтгэмжээр баяжуулан зурж, бичиж илэрхийлсэн нь үнэ цэнтэй болжээ. Эдгээр нь чухамхүү үнэт бүтээлүүд билээ.

Та бүхэн энэ номоос хүүхдийн нүдээр ертөнцийг тольдоорой. Хүүхдүүдийн дуу хоолойг сонсоорой. Улмаар Та хүүхэд хамгааллын зохист орчин бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах урам зориг авна гэдэгт итгэлтэй байна.

Хүүхэд бүр аз жаргалтай, аюулгүй орчинд амьдрах эрхтэй!



**Г.Чинбат**

Говь-Алтай аймгийн Засаг дарга, Хүүхдийн төлөө Зөвлөлийн тэргүүн

Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар нь Японы Хүүхдийг Ивээх Сантай хамтран “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийг 2023-2025 онд амжилттай хэрэгжүүлж байгаа билээ. Энэ төслийн хүрээнд сургуулийн дотуур байрны багш, сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, сумын нийгмийн ажилтнуудыг үе шаттай сургалтад хамруулж, чадавхжуулсан юм. Шаардлагатай сурах бичиг, ном, гарын авлагаар хангаж, хүүхдийн хөгжил хамгаалалд эцэг, эхийн оролцоог нэмэгдүүлж, үр дүнтэй хамтран ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөгжлийн хөтөлбөрт “Боловсролын чанарыг сайжруулах”, “Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг сайжруулах” хөтөлбөрийг тус тус боловсруулж хэрэгжүүлэх, хүүхдүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох гэхчлэн олон талт зорилт тусган хэрэгжүүлж байна.

Говь-Алтай аймагт хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээг сайжруулах салбар дундын хэлэлцүүлэг өрнүүлэх, тулгамдсан асуудлыг хамтран тодорхойлох, хүүхдэд хамгааллын болон боловсролын үйлчилгээ үзүүлэх мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор “Хүүхэд хамгааллын асуудал, шийдэл” чуулга уулзалтыг зохион байгуулж, хамтран ажиллах шийдлээ тодорхойллоо.

Энэ чуулга уулзалтыг угтан хүүхдийн эрх, хамгааллын талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, хүүхдийн дуу хоолойг сонсох, бүтээлч сэтгэлгээг дэмжих зорилгоор “Хүүхэд хамгаалал миний нүдээр” гар зураг, эссэ бичлэгийн уралдаан зарлан дүгнэв. Уралдаанд ирсэн бүтээлүүдийг эмтхтгэн, ном болгон Таны гарт хүргэж байгаа тул хүүхдийн санаа бодлыг тунгаан бодож, хүүхэд хамгааллын үйлчилгээг сайжруулж, хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд ахиц дэвшил гарган ажиллана гэдэгт итгэж байна.

Алтай нутгийн хүүхэд бүр өмнөө тавьсан зорилготой, түүндээ хүрэх хүсэл тэмүүлэлтэй, өөрийгөө болон бусдыг хүндэтгэж, байнга суралцан хөгжиж, буруу муу зуршлаас хол байж, сайн сайхан зүйлд санаачилгатай хандаж, ирээдүйд сайн хүн болж сурч, хүмүүжихийг хүүхэд багачууд та бүхэндээ уриалж байна.
Хүүхэд, багачуудын сайн сайхны төлөө хамтран ажилласан хүн бүрт талархал илэрхийлж, ажлын амжилт, эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе.

Сайн үйлс бухэн дэлгэрч, Алтай сайхан нутаг минь цэцэглэн хөгжих болтугай!



**Б.Алтайбаатар**

Говь-Алтай аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга

Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүүхдийг Ивээх Сан, Говь-Алтай аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар хамтран "Хүүхэд хамгааллын асуудал, шийдэл" чуулга уулзалтыг Алтай хотноо 2025 оны 10 дугаар сарын 7-8-нд амжилттай зохион байгуулсан билээ. Энэхүү чуулга уулзалтаар хүүхдийн хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээнд салбар дундын хамтын ажиллагааг сайжруулахад тулгамдсан асуудлыг хамтран тодорхойлох, хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагуудын мэргэжилтнүүдийг чадавхжуулах зорилготой хэлэлцүүлэг зохион байгуулсан. Мөн чуулга уулзалтыг угтаж "Хүүхэд хамгаалал, миний нүдээр" гар зургийн болон эссэ бичлэгийн уралдаан зарласан юм.

Тус уралдааны эссэ бичлэгийн төрөлд Говь-Алтай аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 84 хүүхэд, 3 насны ангилалд, гар зургийн төрөлд 53 хүүхэд, мөн 3 насны ангилалд оролцсон бөгөөд аймгийн Засаг даргын Тамгын газраас шилдэгүүдийг тодруулж, шагнаж урамшууллаа. Уралдааны бүх бүтээлээр үзэсгэлэн гаргаж, чуулганд оролцогчид болон иргэд, олон нийтэд сурталчлан танилцуулсан билээ. "Хүүхэд хамгаалал миний нүдээр" уралдааныг амжилттай зохион байгуулснаар хүүхдүүд эрхээ танин мэдэж, хамгаалуулах талд ахиц дэвшил гарлаа. Түүнчлэн томчууд хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, сургууль болон гэр бүлийн орчин дахь аюулгүй байдлыг баталгаажуулах, хүчирхийллээс ангид байх, хүүхэд бүрийг хайр халамж, тэгш боломжоор хангах мэдлэг, мэдээлэлтэй болсон нь ач холбогдолтой юм. Уралдаанд оролцогч хүүхдүүд маань зураг болон эссэ бичлэгээр дамжуулан хүүхэд хамгааллын өнөөгийн бодит байдлын талаар үзэл бодол, санал санаачилгаа бүтээлчээр илэрхийлсэн юм.

"Хүүхэд хамгааллын асуудал, шийдэл" чуулга уулзалт нь Говь-Алтай аймагт хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээг сайжруулах, салбар дундын хэлэлцүүлэг өрнүүлэх, тулгамдсан асуудлыг хамтран тодорхойлох, хүүхдэд хамгааллын болон боловсролын үйлчилгээ үзүүлэх мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэхэд чухал үр дүн үзүүлсэн ажил, арга хэмжээ болсонд баяртай байна.

# “ХҮҮХЭД ХАМГААЛАЛ МИНИЙ НҮДЭЭР”
# ГАР ЗУРГИЙН
# УРАЛДААНЫ УДИРДАМЖ

**Зорилго:** Говь-Алтай аймгийн ЗДТГ, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар болон Хүүхдийг Ивээх Сан (ХИС) хамтран **“Хүүхэд хамгааллын асуудал, шийдэл”** чуулга уулзалтыг 2025 оны 10-р сарын 7,8-нд Алтай хотноо зохион байгуулна. Тус арга хэмжээний зорилго нь 2024-2028 оны Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлэх Хүүхэд хамгааллын стратегийн бичиг баримтыг танилцуулах, хүүхэд хамгаалалд оролцогч талууд болон хүүхдүүдийн саналыг сонсох, ХИС-гийн сайн туршлагаас хуваалцах, цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөөг хамтран боловсруулах явдал юм. Тус чуулга уулзалтыг угтан хүүхдийн эрх, хамгааллын талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, хүүхдүүдийн бүтээлч сэтгэлгээг дэмжих, тэдний дуу хоолойг урлагаар дамжуулан илэрхийлэх Хүүхдийн гар зургийн уралдаан зарлаж байна.

**Сэдэв:** “Хүүхэд хамгаалал миний нүдээр”. Оролцогчид нь хүүхдийн эрх ба эрхийн зөрчил, хүүхэд хамгаалал, сургууль болон гэр бүлийн орчин дахь аюулгүй байдал, хүчирхийллээс ангид байх, хайр халамж, тэгш боломж, тусгай хэрэгцээт хүүхдийн асуудлууд гэх мэт сэдвээр өөрийн ойлголт, санааг илэрхийлсэн зураг зурж, ирүүлнэ. Энэ нь асуудал хөндсөн, олон нийтэд хүргэх эсвэл асуудлын шийдлийг санал болгосон байж болно.

**Оролцогчид:** 6–18 насны хүүхдүүд (Хувийн болон төрийн бүх шатны сургуулийн сургагчид, асрамжийн төв, хөгжлийн төвийн болон тусгай хэрэгцээт хүүхдүүд оролцох боломжтой)

**Хүлээн авах хугацаа:** 2025 оны 09-р сарын 24-ний өдрөөс 10 сарын 02-ны хооронд

**БҮТЭЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА:**

- **Гар зураг** нь A3 эсвэл A4 хэмжээтэй цаасан дээр хийгдсэн байх
- **Зурах хэрэгсэл:** усан будаг, энгийн харандаа, пастель, фломастер гэх мэт
- Бүтээл нь тухайн оролцогчийн өөрийн гараар зурсан, өмнө нь уралдаанд оролцож байгаагүй байх
- Зургийн ар талд оролцогчийн овог, нэр, нас, сургууль, анги, холбоо барих утасны дугаар, хаяг тодорхой бичсэн байх.

**ШАЛГАРУУЛАЛТ:**
**Насны ангиллаар:** (6–9 нас, 10–13 нас, 14–18 нас)
**Шүүгчдийн бүрэлдэхүүн:** Зураач, ХГБХХ газрын мэргэжилтэн, ХИС, хүүхдийн зөвлөлийн төлөөлөл

- **Үнэлгээний шалгуур:**

Сэдвийн ойлголт, илэрхийлэл; Ур чадвар, бүтээлч байдал; Эерэг мессеж, нийгмийн ач холбогдол

**Шагнал:**
- Тэргүүн байр – Өргөмжлөл + 200,000 мянган төгрөгийн мөнгөн шагнал
- Дэд байр – Өргөмжлөл + 150,000 мянган төгрөгийн мөнгөн шагнал
- Гутгаар байр – Өргөмжлөл + 100,000 мянган төгрөгийн мөнгөн шагнал
- Тусгай байр – Өргөмжлөл + 50,000 мянган төгрөгийн мөнгөн шагнал

*Нийт оролцогчдод уралдааны зохион байгуулагчдын зүгээс Талархлын гэрчилгээ өгнө.*

**Бүтээл хүлээн авах хаяг:** Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Жинст баг, Хөгжлийн 1400/14, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар.

**Утас:** 7048-3371; **Цахим шуудан:** govialtai@fcy.gov.mn

# “ХҮҮХЭД ХАМГААЛАЛ МИНИЙ НҮДЭЭР” СЭДЭВТ ЭСЭЭ БИЧЛЭГИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

**Зорилго:** Говь-Алтай аймгийн ЗДТГ, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар болон Хүүхдийг Ивээх Сан (ХИС) хамтран **“Хүүхэд хамгааллын асуудал, шийдэл”** чуулга уулзалтыг 2025 оны 10-р сарын 7,8-нд Алтай хотноо зохион байгуулна. Тус арга хэмжээний зорилго нь 2024-2028 оны Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлэх Хүүхэд хамгааллын стратегийн бичиг баримтыг танилцуулах, хүүхэд хамгаалалд оролцогч талууд болон хүүхдүүдийн саналыг сонсох, ХИС-гийн сайн туршлагаас хуваалцах, цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөөг хамтран боловсруулах явдал юм. Тус чуулга уулзалтыг угтан хүүхдийн эрх, хамгааллын талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, хүүхдүүдийн бүтээлч сэтгэлгээг дэмжих, тэдний дуу хоолойг бичгээр дамжуулан илэрхийлэх Хүүхдийн эсээ бичлэгийн уралдаан зарлаж байна.

**Сэдэв:** “Хүүхэд хамгаалал миний нүдээр”. Оролцогчид нь хүүхдийн эрх ба эрхийн зөрчил, хүүхэд хамгаалал, сургууль болон гэр бүлийн орчин дахь аюулгүй байдал, хүчирхийллээс ангид байх, хайр халамж, тэгш боломж, тусгай хэрэгцээт хүүхдийн асуудлууд гэх мэт сэдвээр өөрийн ойлголт, санааг илэрхийлсэн эсээ бичлэгийг бичиж, ирүүлнэ. Асуудал хөндсөн, олон нийтэд хүргэх эсвэл асуудлын шийдлийг санал болгосон байж болно.

**Оролцогчид:** 6–18 насны хүүхдүүд (Хувийн болон төрийн бүх шатны сургуулийн сургагчид, асрамжийн төв, хөгжлийн төвийн болон тусгай хэрэгцээт хүүхдүүд оролцох боломжтой)

**Хүлээн авах хугацаа:** 2025 оны 09-р сарын 24-ний өдрөөс 10 сарын 02-ны хооронд

**БҮТЭЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА:**

- Эсээ нь А4 хэмжээтэй цаасны 1-2 нүүр (гараар бичсэн эсвэл компьютерт шивж хэвлэсэн байх)
- Монгол хэл дээр бичигдсэн байх
- Үг, үсгийн алдаагүй, уншигдахуйц байх
- Бүтээл нь өмнө нь нийтлэгдээгүй, өөрийн оюуны бүтээл байх

**ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ:**
Насны ангиллаар: (6–9 нас, 10–13 нас, 14–18 нас)
Шүүгчдийн бүрэлдэхүүн: ХГБХХ газрын мэргэжилтэн, ХИС, хүүхдийн зөвлөлийн төлөөлөл, багш нар

**Үнэлгээний шалгуур:**
- Сэдвийн хүрээнд бичсэн байдал; Асуудал хөндсөн, шийдэл санал болгосон байх; Найруулга, бичгийн соёл; Хүүхдийн оролцоо, дуу хоолойг тусгасан байдал

**Шагнал:**
- Тэргүүн байр – Өргөмжлөл + 200,000 мянган төгрөгийн мөнгөн шагнал
- Дэд байр – Өргөмжлөл + 150,000 мянган төгрөгийн мөнгөн шагнал
- Гутгаар байр – Өргөмжлөл + 100,000 мянган төгрөгийн мөнгөн шагнал
- Тусгай байр – Өргөмжлөл + 50,000 мянган төгрөгийн мөнгөн шагнал

*Нийт оролцогчдод уралдааны зохион байгуулагчдын зүгээс Талархлын гэрчилгээ өгнө.*

**Бүтээл хүлээн авах хаяг:** Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Жинст баг, Хөгжлийн 1400/14, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар.

**Утас:** 7048-3371; **Цахим шуудан:** govialtai@fcy.gov.mn

“ХҮҮХЭД ХАМГААЛАЛ МИНИЙ НҮДЭЭР”
СЭДЭВТ ЗУРГИЙН УРАЛДААНЫ

# ШАГНАЛТ БАЙРНЫ БҮТЭЭЛҮҮД

**6-9 НАСНЫ АНГИЛАЛ**






I БАЙР

**А.МӨНХБАЯР**
Есөнбулаг сум, 2-р сургууль, 3б анги




II
БАЙР

**З.МӨНХТҮВШИН**
Есөнбулаг сум, 1-р сургууль,
2г анги



III
БАЙР

**А.НАНДИН-ЭРДЭНЭ**
1-р сургууль, 2е анги




IV БАЙР

**Б.БАДАМДАРЬ**
Дэлгэр сумын ЕБС, 3б анги

“ХҮҮХЭД ХАМГААЛАЛ МИНИЙ НҮДЭЭР”
СЭДЭВТ ЗУРГИЙН УРАЛДААНЫ

# БУСАД БҮТЭЭЛҮҮД

**6-9 НАСНЫ АНГИЛАЛ**





**Д.ГАЛБАДРАХ**
1-р сургууль, 2в анги



**Б.БАТСУУРЬ**
1-р сургууль, 2е анги



**Э.ЭРДЭНЭЛХАМ**
Гуулин ЕБС, 2а анги



**Н.АМАРТҮВШИН**
Гуулин ЕБС, 2а анги



**Г.АМГАЛАНБАТ**
Гуулин ЕБС, 2а анги




**Т.БИЛГҮҮДЭЙ**

4-р сургууль, 4в анги



**Б.АНХ-ЭРДЭНЭ**
3-р сургууль, 4а анги



**Б.АМИН-ЭРДЭНЭ**
3-р сургууль, 1г анги

“ХҮҮХЭД ХАМГААЛАЛ МИНИЙ НҮДЭЭР”
СЭДЭВТ ЗУРГИЙН УРАЛДААНЫ

# ШАГНАЛТ БАЙРНЫ БҮТЭЭЛҮҮД

**10-13 НАСНЫ АНГИЛАЛ**






I БАЙР

**Б.БОЛОРТУЯА**
Хөхморьт сум, 1-р сургууль,
8б анги




II БАЙР

**Б.ГҮНБИЛЭГ**
Есөнбулаг сум, 1-р сургууль,
5б анги




**Н.БАТНОРОВ**
Есөнбулаг сум, 1-р сургууль,
6б анги



IV
БАЙР

**Б.БАТСУУРЬ**
Гуулин тосгоны ЕБС, 6а анги

“ХҮҮХЭД ХАМГААЛАЛ МИНИЙ НҮДЭЭР”
СЭДЭВТ ЗУРГИЙН УРАЛДААНЫ

# БУСАД БҮТЭЭЛҮҮД

**10-13 НАСНЫ АНГИЛАЛ**






**Б.БАЯНСАР**
1-р сургууль, 7е анги



**Х.ЭНХ-ЭРДЭНЭ**
1-р сургууль, 7е анги



**Ч.ЦЭЭМЭЭ**
Гуулин ЕБС, 5а анги



**С.ХҮСЭЛСАЙХАН**
Гуулин ЕБС, 6а анги



**Г.СУМХҮҮ**
Гуулин ЕБС, 6а анги




**А.ТҮМЭНХИШИГ**
Гуулин ЕБС, 6а анги



**А.СУВДАНЦЭЦЭГ**
Гуулин ЕБС, 5а анги



**Б.СУМЪЯАБЭЙС**
Гуулин ЕБС, 6а анги




**Д.ӨСӨХ-ИРЭЭДҮЙ**
Цээл сум, 6б анги




**Б.ОЮУНТУЯА**
Хөхморьт сум, 8б анги




**Д.АРИУНЖАРГАЛ**
Хөхморьт сум, 8б анги




**Н.МИНЖИНСОР**
Хөхморьт сум, 7а анги




**М.ЗАНАБАЗАР**
Дэлгэр сум, 6а анги




**Б.БАРЗУЛ**
Дэлгэр сум, 6а анги



Хүүхдийн эрхийг хангаарай миний нүдээр

Миний зургийг харж байгаад маш их баярлалаа. Би та нарт зургаа тавьсан танилцуулъя. Хүүхэд болон эрхтэй байдал бол тэдний нэг нь сурч сургуульд сурах. Миний зураг бол маш энгийн байгаа биз дээ гэхдээ гал үнэндээ бол маш их аз жаргал хайр сэтгэл гэх олон зүйл агуулсан. Хүүхдийн эрх гэдэг л миний нүдээр маш том санагдал бол хөдөлмөр юу хэрэгтэй байдаг юм гэдгийг хүн бүрт мэдүүлж сануулж байх нь хүн эх болон өөрийн той ашигт мөнөөх мөн шүү.

6А анги Б. Марал-Эрдэнэ

**Б.МАРАЛ-ЭРДЭНЭ**
Дэлгэр сум, 6а анги




**С.АНУНГОО**
1-р сургууль, 6б анги




**Х.МӨНГӨНТҮЛХҮҮР**
1-р сургууль, 6б анги



**А.БААСАНЖАРГАЛ**
Төгрөг сум, 6б анги



**Д.БАТЧИМЭГ**
Төгрөг сум, 6б анги




**Х.АНХЗАЯА**
Дарив сум, ЕБС, 5а анги




**М.ЦЭНДЗҮСЭМ**
1-р сургууль, 8д анги

“ХҮҮХЭД ХАМГААЛАЛ МИНИЙ НҮДЭЭР”
СЭДЭВТ ЗУРГИЙН УРАЛДААНЫ

# ШАГНАЛТ БАЙРНЫ БҮТЭЭЛҮҮД

**14-18 НАСНЫ АНГИЛАЛ**





I БАЙР

**Э.МӨНХЗУЛ**

Баян-Уул сум, 1-р сургууль,
12д анги




II БАЙР

**Ж.АНХЗАЯА**
Лицей 10а анги




III БАЙР

**Т.АЛТАНШАГАЙ**
5-р сургууль, 11а анги



IV БАЙР

**А.ЭРХЭС**
Есөнбулаг сум, 10а анги

“ХҮҮХЭД ХАМГААЛАЛ МИНИЙ НҮДЭЭР”
СЭДЭВТ ЗУРГИЙН УРАЛДААНЫ

# БУСАД БҮТЭЭЛҮҮД

**14-18 НАСНЫ АНГИЛАЛ**






**Б.ЭРДЭНЭТҮВШИН**
Гуулин ЕБС, 10а анги




**Э.ЧАНАРАВ**
1-р сургууль, 12в анги



**Э.БАТСАЙХАН**
1-р сургууль, 11а анги



**Б.БОЛОР-ЭРДЭНЭ**
1-р сургууль, 11а анги




**Б.ШҮРЭН-ЭРДЭНЭ**
ХЭЦС, 10а анги




**Э.ТӨРТУЛГА**
Цээл сум, 11а анги




**Б.ХОНГОРЗУЛ**
ХЭЦС, 12а анги



**О.БААСАНЧУЛУУН**
МБС, 12а анги



**М.БҮНЧИНЛХАМ**
МБС, 12а анги




**Б.БАТЦЭЦЭГ**
Баян-Уул сум, 12б анги



**Ч.ЭГШИГЛЭН**
Дарив сум, 9а анги




**Ц.СЭР-ОД**
Бигэр сум, 11а анги




**Э.БАЯРМАА**
Баян-Уул, 12б анги



**Д.ОТГОНЧИМЭГ**
ХЭЦС, 12а анги

“ХҮҮХЭД ХАМГААЛАЛ МИНИЙ НҮДЭЭР”
СЭДЭВТ ЭССЭ БИЧЛЭГИЙН

# ШАГНАЛТ БАЙРНЫ БҮТЭЭЛҮҮД

**6-9 НАСНЫ АНГИЛАЛ**



Говь-Алтай аймгийн ерөнхий боловсролын
лаборатори I сургуулийн 4г ангийн
сурагч Б.Буянхишигт

## Хүүхэд хамгаалал миний нүдээр

Би 9 настай. Миний бодлоор хүүхэд хамгаалал гэдэг бол хүүхэд айхгүй, ганцаараа үлдэхгүй, мөрөөдлөө чөлөөтэй ярьж чаддаг байхыг хэлнэ. Намайг хамгийн сайн хамгаалдаг зүйл бол манай гэр бүл. Ээж намайг тэврэч, аав надад урам өгдөг болохоор би өөрийгөө аюулгүй гэж мэдэрдэг. Бас сургууль дээр багш намайг сонсож, найзууд маань надруу инээмсэглэхэд би өөрийгөө хамгаалагдсан юм шиг санадаг. Би ирээдүйд барилгын инженер болно гэж мөрөөддөг. Өндөр байшин, сайхан гүүр барьж, хүмүүсийг аюулгүй амьдруулахыг хүсдэг. Барилгын инженер хүн байшингаа бат бөх барьдаг шиг, хүүхэд хамгаалал ч бас бидний ирээдүйг бат бөх болгодог гэж би боддог. Миний нүдээр хүүхэд хамгаалал гэдэг бол ээжийн инээмсэглэл, аавын зөвлөгөө, багшийн урам, найзуудын инээд юм. Энэ бүгдийг биднийг хамгаалж буй бат бөх "барилга" гэж төсөөлдөг. Хүүхэд хамгаалал сайн байвал бид мөрөөдлөө биелүүлж, би ч бас өөрийнхөө том барилгыг босгож чадна.

I БАЙР

**Б.БУЯНХИШИГТ**
1-р сургууль, 4г анги

Хүүхэд хамгааллын [illegible]

Юуны түрүүнд би өөрийгөө танилцуулъя. Би Даваасүрэнгийн [illegible] Буянзаяа. Хүүхэд хамгааллын тухай хүүхэд бол ирээдүйн цэцэг гэж [illegible] [illegible] [illegible] юм шүү. [illegible] Хамгийн гол ирээдүй хүүхэд сайхан [illegible] бол манай [illegible] [illegible]. Бас эх орноо хамгаалж байгаа цэрэг ах нараа бид маш их [illegible] хүндэтгэх.

Тэгээд би хүн, хүүхэд бүр эрх тэгш эрхтэй байх хэрэгтэй гэж бодож байна. Ямар ч хүүхэд аав ээжээс хамааралгүй хайрлагдаж [illegible] байх ёстой. Бас хүчирхийллээс хол байж эрүүл өсөж байх ёстой. Гэхдээ хамгийн [illegible] [illegible]. Тэгээд бас эрх зүйн гэж байдгийг [illegible] юм байна. Хамгийн гол хүүхэд бүхний [illegible] байх маш чухал. Хүүхэд бол маш чухал хүн юм. Тийм болохоор хүүхэд асуудлыг [illegible] байж тэр [illegible] [illegible] хэрэгтэй. Бас хүүхэд [illegible] болон аав ээжийн тань юм. Бас хүүхэд асуудлыг [illegible] [illegible] хэрэгтэй. Түүнээс гадна, [illegible], [illegible] маш сайн [illegible] [illegible] нь [illegible] маш [illegible] [illegible]. Бас хүүхэд тухай [illegible] асуудал маш олон байдаг. [illegible] нь [illegible] асуудлыг [illegible] хамгаалан эд зүйл [illegible] байх ёстой. Бас хүүхэд бүхэн [illegible] байх хэрэгтэй. Бас хүүхэд [illegible] [illegible] [illegible] хүүхдээ зөв хүмүүжүүлэх ёстой. Тэр бол ээж аав [illegible] хамгааллагдах үүрэг хариуцлага. Бас хүүхдээ маш сайн хамгаалж [illegible] хүмүүжүүлж [illegible] байдаг. Бас манай улс хүүхдийн [illegible] [illegible], хүүхдийн [illegible], [illegible] байр гэх мэт хүүхэд [illegible] газрууд олон байдаг. Бас тэр газрууд нь хүүхдийн хөгжүүлэх, хамгаалах, дэмжих, хүмүүжүүлэх, эрүүл саруул байлгахад их тустай. Бас би 7 настай хүүхэд. Би 3 настай [illegible] [illegible] [illegible] бас би дараа хоёр дүүтэй. Аав ээж минь намайг болон дүү нараа маш [illegible] [illegible] хайрлан хамгаалдаг. Тийм учраас би тэднээс улам [illegible] авч маш их хичээж байгаа.

Тийм болохоор аав ээж минь намайг дэмжиж бас үргэлж [illegible] [illegible] гэж би бодож байна. Бас бүх хүүхэд ингэж хайрлагдаасай гэж хүсэж байна. Гэхдээ дүүгээ байнга аав ээж минь намайг харж хандаж, байгаад би нэг зүйлийг ухаарсан юм. Тэр нь намайг үргэлж саруул [illegible] гэж [illegible] бүгд нь [illegible] [illegible] гэж ойлгосон юм.

Говь-Алтай аймгийн Дэлгэр сум Дэлгэр ЕБС 4б анги Д.Буянзаяа.

II БАЙР

**Д.БУЯНЗАЯА**
Дэлгэр сум, 4б анги

# Хүүхэд хамгааллын тухай

Хүүхэд гэдэг бол гэр бүлийн баяр баясгалан, улсын ирээдүй юм. Биднийг хайрлаж, хамгаалж өсгөх нь эцэг, эх, багш, томчуудын үүрэг юм.

Зарим хүүхдүүдийг томчууд зоддог, загнадаг, зарим үед хичээлд нь явахыг хориглодог. Энэ бол буруу. Хүүхэд бүр хайрлагдах, хамгаалагдах эрхтэй. Харин томчууд хүүхдүүдийг зовоож болохгүй.

Хүүхдүүд эрүүл, аюулгүй орчинд тоглож, сурч боловсрох эрхтэй. Хэрвээ хүүхэд муу зүйл тохиолдвол том хүнтэй ярилцах, тусламж хүсэх хэрэгтэй. Харин томчууд хүүхдүүдийн дуу хоолойг сонсож, тусалж байх ёстой.

Би өөрөө ч бас найзууддаа тусалж, муу зүйлээс хамгаалдаг хүүхэд байхыг хүсдэг.

Бид бүгдээрээ бие биенээ хайрлаж, хамгаалж байвал манай анги, сургууль, улс орон илүү аз жаргалтай болно.

4-р сургууль 4в ангийн сурагч Ган-Очир




III БАЙР


**Г.ГАН-ОЧИР**
4-р сургууль, 4в анги

## ХҮҮХЭД ХАМГААЛАЛ МИНИЙ НҮДЭЭР

Би одоо хүүхэд. Хүүхдийн нүдээр харвал хүүхэд хамгаалал гэдэг нь хүүхдүүдийг хайрлаж, хамгаалж, аюулгүй, аз жаргалтай амьдруулах тухай ойлголт юм. Хүүхэд бүр эрхтэй. Тоглох эрхтэй, сургуульд сурах эрхтэй, мөрөөдлөө биелүүлэх эрхтэй. Энэ эрхийг хамгаалах нь хүүхэд хамгаалал гэж би боддог.

Хүүхдийг хамгаална гэдэг нь зөвхөн гэртээ ээж аав, эмээ өвөө нарын хайр халамж биш. Сургууль дээр багш нар, гудамжинд том хүмүүс ч бас хүүхдүүдийг зөв хамгаалах ёстой. Жишээ нь, хүүхдийг доромжлохгүй, дээрэлхэхгүй, хүчирхийлэхгүй байх. Хүүхдийг муу зуршил, муу найзаас хол байлгах. Бас хүүхдийн үгийг сонсож, ойлгож байх нь хамгаалал гэж боддог.

Заримдаа бид өөрсдөө ч хүүхэд хамгаалалд оролцож чадна. Би жишээлбэл, найзаа дээрэлхүүлэх үед нь хамгаалж, тайтгаруулж чадна. Хэн нэгэн уйлж байвал инээмсэглүүлж, тоглоомондоо урьж болно. Энэ бол хүүхэд хамгааллын хамгийн энгийн, гэхдээ хамгийн чухал арга. Хүүхдүүд өөрсдөө ч бие биенээ хайрлаж, хамгаалбал бид аз жаргалтай хамтдаа өснө.

Миний бодлоор хүүхэд хамгаалал гэдэг нь томчууд бидэнд тусалж, бид өөрсдөө ч бусдыг хайрлаж, хамгаалж сурч байхад л бүрэн утгаараа хэрэгжинэ. Хүүхэд бүр хамгаалагдсан орчинд байвал айдасгүй, өвдөлтгүй, зодоон маргаангүй, аз жаргалтайгаар суралцаж, тоглож чадна.

Би том болоод эмч болно гэж мөрөөддөг. Тэгээд би хүүхдүүдийг хайрлаж, хамгаалж, тэдний мөрөөдлийг биелүүлэхэд нь тусалж чадна. Одоохондоо би хүүхэд ч гэсэн, би ч бас хамгаалагч байж чадна гэж итгэдэг.

Говь-Алтай аймгийн хоёрдугаар сургуулийн

4а ангийн сурагч Н.Бодь-Алаг

IV
БАЙР

**Н.БОДЬ-АЛАГ**
1-р сургууль, 4а анги

“ХҮҮХЭД ХАМГААЛАЛ МИНИЙ НҮДЭЭР”
СЭДЭВТ ЭСЭЭ БИЧЛЭГИЙН

# БУСАД БҮТЭЭЛҮҮД

**6-9 НАСНЫ АНГИЛАЛ**



## Хүүхэд хамгаалал миний нүдээр

Хүүхэд гэдэг бол ирээдүй. Тэдний өнөөдрийн амьдрал, өсөлт, хүмүүжил, хөгжил, хамгаалалт нь бидний маргаашийн нийгмийг тодорхойлдог. Миний хувьд хүүхэд хамгаалал гэдэг нь зөвхөн хүүхдийг хүчирхийллээс хол байлгах төдий зүйл биш харин тэдний эрхийг хүндэтгэх, хөгжих боломжийг нь бүрдүүлэх хайр халамжаар дүүрэн орчинд амьдруулах явдал юм.

Хүүхэд бүр хайрлагдах, аюулгүй, тайван орчинд амьдрах эрхтэй. Гэвч бодит байдал дээр зарим хүүхэд хүчирхийлэлд өртөж боловсролоос ч хоцорч, ядуурлын ум, улмаас амьдралын үндсэн хэрэгцээнээсээ ч тасарч байгаа нь харамсалтай. Үүнийг өөрчлөхийн тулд бид бүгд хүүхэд хамгааллын талаар мэдлэгтэй, мэдрэмжтэй байх хэрэгтэй.

Хүүхдийг зөвхөн эцэг эх багш нар гэлтгүй нийгмийн бүх иргэд хамгаалах ёстой. Хамт, Хамтрагч нь өсөх хүчирхийлэл, хайр, хайхрамжгүй байдалд чимээгүй байж болохгүй юм.

4-р сургууль 4в ангийн сурагч:
А. Буянхишиг

**А.БУЯНХИШИГ**
4-р сургууль, 4в анги

Хүүхдийн байгууллага миний нүдээр

Хүүхэд нас бол хүний амьдралын хамгийн сайхан дурд дурсамж дүүрэн мартагдашгүй үе байдаг. Тийм болохоор хүүхэд багачуудын сурах хөгжих бүх зүйлийн төлөө аав, ээж, багш, хүүхдийн байгууллагууд бүтээлийн төлөө ажиллаж байдаг юм байна!

Манай оронд хүүхдийн байгууллага үүсэжний 100 жилийн ой тохиож баяраа тэмдэглэсэн.

Нэгэн зүйл: хүүхдийн байгууллага хүүхэд багачуудын их хөгжүүлж тусалж дэмждэг.

Хоёр зүйл: хүүхдийн эрхийн төлөө ажилладаг.

Гурван зүйл: хүүхдийг хөгжүүлдэг.

Нэгтгэж дүгнэвэл сайн, сайхан, , зүйл сурвал тэр болоод сайхан сэ, сэтгэлтэй болно.

4-р сургуулийн
4в ангийн
сурагч Э. Буянмөнх



**Э.БУЯНМӨНХ**
4-р сургууль, 4в анги

# Хүүхэд хамгаалал миний нүдээр

Миний эссэг уншиж суугаа танд энэ өдрийн мэндийг хүргэе. Намайг Түвшинбаярын Манлайбаяр гэдэг. Би Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын 2-р ангид сурдаг.
Сургуулийн алтан босгыг алхах тэрхэн мөчид надад маш их хэцүү байсан. Би шинэ орчинд дасан зохицох, нийгэмшихдээ маш муу. Олон хүүхэд харахаар учиргүй айлах дургүй хүрэх асуудлууд тулгарсан. Энэ нь намайг хичээлээ хоцрох, ялгаварлан гадуурхагдах шалтгаан болсон юм. Бурмаар тэтгэхээр урмаар тэтгэ гэсэн ардын зүйр цэцэн үг үнэхээр үнэн. Миний ээж намайг үргэлж урмын үгсээр урамшуулж, хоцрогдол бүхнийг үйлгүй давтуулж өнөөдрийн намайг өөртөө итгэлтэй, хичээлдээ шаламгай болгосон сайн чиглүүлэгч, сайн багш билээ.
Хүмүүсээ би биедээ урмын сайхан үгийг хэлж байгаарай. Бусдыг болон үр хүүхэд биднийг хайрлан хамгаалж байгаа хамгийн том бэлэг юм шүү.

2б ангийн сурагч Т. Манлайбаяр

**Т.МАНЛАЙБАЯР**
Баян-Уул сум, 2б анги

Хүүхэд хамгаалал миний нүдээр

Хүүхэд таны үйл хөдлөлийг харж өсдөг. Ээж, аав, ах, эгч болон томчууд хүүдийг зодож загнаж өсгөвөл тэр хүүхэд яг тийм уууртай хүн болдог. Хүүхэд хамгаалал гэдэг нь манайх болон г. дүүг, бусад хүүхдүүдийг баяр хөөртэй, аз жаргал-тай аюулгүй орчинд өсгөж загнаж зодохгүй байхыг хэлнэ. Томчууд хүүдээ зодож загнаж, хэлэх үгийг нь тоохгүй бол хүүхэд ээж аавдаа гомдож өөртөө итгэлгүй болно. Мөн том хүмүүс хүүхдэдээ чихэр хийжүүлээд ундаа, бохь чипс авч өгдөг. Манай ээж, аав, эгч, өвөө г бас. Энэ нь хүүхдийн эрүүл мэндэд маш муу байдаг. Би дахиж ундаа чихэр идэж ууахгүй болно. Манай ангийн зарим хүүхэд тоос шороотой хувцастай, гэрийн даалгавраа хийхгүй ирдэг. Хааяа муухай үг хэлдэг. Тэр хүүхдүүдийн ээж, аав нь хувцсыг нь угааж цэвэр хувцас өмсгөж, муухай үг хэлж болохгүй гэдгийг ярилцаж ойлгуулаасай. Бидний томчууд халамжилж, ойлгож, ярилцаж байх хэрэгтэй. Харин бид дүрэм журам сахиж, багш эцэг эхийнхээ үгийг сонсож гэрийн ажилд тусалвал өөрсдийгөө хайрлуулж хамгаалуулж чадна. Би том болоод цагдаа болж хүүхдийг хүчирхийллээс хамгаална.

Дэлгэр сумын ЕБС-ийн 3б ангийн сурагч
Б. Бадамдарь



**Б.БАДАМДАРЬ**
Дэлгэр сум, 3б анги

“ХҮҮХЭД ХАМГААЛАЛ МИНИЙ НҮДЭЭР”
СЭДЭВТ ЭССЭ БИЧЛЭГИЙН

# ШАГНАЛТ БАЙРНЫ БҮТЭЭЛҮҮД

10-13 НАСНЫ АНГИЛАЛ



# Хүүхэд хамгаалал миний нүдээр

Хүүхдийн инээмсэглэл бол дэлхий ертөнцийн хамгийн тунгалаг гэрэл. Тэр инээдний цаана хайрлагдсан мэдрэмж, хамгаалагдсан итгэл, аз жаргалын гэрэл гэгээ шингэсэн байдаг. Миний нүдээр хүүхэд хамгаалал гэдэг бол зөвхөн хууль дүрэм, заалт төдий зүйл биш. Харин хүн бүрийн зүрх сэтгэлийн үүрэг юм. Би хүүхэд хамгааллыг хавардаа нээж цагаан дэлбээ тосдог. Тэр цэцэг нарны илчийг хүсэн шиг хүүхэд бид ч дулаан хайрыг хүсдэг. Салхи шуурганаас хамгаалж байж л тэр цэцэг бүрэн дэлгэрдэг шиг хүүхэд ч зөвхөн хайр хамгаалал дор мөрөөдлөө дэлгэрүүлж чадна.

Хүүхэд хамгаалал гэдэг бол гэр бүлээс эхэлдэг. Эцэг эхийн хайр бол хамгааллын анхны бамбай. Дараа нь багшийн заавар, найзын тусламж, нийгмийн халамж нийлж, хүүхдийн тайван хүрээлсэн дугуй хамгаалал бий болдог. Тэр хүрээний хаана ч цоорхой гарвал хүүхдийн итгэл ганхана. Тиймээс хүүхэд хамгаалал бол хамтын хариуцлага, нийтээрээ барьж босгосон гэрэлт цамхаг юм. Миний нүдээр хүүхэд хамгаалал нь зөвхөн аюулаас хол байлгах биш, харин мөрөөдлийг нь дэмжих явдал. Хүүхэд бүрийн мөрөөдөл бол хүслийн жигүүртэй шувуу. Хэрвээ бид тэднийг хамгаалж, итгэл өгвөл тэр шувуу тэнгэрт дүүлнэ. Харин хамгаалалтгүй орхивол тэр мөрөөдөл хугарсан далавчтай болж, газар дээр унана. Тиймээс хүүхэд хамгаалал бол мөрөөдлийг дэмжих урлаг, ирээдүйг бүтээх хамгийн ариун үүрэг. Өнөөдрийн хүүхэд бол маргаашийн эх орон. Тэдний нүдэнд шингэсэн гэрэл бол бидний ирээдүйн дүр зураг.

Хэрвээ бид өнөөдөр хүүхдийг хайрлаж хамгаалбал, маргааш бид

аз жаргалтай нийгэмд амьдарна. Харин өнөөдөр хайхрамжгүй орхивол маргааш харамсалтай [illegible]. Тиймээс миний нүдээр хүүхэд хамгаалалт гэдэг бол найдвар, гэрэл, ирээдүй. Энэ бол бидний зайлшгүй үүрэг, зүрхний дуу хоолой. Хүн төрөлхтний хамгийн ариун тангараг юм. Хүүхдийн шийдвэрлэлд нэг ч гэсэн асуудал тохиолдох тэ бүхэн бүгд хамгаалалт нь байх ёстой. Учир нь хүүхдийг хамгаална гэдэг бол зөвхөн нэг хүний биш, харин бүх дэлхийн хамгаалах үүрэг хэрэг. Хүүхэд бидний хайр халамжаараа ургаж томрох хайрлах нь хүүхэд багачуудын хайр халамж бидний ургаж нисэх далавч болдог. Хүүхэд багачуудыг мөн харгалзан хянаж маш сайн тавьж харж хамгаалах нь энэ нийгмийн амьдралд бүр бүх ирээдүй хүн амын оршихуй юм. Хүүхдүүдийн санаа хүслийг ойлгох сэтгэлгүй бол хамгаалалт дутуу. Ирээдүйн эздүүдийн тэрхүү мөрөөдлийг дэмжиж, итгэлийг бадраах нь бидний хийгдэх ирээдүйг бүтээх үйл хэрэг. Хүүхдийн нүдний гэрэл бүдгэрэх ёсгүй, харин улам тод гэрэлтэх учиртай. Тэднийг хайхрамжгүй нэг алхам бидний ирээдүйн олон мөрөөдлийг үгүй хийж чадна. Харин тэднийг хамгаалсан нэг алхам мөрөөдлийг тэнгэрт дүүлгэх чадна. Тэднийгээ хүүхэд багачуудаа хайрлаж тэтгээрэй.

Хүүхэд хамгаалалт миний нүдээр...

Хөхморьт сумын 8=Б ангийн
сурагч А. Санчирмаа

I БАЙР

**А.САНЧИРМАА**
Хөхморьт, 8б анги

## Хүүхэд хамгаалал миний нүдээр

Хүүхэд бүр эрхэм, онцгой хамгаалалттай байх ёстой гэж би боддог. Бид бүгд хүүхэд байсан одоо ч хүүхэд хэвээрээ. Томчуудын нүдэнд бид жижигхэн, бас гэнэн, ийм хэрэгцээт мэдлэггүй ч үзэгдэх бидэнд өөрийн гэсэн итгэл, бодол, хүсэл мөрөөдөл бий. Тиймээс миний бодлоор хүүхэд хамгаалал гэдэг бол хүүхэд бүрийн эрхийг адилтгаж тэдний аюулгүй хайраар дүүрэн орчинд өсөх боломжийг бүрдүүлэх явдал юм.

Миний эргэн тойронд сайн аав ээжтэй болгонтой, аз жаргалтай орчинд амьдарч байгаа хүүхдүүд олон байдаг. Гэвч зарим хүүхэд гэр бүлийн хүнд нөхцөлд амьдарч, зарим нь сургууль дээр дээрэлхүүлж ганцаардаж байдаг. Зарим нь бүр гудамжинд, хайр халамжгүй амьдарч байгааг би зурагтаар, сошиалаар хараад үнэхээр өрөвддөг. Ийм хүүхдүүдэд туслах, хамгаалах нь бид бүхний үүрэг гэж боддог.

Хүүхэд хамгаалал гэдэг нь зөвхөн хүүхдийг зодохгүй байх тухай биш. Энэ нь тэднийг сонсох, ойлгох, дэмжих хэрэгцээг нь анзаарах гэсэн олон талтай зүйл. Хүүхэд бүр тоглож наадах, сурч боловсрох, сэтгэл санааны хувьд тайван байх эрхтэй. Харамсалтай нь

зарим томчууд "жижиг хүн" гэдэг ч ойлгодог, хэвч хүүхдийн "хичээлээ л сайн хий" гэдэг бөгөөд сэтгэл санааны хэрэгцээ нь орхигдог. Гэвч бидний сонирхол, дэмжлэг, ярилцлага ч бас хамгаалалт байдаг.

Сургууль дээр ч хүүхэд хамгаалал хэрэгтэй. Зарим хэсэг олон дүүг гадуурхаж, дээрэлхэж байдаг. Хэрэв бид нэг нэгнээ ойлгож, тусалж урам өгөх харилцаатай байвал хүүхэд бүр сургуульдаа дуртай явах болно. Би өөрөө ангийнхаа дээрэлхүүлсэн хүүхдийг хүргэж хамгаалах нь хамгааллын хамгийн энгийн жишээ гэж боддог. Учир нь, бага нас хүүхдүүдтэй шууд өдөр байж, тэдний дуу хоолойг сонсож байх нь ч хамгаалал юм. Хүүхэд сэтгэлээ нээлттэй илэрхийлж, санаа зовсон зүйлээ ярьж чаддаг бол ямар сайхан бэ? Хайрлагдаж итгэл хүлээж өссөн хүүхэд хэзээ ч муу замаар явахгүй.

Хүүхэд хамгаалал бол зөвхөн нэг хүний үүрэг биш. Энэ бол хүн бүрийн сэтгэл зүрхнээс гарч ирэх ёстой хайр, анхаарал, хүндлэл юм. Хүүхэд хамгаалалт сайн байвал бид бүгд аз жаргалтай, эрүүл, ухаалаг иргэдийг бэлтгэн гаргана.

Говь-Алтай аймгийн ерөнхий боловсролын

лаборатори I сургуулийн 7е ангийн

сурагч Б.Баянсар

**Хүүхэд хамгаалал миний нүдээр**

Би хүүхэд. Миний нүдээр ертөнц хамгийн тод өнгөтэй, хамгийн дулаан инээдтэй, бас хамгийн эмзэг нулимстай. Хүүхэд гэдэг бол ирээдүйн эзэн, мөрөөдлийн үргэлжлэл. Гэвч хүүхдийн нүдэн дэх гэгээ алдагдах мөчүүд олон байдаг. Тэр үед бидэнд хамгаалалт хамгийн их хэрэгтэй. Хүүхэд хамгаалал гэдэг бол зөвхөн хүчирхийллээс хамгаалах тухай биш. Энэ бол хүүхдийн сэтгэлийг хайрлах, саналыг сонсох, мөрөөдлийг дэмжих тухай ойлголт. Биднийг зөвхөн сургуульд сургаж, хувцаслаж, хооллохоос гадна сэтгэл санаагаар тайван, аз жаргалтай өсгөх нь хамгаалалт гэж би боддог. Өнөөдөр бидний дунд өөрийнхөөрөө байж чаддаггүй, айдас дунд амьдардаг хүүхдүүд бий. Тэдний нүүрэнд инээмсэглэл үгүй болж, хүсэл мөрөөдөл нь хязгаарлагдаж эхэлдэг. Тиймээс хүүхэд хамгаалал бол томчуудын үүрэг биш, тухайн нийгмийн үнэт зүйл төдийгүй бүх хүмүүсийн зүрх сэтгэлд орших ёстой юм.

Миний нүдээр хүүхэд хамгаалал бол:

- Сургууль дээр хүүхдийг инээмсэглэлээр угтах багшийн дулаан харц
- Гэртээ аюулгүй, хайртай хүнтэйгээ байх итгэл
- Өөрийн санал бодлоо чөлөөтэй хэлэх эрх чөлөө
- Гудамжинд тоглож явахдаа айх айдасгүй байх тайван орчин
- Мөрөөдлөө хэрэгжүүлэхэд томчуудын дэмжлэг, итгэл юм.

Хүүхэд хамгаалал зөвхөн өнөөдөрт хэрэгтэй биш, ирээдүйг бүтээх хамгийн чухал хөрөнгө оруулалт. Аз жаргалтай хүүхэд өсөж байж, аз жаргалтай нийгэм бий болдог. Хүүхдүүд бидний хүсдэг зүйл бол бүх хүүхэд тэгш эрхтэй, инээмсэглэл дүүрэн амьдрах тэр л нийгэм. Миний мөрөөдөл бол хэзээ нэгэн өдөр "хүүхдийн эрх зөрчигдөж байна" гэсэн мэдээ гарахгүй, харин "хүүхдийн мөрөөдөл биелж байна" гэсэн мэдээ өдөр бүр сонсогддог улс орон байгаасай. Ийм нийгмийг бүтээхийн тулд бидний нүдээр харж, чихээр сонсож, зүрхээрээ ойлгох хүн бүрийн оролцоо чухал.

Хүүхэд хамгаалал миний нүдээр бол – хайр, итгэл, ирээдүй.

III
БАЙР

**Б.БАЯНСАР**
1-р сургууль, 7е анги

# ХҮҮХЭД ХАМГААЛАЛ МИНИИ НҮДЭЭР ЭССЭ

Жаргалан сумын ЕБС-ийн 8а ангийн сурагч Б. Дэмүүл миний бие 13 настай. Хүүхэд хамгаалал гэсэн сэдэв маш их өргөн хүрээтэй ойлголт юм. Миний бодлоор нийгмийн үнэт баялаг бол хүүхэд гэж боддог. Хүүхэд бол гэр бүлийн баяр баясгалан, улс орны ирээдүй, энэ нийгмийн үнэт баялаг юм. Цахим орчин хөгжсөнөөр бид сайн муу мэдээллийг зурагт бас цахим орчноос авч байна 5-р ангид байхад багш маань "Хүүхэд хамгаалал" гэдэг үгийг зааж өгсөн. Тэр нь өвдөхгүй, айхгүй,зодуулахгүй, сайн хүмүүжих орчинд байх ёстой гэсэн үг гэж хэлж байсан. Би өөрөө ч гэсэн хэн нэгэн намайг айлгавал эсэргүүцэж, том хүмүүст хэлж чадна. Хүүхэд хамгаалагдах эрхтэй гэдгээ мэддэг болсон. Зарим хүүхдийг ээж, аав гэр бүл нь үл тоодог үг үйлдлээр доромжилдог, мөн хоолгүй хонодог, хичээл сургуульд явуулдаггүй гэх мэт зүйлс нүдэнд минь тодоос тод харагдах юм.Би ийм хүүхдүүдийг бодохоор их гунигладаг. Хүүхэд бүр гэртээ дулаахан ортой, аав ээжийн хайртай, аюулгүй газар амьдрах ёстой. Хэн нэгэн уурлаж загнах,эсвэл хүч хэрэглэж байвал тэр хүүхэд хамгаалуулах хэрэгтэй. Хүүхэд хамгаалал гэдэг нь биднийг зөвхөн хүчирхийллээс хамгаалах гэдэг ойлголт биш гэр бүлийн халуун дулаан гэгээ цацарсан орчинд өсгөх, хайр халамжтай,бидний эрхийг хүндэтгэх, сонсох, хөгжих боломжоор хангах явдал гэж ойлгодог. Хүүхэд биднийг хамгаалах гэдэг нь бидний аюулгүй байдлыг хангаж, бие махбод, сэтгэл санаа нийгмийн харилцаанд ямар нэгэн дарамт хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэхийг хэлэх байхаа. Гэхдээ харамсалтай гол зурам хэргүүд энд тэнд маш ихээр гарч байна. Зарим хүүхэд гэр бүл, сургууль, найз нөхөд , олон нийтийн дунд үл хайхрах, доромжлох, үгээр болон бие махбодын хүчирхийлэлд маш их өртөж байна. Энэ нь тэдний өөртөө итгэх итгэл цаашдын ирээдүйд нь сөргөөр нөлөөлнө. Хүүхэд хамгаалал гэдэг нь зөвхөн төрийн байгууллага аль эсвэл сургуулийн багш нийгмийн ажилтнуудын хийх ёстой ажил биш юм. Миний бодлоор хүн бүр хүүхдийг ХАМГААЛАГЧ байж чадна. Иймд хүн бүрийн оролцох оролцоо чухал юм. Жишээ татах юм бол Гудамжаар явж байхад чинь хүүхэд уйлж байхад зүгээр өнгөрөөд явах биш ойртож очоод яагаад уйлж буйг асуух ийм л энгийн байж чадвал хүчирхийллийг багасгах боломжтой юм. Сургуулийн болон анги нийтийн дунд гадуурхагдаж байгаа хүүхдэд дэмжлэг үзүүлэх гэх мэт хүн бүрийн оролцоо чухал юм. Мөн хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэх нь хамгийн чухал юм. Томчууд харсан ч хараагүй мэт явж буй нь хамгийн аймшигтай зүйл. Томчууд бол чи чадахгүй болохгүй гэдэг үгсийг маш их хэрэглэдэг. Үг нь сонсоод, ойлгоод бидэнд итгэлийн гэрэл асаагаад өгвөл хүүхэд бүр л өөрийн гэсэн ертөнцтэй, зорих зорилготой, хүсэл тэмүүлэлтэй байдаг. Түүнийг нь дэмжээд сонсоод урам зориг өгвөл бид ирээдүйд сайн хүн болж төлөвших байхаа. Тиймээс хүүхэд храмгаалал гэдэг бол миний нүдээр зөвхөн хамгаалах биш биднийг хайрлах, дэмжих эрхийг нь хүндэтгэх, сурч боловсрох орчинг нь бүрдүүлэх олон талт үйл явц гэж ойлгож байна.

IV БАЙР

**Б.ДЭМҮҮЛ**
Жаргалан, 8а анги

“ХҮҮХЭД ХАМГААЛАЛ МИНИЙ НҮДЭЭР”
СЭДЭВТ ЭСЭЭ БИЧЛЭГИЙН

# БУСАД БҮТЭЭЛҮҮД

**10-13 НАСНЫ АНГИЛАЛ**



## Хүүхэд хамгаалал миний нүдээр

Би хүүхэд гэдгээрээ их баяртай байдаг. Гэхдээ хүүхэд байна гэдэг дандаа тоглож инээж, зөвхөн аз жаргалтай байна гэсэн үг биш. Заримдаа бидэд асуудал тулгардаг.

Тэр үед биднийг хамгаалах зүйл маш хэрэгтэй. Энэ бол хүүхэд хамгаалал гэж боддог.

Манай байрны хүүхдүүд дунд заримдаа бие биенээ дээрэлхдэг тохиолдол байдаг.

Жаахан хүүхдүүдийн тоглоомыг булаах, муухай үгээр доромжлох эсвэл тоглоомондоо оруулахгүй байх үе гардаг.

Тэгэхээр тэр хүүхэд их гунигтай болдог, өөрийгөө муу хүн юм шиг бодож эхэлдэг.

Би үүнийг хараад "Бид яагаад бие биедээ ингэж муухай ханддаг юм бол?" гэж боддог.

Хүүхэд хамгаалал гэдэг нь ийм дээрэлхэлтийг зогсоож, биднийг хамгаалах хэрэгтэй гэж боддог.

Мөн бид өдөр болгон сургуульдаа явахдаа машин замаар гардаг. Заримдаа машин ихтэй үед зам гарахад үнэхээр хэцүү байдаг. Жолооч нар хурдан яваад биднийг тоохгүй өнгөрөх үе ч бий. Тэр үед үнэхээр аймаар санагддаг. Зам дээр хүүхэд гарч байвал жолооч нар заавал удаан явж, хүүхдүүдийг аюулгүй гаргаж өгөх ёстой гэж боддог.

Эдгээр асуудлыг шийдэхийн тулд би дараах зүйлийг чухал гэж боддог.
Нэгд, бид хүүхдүүд хоорондоо дээрэлхэлгүйгээр, харин тусалж дэмжиж, эвтэй байх хэрэгтэй.

Хоёрт, багш нар, ээж аавууд бидэнд тусалж, дээрэлхэлт гарвал даруй ярилцаж шийдэх хэрэгтэй.

Гуравт, замын гарц болон дохиог сайжруулж, жолооч нар хүүхдэд анхааралтай байх ёстой.

Хүүхэд хамгаалал гэдэг нь зөвхөн муу хүмүүсээс хамгаалах биш, харин бие биенээ хайрлаж, бидний орчныг аюулгүй болгохын төлөө байдаг гэж боддог.

Хэрэв бүгдээрээ ингэж чадвал бид айхгүйгээр тоглож, сурч, аз жаргалтай байж чадна.

Мөн энэ эссений хүрээнд Замын цагдаатай хамтран аян зохион байгуулах хэрэгтэй.

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын

I сургуулийн сурагч

5а ангийн С.Мөнхбаяр

**С.МӨНХБАЯР**
1-р сургууль, 5а анги

# ХҮҮХЭД ХАМГААЛАЛ МИНИЙ НҮДЭЭР

Намайг О.Багахүү гэдэг. 13 настай. Би Говь-Алтай аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 8-р ангид сурдаг. Манай нутагт хүүхдүүд бие биенээ сайн мэддэг, ах дүүс шиг дотно байдаг. Сум жижигхэн ч гэсэн бидний хүүхэд насыг аз жаргалтай, дулаан болгож өгдөг олон сайхан зүйл бий. Гэхдээ миний бодлоор хүүхэд бүрийн аз жаргал гэдэг нь зөвхөн тоглож наадах биш, харин хайрлуулж, бусдад ойлгогдож, аюулгүй орчинд өөрийгөө үнэ цэнтэй гэж мэдрэхэд оршдог. Миний бодлоор хүүхэд хамгаалал гэдэг нь зөвхөн томчуудын ярих хууль дүрэм биш, харин бидний өдөр тутмын амьдралд хамгийн их хэрэгтэй зүйл. Хүүхэд бүр аюулгүй, хайрлагдсан, ойлгогдсон орчинд өсөх эрхтэй. Хүн бүр биднийг хамгаалж, дэмжиж байж л бид ирээдүйд итгэлтэй, зорилготой хүн болж төлөвшинө. Тиймээс хүүхэд хамгааллыг би өөрийн нүдээрээ зөвхөн том асуудал бус, бидний тоглож наадах, сурч хөгжих, мөрөөдлөө биелүүлэх нөхцөл гэж хардаг.

Хүүхэд хамгаалал гэдэгт хамгийн түрүүнд эцэг эх, багшийн халамж санаанд ордог. Ээж, аав минь намайг өвдөхөд санаа тавьж, сайн сайхныг хүсэж, хайр халамжаар дулаацуулахад би өөрийгөө хамгаалагдсан гэж мэдэрдэг. Багш нар маань зөвхөн хичээл заахаас гадна амьдралын зөвлөгөө өгч, зөв буруут ялгахад тусалдаг. Энэ бүхэнд хүүхдийн амар тайван, аз жаргалын үндэс байдаг гэж би боддог. Гэхдээ заримдаа томчууд өөрсдөө хүүхдийн сэтгэлийг шархлуулчихдаг. Жишээлбэл: Эцэг эх хүүхдээ найзтай нь харьцуулж, "Чи тэдэн шиг биш" гэж голох тохиолдол бий. Энэ нь хүүхдийг маш ихээр сэтгэлээр унагаж, өөртөө итгэлгүй, дотогшоо болгохоос гадна харьцуулагдсан хүүхэддээ дургүй болох хөндийрөх цаашлаад дээрэлхэлт эхэлдэг. Үнэндээ хүүхэд бүр өөрийн гэсэн авьяас, давуу талтай. Харьцуулахын оронд урам өгөх, дэмжих нь хүүхдийг хамгаалж буй хамгийн энгийн бөгөөд зөв зам гэж боддог. Найзуудын дунд ч хамгаалал хэрэгтэй. Заримдаа шоолох, дээрэлхэх, үл тоох зүйл тохиолддог. Тийм үед зүгээр дуугүй өнгөрөх нь асуудлыг улам томруулдаг. Харин бид бие биенээ дэмжиж, тусалж, хүнд хэцүү үед найзынхаа дэргэд байж чадвал энэ бол жинхэнэ хүүхэд хамгаалал юм.

Хүүхэд хамгаалал гэдэгт хамгийн түрүүнд эцэг эх, багшийн халамж санаанд ордог. Ээж, аав минь намайг өвдөхөд санаа тавьж, сайн сайхныг хүсэж, хайр халамжаар дулаацуулахад би өөрийгөө хамгаалагдсан гэж мэдэрдэг. Багш нар маань зөвхөн хичээл заахаас гадна амьдралын зөвлөгөө өгч, зөв буруут ялгахад тусалдаг. Энэ бүхэнд хүүхдийн амар тайван, аз жаргалын үндэс байдаг гэж би боддог. Гэхдээ заримдаа томчууд өөрсдөө хүүхдийн сэтгэлийг шархлуулчихдаг. Жишээлбэл, эцэг эх хүүхдээ найзтай нь харьцуулж "Чи тэдэн шиг биш" гэж хэлэх нь хүүхдэд итгэл алдрал авчирч, дотогшоо болгодог. Үүнээс гадна, харьцуулагдсан хүүхдүүдийн хооронд үл ойлголцол, дургүйцэл төрж, цаашлаад дээрэлхэлт бий болох аюултай. Үнэндээ хүүхэд бүр өөрийн гэсэн онцлог, авьяас, чадвартай. Томчууд хүүхдээ бусадтай харьцуулахын оронд тэдний давуу талыг олж харж, урам өгч, сэтгэлийг нь дэмжих нь хамгаалж буй хамгийн энгийн зөв арга зам гэж үзэж байна. Найзуудын дунд ч хамгаалал онцгой хэрэгтэй. Заримдаа шоолох, үл тоох, дээрэлхэх байдал гардаг. Тэр үед зүгээр хараад өнгөрөх нь асуудлыг улам даамжруулдаг. Харин бид нэгнийгээ өмгөөлж, урам өгч, найзынхаа дэргэд бат зогсож чадвал энэ бол жинхэнэ хамгаалал юм. Бид нэгнээ хамгаалсаар зөвхөн тухайн найздаа туслаад зогсохгүй, бусдад ч үлгэр жишээ болж чадна. Түүнээс гадна, хүүхэд хамгаалал зөвхөн гэр бүл, сургуулиар хязгаарлагдахгүй. Сум, нутаг орон, бүр цаашлаад нийгэм бүхэлдээ хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах ёстой. Хүүхдүүдэд аюулгүй хүртээмжтэй тоглох талбай, тайван суугаад суралцах орчин, өөрийнгөө олон талаас хөгжүүлэх боломж бүрдсэнээр бид илүү итгэлтэй, аз жаргалтай өснө.

Хүүхэд хамгаалал гэдэг нь зөвхөн томчуудын хийх ажил биш, бид өөрсдөө ч нэгнээ хамгаалж, ойлгож, түшиж байх хэрэгтэй. Миний бодлоор хүүхэд хамгаалал гэдэг нь зөвхөн биеийн аюулгүй байдал биш, харин сэтгэл санааны амар тайван орчин юм. Хайрлуулж байгаагаа мэдрэх, өөрийгөө үнэ цэнтэй хүн гэж бодох, мөрөөдлөө дагах итгэлтэй байх нь хамгийн том хамгаалалт. Хүүхэд бүр инээж, мөрөөдлөө биелүүлэх эрхтэй. Тиймээс хүүхэд хамгаалал миний нүдээр бол эцэг эхийн халамж, багшийн зөвлөгөө, найзуудын дэмжлэг, өөрсдийнхөө зүрх сэтгэлийг хамгаалах ухаан юм. Ирээдүйд бид том болоод ямар ч мэргэжилтэй, хаана ч амьдарсан бай, хүнлэг, бусдыг хайрлаж хамгаалдаг сэтгэлтэй байх нь хамгийн чухал гэж боддог. Хүүхэд хамгаалал гэдэг бол зөвхөн өнөөдөр бус, бидний ирээдүйн гэрэлт маргаашийн баталгаа юм. Тиймээс хүүхэд бүр хамгаалагдсан, итгэлтэй, аз жаргалтай өсвөл Монголын маань ирээдүй гэрэлтэй, дэлхий маань дулаан уур амьсгалтай байх болно. Хүүхдийн инээмсэглэл гэдэг нь хүн бүрийн зүрхэнд нар шиг гэрэлтдэг учраас түүнийг хамгаалах нь бидний хамгийн том үүрэг юм.

Хэрвээ хүүхэд бүр хайрлагдаж, хамгаалагдаж өсвөл хорвоо дэлхий маань илүү сайхан болно гэдэгт би итгэдэг.

Эссэ бичсэн

Цээл сум 8б ангийн сурагч: О.Багахүү

**О.БАГАХҮҮ**
Цээл сум, 8б анги

# Хүүхэд хамгаалалт - Миний нүдээр

Хүүхэд бол гэрэлт ирээдүй, эхийн гэгээ хайрын маргааш. Энэ дэлхий дээрх хамгийн ариун, хамгийн үнэтэй баялаг бол хүүхэд. Гэвч энэ үнэт эрдэнэ өдөр бүр хүчирхийлэл, хайхрамжгүй байдал, ядуурал, боловсролгүй байдалд өртөж цэвэр ариун сэтгэл нь шархтаж, ирээдүй нь бүрхэгдэж байдаг. Харин миний нүдээр хүүхэд хамгаалах гэдэг нь зөвхөн томчуудын үүрэг биш бид бүгдийн хамтын хариуцлага юм.

Хүүхэд хамгаалах гэдэг нь тэдний эрх ашгийг хамгаалж, хүчирхийллээс ангид байлгаж сурч хөгжих, аз жаргалтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэхийг хэлнэ.

Гэхдээ энэ үг зүгээр л хууль дүрмээр хязгаарлагдах ёсгүй, харин хүн бүрийн сэтгэл зүрхэнд, үйлдэлд оршиx ёстой гэж би боддог.

Жишээлбэл манай хөрш айлын Т гэх бяцхан охин өдөр бүр уйлж, сургуульдаа явах дургүй байдаг байлаа. Гэхдээ би учрыг нь ойлгодоггүй байсан ч нэг өдөр Т гэх нь манай ээжтэй ярилцаж, түүнийг гэртээ хүчирхийлэлд өртдөг тухай хэлсэн.

Энэ мэдээг сонсоод зүрх минь шимшрэж өвдсөн.

Бол миний насны охин. Энэ нууцыг бас энд ч хэлээгүй. Тэр ч бас толгой цохиж, мөрөөрөө доо хүрэх эрхтэй шүү дээ. Харин бид түүнийг анзаарахгүй өнгөрч байжээ. Түүнээ, хайш, би, хүүхэд,

Түүнээ хайш би хүүхэд бүр аз жаргалтай, аюул-гүй орчинд өсөх ёстой гэдгийг гүнзгий ойлгосон. Хүүхэд хамгаалах нь зөвхөн хуулийн байгууллага, багш, эцэг эхийн үүрэг биш. Жирийн иргэн бүр, сурагч ч хүртэл өөрийн орон зайд хэн нэгэнд анхаарал хандуулж туслах боломжтой.

Миний бодлоор хүүхэд хамгаалах хамгийн эхний алхам бол сонсох. Хүүхдийн дуу хоолойг сонсох тэдэнд итгэл өгч сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх нь маш чухал. Заримдаа нэг сайхан, нэг халуун дулаан харц найдв-рын гэрэл нь болдог. Бас тэднийг ялгаварлах, гадуурхахгүй, бусдын адил эрх тэгш харьцах нь хамгаалалтын нэг хэлбэр юм.

Нийгэмд маш олон сайн жишээ ч байдаг.
- Зарим сургуулиуд "Хүүхэд хамгаалах өдөр" зохион байгуулж хүүхдүүдийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлэх боломж бий болгож дэмжих уур амьсгалыг бүрдүүлдэг. Зарим сум багт "Хүүхдийн элч" ажиллуулж, тэдний эрх ашгийг хамгаалж буй нь тун сайшаалтай.

Хүүхэд хамгаалалт бол ганц өдрийн сэдэв биш.

бол өдөр бүрийн зорилго, өдөр бүрийн үйлдэл. Миний хувьд би өөрөөсөө насаар ах-заараа хүндлэх, дүүгээ хайрлах, хэн нэгэнд хэрэгтэй үедээ туслах, "чи үнэ цэнэтэй шүү" гэж хэлж чадах хүн байхыг хүсдэг. Учир нь бидний хийсэн өчүүхэн ч гэсэн үйлдэл хэн нэгэнд гэрэл болдгийг мэднэ.

Эцэст нь хэлэхэд хүүхдийг хамгаална гэдэг нь тэдний эрхийг мөрөөдлийг, ирээдүйг хамгаалж буй хэрэг юм. Би "бүх хүүхэд хайрлагдаж өсөөсэй" гэж хүсдэг. Би сурч хөгжих эрхээ эдлээсэй, хүчирхийллээс ангид байж аз жаргалтай ирээдүйг угтаасай гэж, зүрхнээсээ хүсдэг.

Говь-Алтай аймаг Төгрөг сум 7б ангийн сурагч А. Намуунтуул.

**А.НАМУУНТУУЛ**
Төгрөг сум, 7б анги

Хүүхэд хамгаалал.
миний нүдээр
Эссэ

Хөгжил хараалалаас сургууль орох хөндлөн зам дээр, дээр явган хүний гарц байдаггүй. Үүний улмаас зам гарах хэцүү байдаг. Манай сургуулийн ойр орчим машин машин, зогсоолгүй учраас маш эмх замбараагүй байдаг Хүүдэ, Хүүхэд бидэнд хичээл тарах, хичээл орох үед их аюултай байдаг. Манай гэрийн хажуудах тоглоомын талбайн хашааны төмөр торнуудана эвдэрсэд хүүхэд бидний гэмтээх, тоглоомууд нь эвдэрсэн учраас зөвхөн бөмбөг л тоглодог. Үдэш гадуур явахад гэ, гудамжны гэрэл байхгүй учир урдах зам тод харагддаггүй болохоор муухай байдаг юм. Хүүхэд бидний хайрлан хамгаалдаг хүмүүс олон байдаг ч бидний тоглох зарим зүйлсийг анзаарахгүй өнгөрөөдөг.

Хүүдүүдээ ах эгч бидэнд хайртай хүмүүсийн хийж өгсөн тоглоом болон бусад зүйлсийг гамтай хэрэглэж суралцгаая гэж бусад бүх хүүхдүүддээ уриалж байна.

Эссэ бичсэн: 1-р сургуулийн 5в ангийн сурагч: Б.Гүнбилэг

**Б.ГҮНБИЛЭГ**
1-р сургууль, 5в анги

# Хүүхэд хамгаалал миний нүдээр

Хүүхэд гэдэг бол гэр бүлийн аз жаргал улс орны ирээдүй дэлхийн баялаг юм. Тиймээс хүүхдийн эрх аюулгүй байдлыг хамгаалах асуудал зөвхөн гэр бүл төдийгүй нийгмийн нийт иргэдийн үүрэг гэж би боддог. Миний нүдээр хүүхэд хамгаалал гэдэг нь зөвхөн хүчирхийллээс хамгаалах тухай ойлголт биш харин хүүхэд бүр эрүүл, аюулгүй, хайр энэрэл дунд өсөж мөрөөдлөө биелүүлэх боломжтой орчныг бүрдүүлэх юм. Өнөөдөр олон хүүхэд сургуульд сурч тоглож мөрөөдлөө бичиж суугаа ч зарим нь хүчирхийлэл үл хайхрах ядууралд нэрвэгдэж эрхээ эдэлж чадалгүй амьдарч байна. Энэ бүхэн миний сэтгэлийг өвтгөдөг. Би хүүхэд хамгааллыг бодоход хамгийн түрүүнд хайр халамж санаанд ордог.

Хайрлагдсан хүүхэд өөрийгөө үнэтэй нэгэн гэдэг ойлголт итгэлтэй хүн болж төлөвшинө. Харин аюулгүй орчинд тухгүй байна.

Миний бодлоор хүүхэд хамгаалалд дараах зүйл чухал:

1. Эцэг эхийн үүрэг: хүүхдээ зөв хүмүүжүүлж хамгаалж сурч дэмжих боломж олгох.
2. Сургууль, багш нарын дэмжлэг: хүүхдэд зөв мэдлэг олгохоос гадна аюулгүй, итгэл төрүүлэх орчин бүрдүүлэх

Нийгмийн хариуцлага: Хүн бүр хүүхдийн эрхийг хүндэтгэж хүчирхийлэлд үл тэвчих хандлагатай байх.
Би өөрийн нүдээр хүүхэд хамгааллыг харахад энэ бол хууль дүрэм төдий биш, харин хүн бүрийн сэтгэл, хандлага хариуцлагын илэрхийлэл. Хэрэв бид хүүхэд бүрийг хамгаалж чадвал нийгмийн ирээдүй гэрэлтэй, хүчтэй, энэрэлтэй байна гэж итгэдэг.
Тиймээс би өөрөө эхлээд бусдад зөв нөлөө үзүүлэхийг хичээнэ. Найз нөхдөө хамгаалж буруу зүйл харвал дуугүй өнгөрөхгүй мэдэгдэж ээж аавдаа туслах, дүү нартаа хайрлах нь миний хийж чадах жижиг энгийн боловч үнэ цэнэтэй хувь нэмэр юм.
Эцэст нь энэхүү хүүхэд хамгаалал миний нүдээр гэж бол хүүхэд бүрийн инээмсэглэл мөрөөдөл итгэл найдварын баталгаа юм.
Бид бүгдээрээ хамтдаа хүүхдээ хамгаалж чадвал ирээдүй минь гэрэл гэгээтэй байх болно.

...хариуцлага: Хэн бүр хүүхдийн эрхийг хүндэтгэх хүчирхийллийг үл тэвчих хандлагатай байх.

Би өөрийн нүдээр хүүхэд хамгаалахыг харахад энэ бол хүүхэд дуугүй тоглох биш, харин хүн бүрийн сэтгэл, хандлага хариуцлагын илэрхийлэл.

Хэрэв бид хүүхэд бүрийг хамгаалж чадвал нийгмийн ирээдүй гэрэлтэй, хүчтэй, жаргалтай болно гэж итгэдэг.

Тиймээс би өөрөө эхэлж бусдад эерэг нөлөө үзүүлэхийг хичээнэ. Найз нөхдөө хамгаалж буруу зүйл харвал дуугүй өнгөрөхгүй мэдэгдэх, ээж аавдаа туслах, дүү нараа хайрлах нь миний хийж чадах хамгийн энгийн боловч үнэ цэнтэй хувь нэмэр юм.

Эцэст нь хэлэхэд хүүхэд хамгаалал миний нүдээр гэдэг бол хүүхэд бүрийн инээмсэглэл маргаашийн итгэл найдварын баталгаа юм. Бид бүгдээрээ хамтдаа хүүхдээ хамгаалж чадвал ирээдүй минь гэрэлтэй байх болно.

Говь-Алтай

Хөхморьт

ЕБС 8б анги

Т. Тогтохшуур

**Т.ТОГТОХШҮҮР**
Хөхморьт сум, 8б анги

Хүүхэд хамгаалал бидний нүдээр

Бид эрсдэлгүй нийгэмд сэтгэл амар амьдармаар байна. Яагаад гэвэл 16 настай охины тухай хүн амины хэрэг. Энэхүү хэргийн алга болсон хэрэг гээд энэ мэт бүр ийм хэргийн тоо нэмэгдсээр байна. Шүүх прокурорууд нь хахууль авах тухай нийгмийн шуламсанд нийт мэдээд л байдаг. 16 настай охины хэрэг гэхэд ашуургын 9 алгаалттай. Хүний амь насанд хүрсэн нь батлагдаад байхад хахууль авч байгаад алгасагдсан хүн бас хэчнээн юм. Мөн бэлгийн хүчирхийлэл, хүчингийн хэргээр маш олон хүүхэд сэтгэл санаа бие махбодоороо хохирч байна. Хэдий бид гэмт хэргийг болгоож чадахгүй ч бид шударга шүүх прокурор, хэргийг оноосон шийтгэлийг зөв зохистой хууль ёсны дагуу өгөх. Мөн хугацаанаас нь өмнө суллахгүй байх хэрэгтэй.

Хүүхэд их хөдөлгөөнтэй юман дээр үсэрч харайна унаж бэртэнэ. Энэ бүхнийг бүрдүүлэн бидэнд аюулгүй тоглоомын талбай хэрэгтэй. Гэр хороололд нэг тоглоомын талбай бариад өгөөч. Бидэнд 1 шороон талбай дээр нэг саравч савлуур барина. Тэр нь цаг хугацааны явцаар элэгдэж хугарна. Тэр эвдэрсэн тоглоом дээр хүүхдүүд очиж тоглож гэмтэнэ. Энэ бүхний шийдэж эвдэрсэн хугарсан тоглоомыг засч шороон талбайн оронд зүлэгжүүлэлттэй болох хэрэгтэй. Хэдий төсөв их орох ч хүүхдүүд ямар их баярлах цагийг хөгжилтэй өнгөрөөж инээдэн тоглохыг нь бодоод үзээрэй. Хүүхдүүд бид нар ч нийгмээ өөрчилж чадна. Тоглоомын талбайн тоглоомуудаа эвдэлж хэмжээгүй бусадтай эвтэй харьцах биенийгээ ялгаварлахгүй, биенийгээ хүндэлж бусдадаа. Муухай үг хэлэхгүй жигдэн харьцах. Хүүхдүүд гэсэн нийгэм нэгдэж чадна бүгдээрээ нийгэмд сэтгэл амар амьдарцгаая. Бид сайхан нийгмийг бусдаас бус өөрсдөөсөө эхлэх хэрэгтэй.

**Б.БАЯРЦЭЦЭГ**
1-р сургууль, 8д анги

Хүүхдийн хамгаалал миний нүдээр

Хүүхэд бүхэн тэгш эрхтэй байх ёстой. Зарим нэг хүмүүс хүүхдийг гаднаас нь хараад дүгнэж байдаг. Жишээ нь: Хөгжлийн бэрхшээлтэй, аав ээжгүй, царай зүсээр нь муссан хувцсаар дүгнэж ялгаварлан гадуурхаж харьцдаг.

Хүүхдийн хамгаалал миний нүдээр хүүхэд бүхэнтэй ээлдэг, ялгаварлан харьцаагүй, хүчирхийлэлгүй, бусад харьцуулдаггүй, дээрэлхдэггүй, доромжилдоггүй байх нь миний хувьд хүүхдийн хамгаалал юм. Хүүхдийг ялгаварлан харьцаж, хүчирхийлж, нэгнийг нөгөөтэй харьцуулж, айдас төрүүлэхэд сэтгэл зүйд нь сөрөг нөлөө гарч нийгэмд идэвхгүй, сонирхолгүй өөртөө итгэх итгэлгүй, зориггүй, ичимхий, айх мэдрэмжтэй, чөлөөт бус сул дорой нэгэн болдог. Сул дорой болох нь ангийнхан жвэл цуглуулийнх нь хүүхдүүд дээрэлхэх магадлал өндөртэй. Мөн хүүхдийг загнаж зэмлэхдээ учир шалтгааныг нь асууж тайлбарлаж өгч хэрэгтэй харилцаж зөвөөр ойлгоцгоно. Хүүхдийг бусадтай харьцуулах нь сөрөг нөлөөтэй

Тэр тэрийг хийсэн биш бас хийнэ гэсэн бодол төрдөг. Бас хүүхдэд айх мэдрэмж нь юмсыг мэдэхгүй үед гарч ирдэг. Хамгийн их нөлөөтэй зүйл нь хүрээлэн буй орчноос үлгэр дууриал(ал) авч байдаг. Сургуулийн харилцаанд байж буй дээрэлхэл нь нэг нэгэнтэйгээ муудалцаж дээрэлхэл үүсдэг. Тиймээс нэг нэгэнтэйгээ эвтэй найртай байгаарай. Энэ үйл явдлын болохоос өмнө багш ажилтан нар эцэг, аавдаа хэлэх нь зөв шийдэл. Ер бусын асуудал үүсэх үед хамгийн түрүүнд хүүхэд рүүгээ дайрах биш өөрийгөө тайвшруулж уураа барьж, хүүхэдтэйгээ ярилцаж дахин хийж болохгүй гэдгийг сануулаад орхи.

Ийм асуудлыг тарихаа больж хүүхдээ хамгаалж хайрлаж, нандигнан байх ёстой.

- Хүүхдийн нүдэнд муу үйл зан авир бүү харуулаарай.

"Хүүхэд бол таны толь"

Г.Л.А-ийн Цээл сумын Е.Б.С-ийн
7б ангийн сурагч.

**С.САНЧИРМАА**
Цээл сум, 7б анги

Хүүхэд хамгаалал миний нүдээр

Хүүхэд бол хүн төрөлхтний ирээдүй, улс үндэстний хөгжлийн баталгаа юм. Хүүхэд биднийг шийваа хүчирхийлэл, аюул ослоос хамгаалахыг бид хүүхэд хамгаалал гэж ойлгодог. Өнөөдрийн хүүхэд маргаашийн ирээдүйг бүтээдэг учраас тэднийг хамгаалах, хайрлах, зөв хүн болгон төлөвшүүлэх нь гэр бүл, нийгэм, төрийн нэн тэргүүний зорилго байгаасай.

Юуны өмнө хүүхэд хамгааллын хамгийн эхний орчин бол гэр бүл юм. Аав, ээжийн халуун дулаан хайр халамжид өссөн хүүхэд өөрийгөө үнэ цэнтэй, хайрлагдсан гэдгийг мэдэрч өөртөө итгэлтэй, зөв төлөвшилтэй, бусдад хайртай хүн болж төлөвшдөг байх. Харин тэднийг үл хайхарч, хүч хэрэглэн загнаж, хайр халамжаар дутаах нь тэдний сэтгэл зүйд хүндээр нөлөөлж цаашдаа нийгэмд буруу хандлагатай, өөртөө итгэлгүй хүн болж өсөхөд нөлөөлдөг байх гэж би бодож байна. Тиймээс хүн бүр хүүхдийнхээ хүсэл сонирхлыг сонсож, тэднийг дэмжиж, урамшуулж, хамтдаа бүхнийг хийж, зөв хүн болж төлөвшихөд нь үлгэр дууриайлал үзүүлэх хэрэгтэй.

Мөн сургуулийн орчинд хүүхэд хамгаалал хамгийн чухал. Багш сурган хүмүүжүүлэгчид болон сургуульд ажилладаг хүн бүр хүүхдийн эрхийг хангаж, тэднийг ойлгож дэмждэг, тэднийг сонсдог байх үүрэгтэй. Багш маань бидэнд “Та бүхэн юу гэж бодож байна? , Хийж чадахгүй, эргэлзээтэй зүйл байвал багшдаа хэлээрэй., Надаас тусламж аваарай, багш нь үргэлж нээлттэй шүү.” гэх мэтээр бидэнд үргэлж дэмжиж туслахдаа бэлэн байгаагаа хэлдэг нь надад маш их таалагддаг. Сургуульд хүүхдүүд зөвхөн хичээл хийх бус эерэг харилцаа хандлага, хамт олонч байдал зэрэг чухал чадварыг эзэмшдэг гэж би боддог.

Монгол улсад хүүхдийн эрхийг хамгаалах хууль журам үйлчилж, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт зэргийн эсрэг олон ажил хийгдэж байгаад их баяртай байна. Цаашдаа хүүхэд бидний төлөө зөндөө гоё зүйл хийх байх аа гэж итгэж байна. Хүүхэд бүхний ирээдүй гэгээн цагаахан гэртэй сайхан байхыг ерөөе.

Оролцогч: Говь-Алтай аймгийн Дарив сумын ЕБС-ийн 5А ангийн сурагч

Батзаягийн Баасан-Од

**Б.БААСАН-ОД**
Дарив сум, 5а анги

## Хүүхэд хамгаалал миний нүдээр

Хүүхэд бол ертөнцийн хамгийн гэгээн инээсэглэл , маргаашийн гэрэл гэгээ билээ. Тэдний нүднээс мөрөөдөл гялалзаж, сэтгэлээс нь итгэл цацардаг. Гэвч тэрхүү гэрлийг бүдгэрүүлэх аюул хаа сайгүй оршдог учир хүүхэд хамгаалал бид бүгдийн нүд , сэтгэлд үргэлж байхаас аргагүй. Миний нүдээр хүүхэд хамгаалал гэдэг нь зөвхөн хүчирхийллээс ангид байлгах төдий бус , хүүхэд бүрийг хайрлан сонсох , урам хайрлах , төрөөдлөө биелүүлэх замыг нь гэрэлтүүлэх явдал юм. Гэр бүл бол хамгааллын эхний цайз. Эцэг эхийн энэрэл , халуун дулаан үг , зөв хүмүүжил нь хүүхдийн итгэлийг бэхжүүлнэ. Харин сургуульд багш нар мэдлэгийн үрийг суулгаад зогсохгүй , хүүхдийн зүрх сэтгэлийг хамгаалах үүрэгтэй. Нийгмийн зүгээс хүүхэд бүрийн эрхийг дээдэлж , аюулгүй орчинд өсөх нөхцөлийг бүрдүүлэх нь жинхэнэ хамгаалал юм. Хүүхэд хамгаалах үйлс зөвхөн байгууллагын биш , хүн бүрийн үүрэг гэдэгт би итгэдэг. Бид өөрийн орчин дахь бяцхан ертөнцийг хайрлан хамгаалж чадвал тэдний инээмсэглэл маргаашийн Монголын хамгийн тод гэрэл болно.

**Б.ЦОЛМОНТУЯА**
Хөх морьт сум, 6б анги

## Хүүхэд хамгааллын асуудал, шийдэл

Хүүхэд бол гэр бүл, нийгэм, улсын хамгийн үнэт баялаг бөгөөд тэдний аюулгүй байдал, аз жаргал бол бидний ирээдүйн баталгаа юм. Гэвч өнөөгийн нөхцөлд хүүхдийн эрхийг зөрчих, үл хайхрах, бие махбодийн болон сэтгэл санааны хүчирхийлэлд өртөх аюул байсаар байна. Зарим хүүхэд боловсролын эрхээ бүрэн эдэлж чадахгүй, хөдөлмөр эрхлэх, цахим орчинд дарамтанд өртөх зэрэг асуудал ч түгээмэл гарч байна. Энэ бүхэн нь хүүхдийн ирээдүйд сөргөөр нөлөөлөхөөс гадна нийгмийн хөгжилд ч том саад болдог. Хүүхэд хамгааллын асуудлыг шийдвэрлэхийн тулд олон талын оролцоо зайлшгүй хэрэгтэй. Юуны өмнө гэр бүл хүүхдийн хүмүүжил, халамж, аюулгүй орчныг бүрдүүлэх хамгийн чухал үүргийг хүлээнэ. Дараа нь сургуулийн орчин хүүхдэд зөв боловсрол, төлөвшил олгохоос гадна аливаа хүчирхийллээс хамгаалсан аюулгүй орчин байх ёстой. Төрийн зүгээс хүүхдийн эрхийг хамгаалах хууль, бодлогыг хэрэгжүүлэх, хяналт тавих нь зайлшгүй. Мөн олон нийтийн байгууллага, иргэн бүр хүүхдийн асуудалд мэдрэмжтэй хандаж, туслах сэтгэлтэй байх шаардлагатай. Ийнхүү хүүхдийг хамгаалах ажлыг олон талын оролцоотойгоор шийдэж шаардлагатай. Гэр бүлийн үүрэг хариуцлага, сургуулийн дэмжлэг, төрийн бодлого зэрэг нь уялдаа холбоотой байж гэмээнэ хүүхдийг бүрэн хамгаалж чадна. Эцэст нь хэлэхэд, хүүхдийг хамгаалах нь зөвхөн нэг хүний биш, бүх нийтийн үүрэг. Хүүхэд бүр аюулгүй, аз жаргалтай өсөж хөгжих боломжтой байх нь бидний нийгмийн хөгжил, ирээдүйн баталгаа юм.

Говь-Алтай аймгийн
Цээл сумын 8а ангийн
сурагч. Н. Үүлэнсолонго

**Н.ҮҮЛЭНСОЛОНГО**
Цээл сум, 8а анги

## Хүүхэд хамгаалал миний үзэл

Хүүхэд хамгаалал гэж сонсоод би хамгийн түрүүнд хүүхдийг хайрлаж хамгаалах гэж ойлгосон. Бид ч л соёолж буй нахиа шиг. Хэрвээ усалж тордоод л байвал өндөр том мод болж ургана. Харин анхаарахаа больчихвол тэд хатаж хорчийно.

Анхны найз минь нэг удаа багшийн асуултад буруу хариулсан чинь хүүхдүүд пир хийтэл инээлдсэн. Тэр найз минь уйлаад юу ч дуугаралгүй суугаад л байсан. Тэгэхэд би нэг зүйлийг бодсон юм л даа. Бид бүх зүйлийг чаддаг байх ёстой гэж үү?

Би өөрөөсөө яагаад гэдэг асуултыг их асуудаг. Биднийг заавал томчууд хамгаалах ёстой юм уу?

Яагаад бид өөрсдөө найзыгаа хамгаалж халамжилж болохгүй гэж. Би жаргалтай амьдралыг хүсдэг. Тэгээд ганцаараа жаргалтай байвал энэ нь хувиа хичээсэн зан гэж бодсон. Хүүхэд бүр айдасгүй, тоглож, сурч, инээж байх нь жаргалтай амьдрал. Томчууд биднийг хайрлаж хамгаалах нь тэдний үүрэг. Тэгээд бид өөрсдөө ч найзыгаа хамгаалж чадна. Хүүхэд хамгаалал бол миний бодлоор "найзын инээмсэглэлээ хамгаалах"л гэж би боддогоо.

6е ангийн сурагч: Д.Батмөнх

**Д.БАТМӨНХ**
Цээл сум, 6е анги

## Хүүхэд хамгаалал миний нүдээр

Би хүүхэд. Хүүхэд гэдэг бол эцэг эхийн баяр баясгал, нийгмийн ирээдүй улс орны үнэт баялаг. Харин биднийг хамгаална гэдэг нь зөвхөн муу зүйлээс хол байлгах тухай ойлголт биш харин хайр халамж итгэл найдвар, зөв замыг зааж өгөхийг хэлдэг. Миний нүдээр хүүхэд хамгаалах гэдэг нь аюулгүй орчинд амьдрах эрхээр хязгаарлагдахгүй. Хүүхэд бүрийн дуу хоолойг сонсож, сэтгэл санааг ойлгож мөрөөдлийг нь дэмжих явдал юм. Тоглож наадахдаа айхгүй байх, сурч боловсроход саадгүй байх, мөрөөдлөө биелүүлэхэд урам авах энэ бүхэн хүүхэд хамгааллын бодит утга гэж би боддог. Энэ эрхийг хамгаалах хамгийн түрүүнд аав ээж, дараа нь багш, найз нөхөд улмаар бүхэн бүтэн нийгэм хариуцах учиртай. Хэрэв томчууд биднийг тоохгүй өнгөрвөл хүүхэд өөрийгөө ганцаардсан үнэ цэнгүй мэт мэдэрч байна. Харин ойлгож сонсож, алдаа гаргахад ухаалаг зөв зөвлөх аваас бид өөртөө итгэлтэй аз жаргалтай өснө. Хүүхэд хамгаалах миний нүдээр бол зөвхөн хүчирхийллээс хамгаалах биш харин хүүхдийн итгэл найдвар. Хүүхдээ сонсож хайрлаж дэмжсэн нийгэм л жинхэнэ хөгжлийн замд алхаж чадна.

**Т.ЭНХЖИН**
Хөхморьт сум, 6б анги

Хүүхэд хамгаалах миний түүх.

Хүүхэд бол гэр бүлийн баялаг төдийгүй улс үндэстн ирээдүйг тодорхойлох хамгийн үнэ цэнтэй хөрөнгө юм. Гэвч хэдий ч өнөөгийн нийгэмд хүүхдийн эрх зөрчигдөх, хүчирхийлэлд өртөх, сургуулиас завсардсан, ажил хийлгэдэж зэрэг олон асуудал байсаар ирсэн. Энэ бүхэн нь зөвхөн нэг гэр бүлийн бус, бүхэл бүтэн улс үндэстний ирээдүйд ноцтой сөрөг нөлөө үзүүлдэг. Юуны өмнө хүүхэд хамгаалалтын тулгамдсан асуудлын нэг нь гэр бүлийн орчин дахь хүчирхийлэл юм. Хүүхэд өсөж хүмүүжих хамгийн аюулгүй орчин болох ёстой гэртээ хайр халамж бус харин үл хайхрах, доромжлох, зодох зэрэг сөрөг харилцаанд өртөх нь тэдний сэтгэл зүй, боловсролд нөхөж баршгүй хохирол учруулдаг. Мон орон нутгийн зарим бүсэд ядуурлын улмаас хүүхдийг хөдөлм дайчлах, сургуулиас гарах байдал ч тулгамдсан асуудлын нэг хэвээр байна. Харин энэ бүхнийг шийдвэр лэх гарц үгүйлэгдэж байдаг. Нэн тэргүүнд хууль эрх зүйн орчныг чангатгах нь зайлшгүй. Хүүхдийн эрх ямар хэлбэрийн хүчирхийллийг тэвчихгүй гэж хатуу

байр суурьтай. Хүүхдийн хууль тогтоомжтой байх шаардлагатай. Хоёрдугаарт, гэр бүлийн боловсролыг дэмжих хэрэгтэй. Эцэг эх хүүхдээ зөв өсгөхөд мэдлэг, арга барилтай бол хүүхэд илүү аюулгүй, хайртай орчинд амьдарна. Гуравдугаарт, сургууль олон нийтийн оролцоо чухал.

Сургуулийн хичээл завсардалтыг бууруулах хүүхэд ээлтэй сургалтын орчин бүрдүүлэх нь нийгмийн хамтын үүрэг юм. Хүүхэд хамгааллын асуудлыг шийдвэрлэх нь төрийн байгууллага, иргэний нийгэм, эцэг эх иргэн бүрийн хамтын хариуцлага юм. Хүүхэд бүр инээмсэглэж аз жаргалтай амьдрах эрхтэй" гэдэг зарчмыг амьдралд хэрэгжүүлэхийн төлөө бид өнөөдрөөс эхлэн өөрийн үйлдлээрээ аз жаргалтай, хөгжсөн Монгол улсын үндэс суурийг тавина

Бичсэн: Ц.Мишээл 7б ангийн сурагч

Ут: 221.

**Ц.МИШЭЭЛ**

Цээл сум, 7б анги

# Хүүхэд хамгаалалт миний нүдээр

Хүүхэд хамгаалалт нь миний нүдээр дээрэлхүүлж гадуурхагдаж байсан хүүхэд найз нөхдийгөө анзаарч гадуурхагдаж байсан хүүхдийг хамгаалж бас ядуу гэрийн хүн ээжийн өнчин өссөн хүүхдүүдийг гэртээ авчирч хоол унд өгч хувцас өмсгүүлж хүүхдийг хайрлаж хамгаалж гэр бүлийн хүчирхийлэл эсвэл цахим орчинд хүчирхийлүүлж байгаа хүүхдүүдийн аав ээжид эсвэл нийгмийн ажилтанд хэлж аль эсвэл "108" буюу хүүхдийн тусламжийн дугаарт холбогдож арга хэмжээ авах. Үм Гар утсанд донтсон үеэ эсвэл найз нөхөддөө зөвөөр ойлгуулж найзуудаа муу зуршлыг үгүй хийх нь найзуудаа эрүүл мэндийг хамгаалж байгаа хэрэг юм.

Зээ бичсэн

Хөхморьт 7.а ангийн сурагч

Н. Минжинсор

**Н.МИНЖИНСОР**
Хөхморьт сум, 7а анги

Хүүхэд хамгаалал

Эсээ

## Хүүхэд хамгаалал миний нүдээр

Миний нүдээр хүүхэд хамгаалал гэдэг нь зөвхөн хүүхдийг хүчирхийллээс хамгаалах тухай биш, харин хүүхэд гэдэг үнэ цэнэтэй оршихуй гэдгийг хүлээж зөвшөөрөх эхлэл.

Өглөө бүр сургуульдаа явах замдаа би олон янзын хүүхдийг хардаг. Зарим нь инээмсэглэж, үүргэвчээ дүүрэн ном дэвтэртэй алхаж байхад зарим нь цонхийж ядарсан нүүртэй явдаг. Түүний зарим нь хичээл хийж, мөрөөдлөө биелүүлэх замдаа явж байхад зарим нь амьдралын бэрхшээлтэй тэмцэж байдаг. Тэр үед би боддог: "Яагаад хүүхэд бүр адилхан өсөж байдаггүй юм бол? адилхан хамгаалал авч чаддаггүй юм бэ? Үргэлж л цахим орчинд хүүхэд алга болсон, хүүхэд амь үрэгдэх гэх мэдээ өдөр ирэх тусам илүү ихсэх л байдаг. Учир нь хүүхэд гэдэг бол хамгаалалтгүй орхивол хамгийн амархан гэмт хэргийн бай болдог юм.

Намайг хүмүүсийн яриаг сонсдоггүй байсан бол би одоо хэн ч биш байх байсан. Би бол жирийн нэг хүүхэд гэхдээ миний дотор хэний ч хараагүй хүсэл, мөрөөдөл, сонсоогүй үг, үнэлэгдээгүй үнэ цэнэ бий.

Томчуудын үйлдэл, шийдвэр хандлага нь хүүхдийн ирээдүйг тодорхойлдог. Хүүхдийг хамгаалахгүй бол бид ирээдүйгээ хамгаалахгүйтэй адил. Харин хүүхэд бүрийн дуу хоолой сонсвол Монголын хүчирхэг, гэрэлтэй, дуу дүүрэн байна.

Говь-Алтай аймгийн Цээл сумын ЕБС-ийн 8а ангийн сурагч Г. Халиунсор

**Г.ХАЛИУНСОР**
Цээл сум, 8а анги

Хүүхэд хамгаалал

Эсэ

Хүн бүрийн амьдралын хамгийн үнэ цэнэтэй үе бол хүүхэд нас билээ. Энэ үед хүүхэд зөвхөн гэр бүлдээ төдийгүй нийгмийн халамж, хамгаалалд тулгуурлан өсөж торнидог. Хүүхэд хамгаалал гэдэг нь хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, аюулгүй байдал, эрх ашгийг хангах өргөн хүрээтэй ойлголт бөгөөд ирээдүйн гэрэлт нийгмийг бүтээх үндэс юм.

Хүүхэд бол гэр бүлийн баялаг, улсын ирээдүй. Тиймээс тэднийг хүчирхийлэл, үл хайхрал, хөдөлмөрийн мөлжлөгөөс хамгаалах нь зайлшгүй. Өнөө цагт мэдээллийн хэрэгсэл, цахим орчинд хүүхдийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлөх олон хүчин зүйл бий. Иймээс эцэг эхчүүд, багш сурган хүмүүжүүлэгчид, төр засаг хамтран хүүхдэд зөв төлөвшил олгох, эрүүл орчин бүрдүүлэх нь хамгааллын чухал хэсэг болдог. Хүүхдийг хамгаалах ажил нь зөвхөн хууль дүрмээр хязгаарлагдах бус хүн бүрийн хандлага, ухамсар дээр тулгуурладаг. Хүн бүр хариуцлагатайгаар хүүхдийн дуу хоолойг сонсдог, мөрөөдлийг нь дэмжиж байх хэрэгтэй. Эцэст нь хэлэхэд, хүүхэд хамгаалал бол зөвхөн нэг салбарын ажил биш, бүх хүний хариуцлага юм. Бид хүүхэд бүрийг хайрлаж, хамгаалж чадвал Монголын ирээдүй гэрэлтэй, итгэл дүүрэн байх болно.

ГАА-ын Хөхморьт сумын ЕБС-ын 6б ангийн сурагч С. Энхманлай.

**С.ЭНХМАНЛАЙ**
Хөхморьт сум, 6б анги

# Хүүхэд хамгаалал миний нүдээр

Хүүхэд хамгаалал гэдэг бол миний хувьд хүүхдийг аливаа аюул зовлон муу муухайгаас хамгаалах хайрлаж халамжлах үйл явц гэж би боддог. Хүүхэд бид бол хамгийн эмзэг бөгөөд хамгийн их халамж шаардагддаг юм. Хүүхдийн эрхийг хамгаалах нь зөвхөн хууль дүрмийн асуудал биш бидний өдөр тутмын хайр халамжийн асуудал ч байж болно. Хүүхэд бүр өөрийн эрхтэй, амьдрах өсөж хөгжих нь эцэг эхийн хариуцлага юм. Бидний өсөлт хөгжил, амжилт бол тухайн нийгмийн ирээдүйн суурь болдог. Хүүхэд хамгаалах нь зөвхөн хүүхдийн хувьд чухал биш бүх нийгэмд үр өгөөжөө өгнө гэж боддог. Хүүхэд хамгаалагдсан орчинд бие даасан хариуцлагатай, бүтээлч хүн болж төлөвшинө. Орчин үеийн хүүхдүүд интернэт ухаалаг төхөөрөмж ашиглах болсон гэхдээ эцэг эх асран хамгаалагч нар нь илүү их анхаарал халамж тавих хэрэгтэй учир нь цахим гэдэг хэрэг үүнийг бай гээд нүд муудаж хараагүй болох аюултай үр хүүхдээ хамгаалах хэрэгтэй. Хүүхэд хамгаалал бол хүүхдийн амьдралын чанар эрхийг хамгаалж аз жаргалтай байх нь эрүүл орчинд өсгөх үйл явц юм. Хүүхэд хамгаалах нь миний нүдээр хүүхэд хамгааллын асуудал нь зөвхөн эцгийн асуудал биш. Харин хүн бүрийн оролцоо хайр халамж хариуцлагыг шаардах орчин үйл юм. Тийм бид хүүхэд бүрийн аз жаргалтай ирээдүй, эрүүл мэндийг хамгаалж хүргэхийн ангид боловсролтой бүтээлч хүн болох нь бүрдүүлэхийн төлөө хийж буй үйл ажиллагаа хийх ёстой. Хүүхэд хамгааллын төлөө хийж буй үйл ажиллагаа, бодлого, хувь хүний оролцоо хүний ёс үнэт зүйлийг бэхжүүлэх тул улам бүр өргөжих хэрэгтэй. Мөн хүүхдийн сонсож байгаа асуудлыг нь хамтдаа шийдэх хэрэгтэй, гэж боддог. Гэхдээ хүүхдээ хэт их хайрлаж байна гээд дураар нь тавьж болохгүй тэгвэл таны хүүхэд бүх зүйлийг бэлэнгээр бодох байна. Хүүхэд хамгаалах нь миний нүдээр эдгээр зүйлс хамаарах байна.

ГАА Цээл сумын Е.Б.С-ийн 7б ангийн сурагч. О. Чинбилэг

**О.ЧИНБИЛЭГ**
Цэээл сум, 7б анги

## Хүүхэд хамгаалал миний нүдээр

Хүүхэд гэдэг бол гэр бүлийн баяр баясгалан ,нийгмийн ирээдүй , улсын хөгжилд нэмэр оруулах хойч үеийнхэн юм. Гэвч хүүхэд бүр аз жаргалтай амьдрах эрхтэй хэдий ч тэдний эрх зөрчигдөх , хүчирхийлэлд өртөх тохиолдол байсаар байна. Миний нүдээр хүүхэд хамгаалал гэдэг нь зөвхөн хүчирхийллээс хамгаалах бус , тэдний эрүүл өсөж хөгжих боломжийг бүрдүүлэх өргөн хүрээтэй ойлголт юм. Юуны өмнө гэр бүл хүүхдийг хамгаалах анхны орчин байдаг. Эцэг эхийн хайр халамж , Зөв хүмүүжил нь хүүхдийн сэтгэл зүй , хүмүүжлийг тогтооно. Харин сургуульд багш нар зөвхөн мэдлэг өгөхөөс гадна хүүхдийн дуу хоолойг сонсож , тэднийг хамгаалах чухал үүрэгтэй. Нийгмийн зүгээс хүүхэд бүрт аюулгүй орчин бүрдүүлэх , эрхийг нь дээдэлж хуулиар хамгаалах шаардлагатай. Миний бодлоор хүүхэд хамгаалал бол ганц байгууллагын ажил биш , хүн бүрийн үүрэг юм. Бид өөрийн эргэн тойрон дахь хүүхдийг үл хайхрах бус , хайрлан дэмжиж , эрхийг нь хамгаалж чадвал жинхэнэ хамгаалал бүрдэнэ. Ингэснээр хүүхэд бүр аз жаргалтайгаар мөрөөдлөө биелүүлж , ирээдүйн Монголын гэрэл гэгээ болж чадна.

**Б.АРИУНЗАЯА**
Хөхморьт сум, 8б анги

## Хүүхэд хамгаалал

Хүүхэд бүхэн аз жаргалтай, амар тайван өсөх эрхтэй. Гэхдээ зарим хүүхдүүд гэртээ болон сургуульдаа хүчирхийлэлд өртөж байдаг. Заримынх нь зодож, загнаж зарим нь хичээлд явах боломжгүй байдаг. Энэ нь буруу зүйл юм. Томчууд хүүхдийг хайрлаж хамгаалж байх хэрэгтэй. Хүүхдүүд тоглож, сурч, мөрөөдлөө биелүүлэх ёстой. Бид аюулгүй орчинд өсөх хэрэгтэй. Хэрэв хэн нэгэн намайг эсвэл миний найзууд, өөр хүүхдүүдийг зовоож байвал багшдаа, цагдаад, аав, ээждээ хэлэх хэрэгтэй. Хүүхэд хамгаалал гэдэг нь биднийг аюулгүй, тайван орчинд амьдруулахын төлөө. Бид нарт хайр, итгэл, дэмжлэг хэрэгтэй. Хүүхдүүдийг хамгаалахын зөвхөн эцэг эх хийх ёстой гэж хүмүүс боддог байх гэхдээ бид нарын. Багш, Цагдаа, Эмч гээд бүх хүмүүс биднийг хамгаалах хэрэгтэй. Хүүхэд хамгаалахын 1 жишээ нь үнсэх, тэврэх хүүхдэдээ эрх сайн үг хэлэх эх-дэг гэж би боддог. Тийм хүүхэд бүхэн инээмсэглэж байгаасай гэж би томчууд та нарт уриалж байна.

**Д.БУЛГАНЧИМЭГ**
Цээл сум, 8а анги

## Хүүхэд хамгаалал миний нүдээр.

Хүүхэд бол гэр бүлийн аз жаргал, улс эх орныхоо ирээдүй юм. Миний бодлоор хүүхэд хамгаалал гэдэг нь зөвхөн хүчирхийллээс хол байлгах бус, хайр халамж, сурч боловсрох болон аюулгүй орчин нөхцөл бүрдүүлэхийг хэлдэг. Хүүхэд хамгаалалт гэдэг үг надад хамгаалах хашаа биш, харин хайр, журам, ойлголт хүндэтгэлийн орчин мэт санагддаг. Өнөөдөр олон хүүхэд сургуульдаа явах замдаа ч аюултай нөхцөл байдалтай уулзаж нүүр тулдаг. Зарим нь гэр бүлээс хангалттай хайр халамж, зөв харилцаа авч чаддаггүй. Энэ бүхэн надад болон манай хүүхдүүдийг хамгаалах нь зөвхөн төрийн биш, хүн бүрийн үүрэг хариуцлага гэдгийг ойлгуулдаг чухал зүйл юм. Хүүхэд хамгааллыг би зөвхөн томчуудын ажил асуудал гэж харахгүй, харин өөрсдөө эхлэх хэрэгтэй гэж боддог. Бид өөрсдөө бага дүүгээ хайрлаж зөв үлгэр дуурайлал болж, найз нөхдөө тусалж дэмжиж чадвал энэ нь хамгааллын хамгийн эхний алхам юм.

Миний нүдээр хүүхэд хамгаалал бол хүүхэд бүрийг инээмсэглүүлж айх айдасгүй, мөрөөдлөө биелүүлэх боломжтой орчин нөхцөлд аюулгүй өсөх явдал юм. Хүүхдээ цаг зав гаргаж яриулж сонсож ойлгож чаддаг гэр бүл хамгийн сайн хамгаалал болж чаддаг байна. Тиймээс хүүхдийн эрхийг хүндэтгэж, тэдний нээлттэй зан чанар, дуу хоолойг сонсдог нийгэмд амьдрахыг бид маш их хүсдэг юм шүү.

**Ч.АЛДАРМАА**
Цээл сум, 8б анги

# Хүүхэд хамгаалалынхан бидний нүдээр

Хүүхэд хамгаалалынхан бидний нүдээр

буслад эерэг сайхан сэтгэгдэл төрүүлдэг

Бусдыг дэмждэг нэг баг юм.

Хэрэв нэгэн эмээ цүнхээ даахгүй явж байвал чи яах байсан бэ?

Би эмээ дээр очоод эмээ таны цүнх их

хүнд харагдаж байна хэмээн хэлж туслах байсан.

Энэ мэт буслад туслах, бусдыг хүндлэхийг

үргэлж бидэнд зааж сургаж байдаг.

Хүүхэд болгон гэр бүлтэйгээ , аав ээжтэйгээ, аз жаргалтай, амьдрах боломжтой байдаггүй.

Зарим хүүхэд хүчирхийлэл , үл хайхрал , дарамтад өртдөг.

Тийм үед хүүхэд биднийг хамгаалж , тусалдаг хүмүүс бол

хүүхэд хамгаалалынхан юм.

Тэд бидний нүдээр : Зөвхөн албан үүрэг гүйцэтгэж байгаа хүн биш

Харин хүүхдийн дуу хоолойг сонсдог, ах эгч нар шиг санагддаг.

Хүүхдийн эрхийг хамгаалдаг , итгэл найдвар төрүүлдэг хүмүүс

хүүхэд бидний төлөө зүрх сэтгэлээ зориулсан баатрууд юм

Тиймээс бидний нүдээр : Хүүхэд хамгаалалынхан бол

сэтгэлтэй мэргэжилтэн , үнэн хүмүүнлэгийн элч нар юм.

“ Хүүхэд хамгаалалынхан бидний нүдээр

Оролцогч: Говь-Алтай аймгийн Дарив сумын

5А ангийн сурагч Т. Ижилсаран

**Т.ИЖИЛСАРАН**

Дарив сум, 5а анги

# Хүүхэд. хамгаалах зөв

Хүүхэд бол эх орны маань ирээдүй, гэр бүлийн гэрэл гэгээ, нийгмийн үнэт баялаг юм. Тэдний инээмсэглэл бол амар тайван хайр энэрлээр дүүрэн амьдралын бодит байдал дээр хүүхдүүд маань хүчирхийлэл үл хайхрал гадуурхалд өртөх томоохон хараа хамгаалалтай нь байсаар байна. Энэ бүхнийг зогсоохын тулд хүүхэд хамгаалал гэдэг ойлголтыг хүн бүр ухамсарлах, бодитоор хэрэгжүүлэх цаг хэдийн болжээ.

Хүүхэд хамгаалан гэдэг нь зөвхөн тэднийг зодохгүй загнахгүй байх гэсэн үг биш. Харин тэднийг хөгжих эрхийг дэмжиж сэтгэл санааны хувьд тайван орчинг бүрдүүлэх дуу дуулах, дуу хоолойг нь сонсож аюулгүй байдлыг хангах цогц үйл ажиллагаа юм. Тэдний амьдралд хайр, итгэл хүндлэл хэрэгтэй.

**Г.ИДЭРЧИМЭГ**
Хөхморьт сум, 6б анги

## Хүүхэд хамгааллын асуудал миний нүдээр

2025-10-03

Миний хамгийн хайртай хүмүүс бол миний аав, ээж, ах, дүү, багш нар минь билээ. Энэ эрхэм хүмүүс маань эрүүл энх аз жаргалтай байвал надад бас аз жаргалтай л байна. Хүүхэд бол бидний гэрэлт ирээдүй амьдралын замыг нь зөв зааж чиглүүлж өгөх нь эцэг эхийн үүрэг хариуцлага гэж бодож байна. Орчин үед аав, ээж нар их архинд орж улмаар гэр бүл, үр хүүхдэдээ хүчирхийлэл үйлдэж байгаа нь нийгэмд олон сөрөг үр дагаврыг авчирч байна.

Энэ бүхний цаана архидалт их байна. Миний бодлоор архины үнэ болон татварын үнийг маш их үнэтэй болгох хэрэгтэй гэж бодож байна.

Бидний ирээдүй болсон үр хүүхдүүд зөв төлөвшилтэй эх оронч сэтгэлгээтэй хүн болон өсөн хүмүүжээсэй хэмээн боддог. Архийг уусныаар:

### Гэр бүлийн архины асуудал/Интернэтээс/

Архи гэдэг нь согтууруулах ундааны хэмжээгээ хянах чадваргүй болох өвчин юм. Польшийн хүн амын 16 орчим хувь нь согтууруулах ундааг эрсдэлтэй байдлаар хэтрүүлэн хэрэглэдэг гэсэн тооцоо бий. Архичин хамт амьдрах нь байнгын хурцадмал байдал, сэтгэл хөдлөлийн хэт ачааллатай холбоотой байдаг. Гэр бүл дэх архи нь бэлгийн хүчирхийлэл, бие махбодийн хүчирхийлэл, түрэмгийлэл, санхүүгийн асуудал, гэртээ сэтгэл зүйн хүчирхийлэл, хүмүүстэй харилцах, хууль тогтоомжтой холбоотой асуудал гэх мэт эмгэгийн бусад хэлбэрийг дагуулдаг.

Өрхийн аль нэг гишүүн архи хэтрүүлэн хэрэглэснээр гэр бүлийн бусад гишүүд айдас, түгшүүр, уур хилэн, уйтгар гуниг, хурцадмал байдал, ичгүүр, доромжлолыг үүсгэдэг. Айдас, түгшүүр нь зөвхөн тодорхой, давтагдах аюул заналхийллийн үр дүнд үүсдэг төдийгүй гэр бүлд байх ёстой холбоо, дэмжлэгийн тогтолцооны эвдрэл, гэр бүлийн гишүүдэд аюулгүй байдлын мэдрэмжийг өгөхтэй холбоотой юм.

Архи уух эмгэгийн хэв маягийг өвөө, аав, авга ах, дараа нь хүүхдүүд давтдаг.

Сэтгэл түгшсэн хандлага, итгэлийн ерөнхий хямрал нь ихэвчлэн гадаад ертөнцтэй харилцах харилцаанд шилждэг. Гэр бүлийн архидалт нь юуны түрүүнд уур хилэнг үүсгэдэг, шууд холбоо барих эсвэл дарангуйлдаг. Уур нь архинд донтсон хүнд голчлон чиглэдэг боловч янз бүрийн шалтгааны улмаас түүний илэрхийлэл нь хаагдсан байдаг тул гэр бүлийн гишүүд өөр хоорондоо хуваалцах эсвэл гадаад ертөнцийн эсрэг чиглүүлдэг

Заримдаа уур уцаар өөр рүүгээ чиглэж, өөрийгөө хорлох, өөрийгөө муугаар доромжлох, өөрийгөө дээрэлхэх, өөрийгөө гутаан доромжлох явдал тохиолдож болно. Архидан согтуурах гэдэг нь гэр бүлийн амьдрал эвдэрч сүйрсэн үед сэтгэл санааны хувьд маш их хохирол амссаны улмаас уйтгар гуниг, гутрал, цөхрөл, арчаагүй байдлыг илэрхийлдэг. Таны гэрийн "дөрвөн хана"-д нууц болж байгаа талаар ичгүүртэй зүйл бас байдаг. Ичгүүр нь таныг бусдыг болон өөртөө анхаарал тавихад хүргэдэг.

**Архинаас татгалзах нь эрүүл мэндэд болон гэр бүлийн халуун дулаан уур амьсгалыг бүрдүүлэх улмаар аз жаргалтай амьдрах, мөнгө санхүүгийн байдал сайжрах, ажил албандаа амжилт гаргах нь элбэг байна.**

Аав ээжийнхээ хамгийн хайртай хамгийн нандин эрхэм хүүхдийнхээ хажууд байхдаа "Архи битгий уугаач" ээ гэдгийг уриалмаар байна. Нэг талдаа маш том соёл хэдий ч нөгөө талдаа гэр бүлийн байдалд сөргөөр нөлөөлнө.



Говь-Алтай аймгийн Төгрөг сумын ЕБС-ийн сурагч 7б анги

Сэдэв: Хүүхэд хамгаалал миний нүдээр — Ц. Саруулгэрэл

Хүүхэд гэдэг бол улс орны ирээдүй, гэр бүлийн баяр баясал, нийгмийн хамгийн үнэт эрдэнэ юм. Миний хувьд "хүүхэд хамгаалал" гэдэг нь зөвхөн хүчирхийллээс хамгаалах төдий зүйл биш, харин хүүхэд бүрийг аюулгүй, хайр халамж дүүрэн орчинд өсгөж хүмүүжүүлэх өргөн сонголт гэж боддог.

Өнөөдөр дэлхий дахинд олон сая хүүхэд бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн болон үл хайхрах хүчирхийлэлд өртөж байна. Манай улсад ч гэсэн хүүхдийн эрх зөрчигдөх тохиолдол байсаар байгаа нь харамсалтай. Тэвч зөвхөн төр засаг, багш сурган хүмүүжүүлэгчид бус, иргэн бүр хүүхэд хамгааллын төлөө санаа тавих ёстой. Миний бодлоор хүүхдийг хамгаалах хамгийн эхний алхам бол тэднийг сонсож, ойлгож, эрхийг нь хүндэтгэх явдал юм. Хүүхдүүд өөрсдийн санаа бодлоо чөлөөтэй илэрхийлж, аюулгүй мэдрэмжтэй байж чадвал тэд өсөж хөгжихөд илүү итгэлтэй, хүчтэй болдог.

Ирээдүйд би том хүн болсны дараа хүүхдийн эрхийг хамгаалдаг. сайн дурын байгууллагад ажиллаж, нийгэмд өөрийн хувь нэмрээ оруулахыг хүсдэг. Учир нь хүүхэд бүр хамгаалагдах эрхтэй бөгөөд бид бүгдээрээ тэднийг хамгаалагч байх үүрэгтэй. Мөн эцэг эхчүүд ч бас хүүхдээ асран хамгаалах ёстой.

**Ц.САРУУЛГЭРЭЛ**
Төгрөг сум, 7б анги

“ХҮҮХЭД ХАМГААЛАЛ МИНИЙ НҮДЭЭР”
СЭДЭВТ ЭСЭЭ БИЧЛЭГИЙН

# ШАГНАЛТ БАЙРНЫ БҮТЭЭЛҮҮД

**14-18 НАСНЫ АНГИЛАЛ**



## ХҮҮХЭД ХАМГААЛАЛ БА АЮУЛГҮЙ ОРЧИН

/ЭССЭ/

Хүний хамгийн сайхан дурсамжууд ихэвчлэн бага настай нь холбогддог. Учир нь хүүхэд гэдэг өөрөө ариун учраас. Тиймээс бага насны хүүхдэдээ анхаарал хандлагыг алгасалгүй үзүүлдэг. "Хүүхдийн сэтгэл шиг цагаахан", "Хүүхдийн нүд хэзээ ч худал хэлдэггүй" гэсэн сайшаалын үгсийг мөн харамгүй хэлэлцдэг. Ийм л халамж хайр, ерөөл бэлгийн үгсийг бага насандаа бид хангалттай сонсож амждаг. Өөрөөр хэлбэл, хүүхэд гэдэг бэх дусаагүй цагаахан цаас. Тиймээс эхний мөрөөс нь эхлээд л дотно дулаахан үгсийг түүний сэтгэл зүрхэнд сийлэх ёстой.

Үүнээс гадна албан ёсны боловсролын байгууллагаар дамжуулан хүмүүжил төлөвшил, эрдэм боловсролыг олгодог. Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Монгол Улсын боловсролын зорилго нь хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцаж, ажиллах, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэхэд оршино" хэмээн заажээ. Энэ бол хамгийн гэгээлэг үүрэг даалгавар. Учир нь бид эх орон, эх дэлхийнхээ ирээдүйн ээдийг бэлдэж байгаа явдал. Тиймээс энд хариуцлага, сэтгэл илүү тодоор гэрэлтэх ёстой. Монгол Улсын хэмжээнд жилд дунджаар 35000 хүүхэд сургуульд элсэн ордог гэсэн дундаж тоо баримт байдаг. Бид нэг ч хүүхдийг гартаа цоожтой хаалганы нь цаана үлдээх ёсгүй.

Сургууль гэдэг үг өөрөө яг цэцэг шиг санагддаг. Гэхдээ цэцгийг ургуулахад хөрс шороо, усалгаа, дулаан, агаар салхи, таатай байдал гээд олон хүчин зүйл шаардлагатай болдог. Тэгвэл бидний үр хүүхэд энэхүү цэцэг шиг ургахад юу хэрэгтэй вэ. Хамгийн тэргүүнд хүүхэд бүр эрүүл энх байх хэрэгтэй. Эрүүл энх байхын тулд эрүүл аюулгүй орчин бий болгох хэрэгтэй. Орчин гэдгийг "Ямар нэг зүйлийг тойрон хүрээлж буй ойр хавь" хэмээн "Монгол хэлний их тайлбар толь"-д үгийн утгыг тайлсан байдаг.

Харин одоо яг юу хийх вэ гэж үү. Энэ тал дээр миний бие хэн нэгэн газарт найдалгүйгээр, хэн нэгэнд буруут чихэлгүйгээр өөрийн бодол саналаа нэмэрлэж, тэр бүхнээ үлгэрлэн манлайлж хийхийг хүсэж байна. Миний бяцхан хөөрхнүүд айх айдасгүй, аюулгүй сурч боловсроход би оролцох, бүр тэргүүн эгнээд ажиллах ёстой. "Би хүүхэд юм чинь чимээгүй л байж байя. Томчууд хийх ёстой" гэсэн идэвхгүй бодлоосоо салах ёстой.

Аливаа зүйлийг бага гэж бүү алгуурла. Багаас их бий болдог. Багахан бэрхшээл хуримтлагдсаар дааж давшгүй гай гамшиг ч болох нь бий. Тиймээс эргэн тойрноосоо эхлээд л цэгцэлье.

Юуны өмнө энэ сайхан эрдмийн өргөөндөө айдасгүй ирэх замыг нь амар амгалан байлгая. Замд нь нэг ч согтуу хүн, золбин нохой, ангал ирмэг, харанхуй гудам байх ёсгүй. Тэд маань хүүхэд. Тиймээс зам зууртаа аав ээж, ах дүүтэйгээ амттан идэхийг хүсэж л таарна. Тиймээс сургуулийн ойр орчинд байгаа баталгаагүй

хүнс зардаг дэлгүүрүүдэд шаардлага тавья. Хэрвээ санал хүсэлтийг минь хүлээж авахгүй бол сургууль даяараа энэхүү дэлгүүрээс үйлчилгээ авахаа зогсооё.

Энэ замд тохиолдох нэгэн түгшүүр бол замын аюулгүй байдал. Гэрлэн дохио, гарц бол энэ аюулаас аврагч байх ёстой. Мөн эцэг эхчүүд замын зохицуулагч хийж байгаа нь тун чухал. Тэр хүмүүсээ улам хариуцлагажуулъя, идэвхжүүлье. Цалин мөнгө нэмж олгож чадахгүй ч гэсэн урмын үгээр тэтгэж, халуун цайгаар хангаж байя.

Сургуулийн хашааны доторх хурц үзүүртэй төмөр, том чулуу гээд эрсдэлтэй бүгдийг янзалъя. Тэднийхээ эрсдэлгүй ертөнцийг бүрдүүлье. Сургуулийнхаа хашаанд, тэр тусмаа дуртай тоглоомууд дээрээ тоглож байгаад хэн ч гэмтэж бэртэх ёсгүй.

Анги танхимаа үргэлж цэвэр цэмцгэр байлгая. Хугарч унасан сандал ширээгээ засварлая. Ангидаа тогтмол цагт цэвэр агаар оруулж байя. Заримыг нь бид анзаарч ч хардаггүй энэ мэт жижиг зүйлсээс л эрүүл аюулгүй орчин маань бий болно.

Түүнчлэн мэдээж барилгын стандарт норм, урсгал засвар, томоохон тоног төхөөрөмжүүд гээд бидний сэтгэл байвч хүч хүрэхгүй зүйлс олон байгаа. Харин энэ бүгдийн байгаа төрх, үнэн бодит байдлыг холбогдох газарт нь цаг алдалгүй уламжилж, асуудлыг шийдвэрлүүлж байя.

Эцэст нь сэтгэл зүйн таатамжтай орчин нэн чухал. Энд зөвхөн хайр гэрэлтсэн харц, урмаар шагнасан үг байх ёстой. Бүгд адил боломжоор хангагдсан, гадуурхал шоовдорлолгүй харилцаа байх ёстой. Аав ээж, асран хамгаалагч, багш, ажилтан, сурагч бүгд сэтгэлийн гүнээс ойлголцдог байх ёстой. Алхам бүрд хүндлэл мэдрэгдэж, хором мөч бүрд халамж түгж байх ёстой.

Ийнхүү эрүүл аюулгүй орчин бүрдсэнээр хүүхдүүд маань өвчин зовлон, бэртэл гэмтэл, айдас жихүүдэс, хорсол зэвүүцэл бүхнийг ор тас мартаж, амар амгалан орших болно.

Эрсдэлгүй, аюулгүй орчинд л хүүхэд эрүүл байж чадна. Эрүүл л байж чадвал энэ нутгийнхаа, энэ улсынхаа, энэ дэлхийнхээ ирээдүйг бүтээж чадна. Энд л хамгаалагдсан хүүхэд хайрыг мэдэрч, мэдэрсэн хайраа бусдад түгээж чадна. Эндээс л бүх сайн сайхан эхлэх болно.

Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын ЕБС-ийн 12б ангийн сурагч Э.Баярмаа

I БАЙР

**Э.БАЯРМАА**
Баян-Уул, 12б анги

**Хүүхэд хамгаалал миний нүдээр эссэ бичлэгийн уралдаан**

**Нэр: Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 1-р сургуулын 12г ангийн сурагч Б.Баднаанямбуу**

**Хаяг: Жинст 45-25**

Би хүүхэд. Хүүхэд гэдэг нь зөвхөн сурагч эсвэл тоглож наадаг бяцхан хүн төдий бус, харин ирээдүйн насанд хүрсэн нийгмийн бүрэн эрхт нэгэн гишүүн юм. Миний ойлгож буйгаар хүүхэд хамгаалал гэдэг нь зөвхөн хүчирхийллээс хамгаалах төдийгүй бидний эрүүл, аюулгүй орчинд өсөн дэвжихэд шаардлагатай бүх нөхцөлийг бүрдүүлэхийг хэлнэ.

Би Говь-Алтай аймгийн жирийн нэгэн сурагч. Өдөр бүр сургуульдаа явах замдаа олон хүүхдийг хардаг: зарим нь инээмсэглэн тоглож наадан алхах бол, зарим нь санаа зовсон царайтай явна. Миний бодлоор хүүхэд хамгаалал гэдэг нь хүүхдийн тэрхүү "гэрэлтсэн" инээмсэглэлийг алдахгүй байлгах баталгаа юм.

Гэр бүлийн аз жаргал, нийгмийн ирээдүй, улс орны хөгжил цэцэглэлтийн үндэс болсон хүүхдүүд өнөөдөр дэлхий дахинд хүчирхийлэл, дээрэлхэлт, ядуурал зэрэг олон эрсдэлтэй тулгарч байна. Монгол Улсын хувьд ч хүүхэд хамгааллын асуудал тулгамдсан томоохон сэдэв болж байгааг судалгаа, мэдээллүүд харуулдаг. Бид өдөр бүр хүүхдийн эрхийг үл тоомсорлосон жижиг зүйлсийг анзааралгүй өнгөрөх нь олонтаа. Жишээлбэл, дээрэлхүүлсэн нэгнийг сонсолгүй өнгөрөх, гэр бүлийн хүчирхийллийг "том хүний асуудал" хэмээн үл ойшоох эсвэл түр зуурын арга хэмжээ аваад өнгөрөх зэрэг нь хүүхдийн сэтгэлд гүн шарх үлдээж, цаашлаад ирээдүйн хүнд гэмт хэргийн үндэс болж ч болохыг анзаарахгүй байх нь бий.

"Энэ бүхнийг зогсоохын тулд би өөрийн хэмжээнд юу хийж чадах вэ?" гэсэн асуултыг өөрөөсөө асуусны дараа есдүгээр ангидаа хүүхдийн төлөө, хүүхдийн өөрөө удирдах байгууллага болох Хүүхдийн зөвлөлд элссэн юм. Жилийн хугацаанд тэргүүний үүрэг гүйцэтгэж, олон хүүхдийн дуу хоолойг сонсож, тэдний зовлон, баяр баяслыг хамтдаа мэдэрч хуваалцлаа. Бүдгэрсэн нүдний очийг сэргээхийн тулд олон үйл ажиллагаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. Энэ гайхамшигт аяллын туршид шантрах үе бишгүй байсан ч биднийг дэмжин хамтдаа даван туулах томчууд байгаад маш их талархдаг. Үүнээс би том хүний хүүхдэд үзүүлэх нөлөө ямар чухал болохыг ойлгосон. Хэрэв бүгдээрээ хамтарвал хүүхэд хамгааллаараа тэргүүлэх аймаг, цаашлаад улс болох бүрэн боломжтой гэдгийг биеэрээ мэдэрсэн.

Энэ салбарын нэгэн хэсэг болсноор Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газрын мэргэжилтнүүдийн ажил, бүтэцтэй илүү ойр танилцах боломжтой болсон. Үүднээс нь эхлээд л хайр халамж мэдрэгддэг, жижүүр ах, ажилтан бүр хүүхдийн төлөө дор бүрнээ нэгийг хийж бүтээхийг хүсдэг "багш" шиг сэтгэлтэй хүмүүс байдгийг харсан. Тиймээс хүүхдээ хамгаалахын тулд зөвхөн боловсролын систем, төрийн байгууллагад найдах бус, бүх насанд хүрэгчдийн хандлага өөрчлөгдөх нь хамгийн чухал юм.

II БАЙР

**Б.БАДНААНЯМБУУ**
1-р сургууль, 12г анги

## Хүүхэд хамгаалал, миний нүдээр

Би бол хүүхэд. Миний нүдээр хүүхэд хамгаалал гэдэг бол зөвхөн нэг байгууллага, хууль дүрмийн хүрээнд хязгаарлагдах ойлголт биш. Энэ бол хүүхэд бүрийн эрх чөлөө, мөрөөдөл, аз жаргалыг хамгаалах өргөн хүрээтэй, хүнлэг үнэт зүйл юм. Хүүхэд хамгаалал нь зөвхөн хүчирхийллээс сэргийлэх тухай бус, харин хүүхдийг хүн гэдэг утгаар нь хүндэтгэн, дуу хоолойг нь сонсож, хөгжих боломжийг нь бүрдүүлэх тухай юм.

Өнөөдөр бидний эргэн тойронд хүүхдийн эрх зөрчигдөж буй олон жишээ бий. Зарим хүүхэд гэр бүлийн үл хайхрал, хүчирхийлэлд өртөж, зарим нь сургуулийн дарамт дээрэлхэлт, цахим орчны сөрөг нөлөөнд автаж байна. Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн түлд зөвхөн хууль, дүрэм бус, хүн бүрийн хандлага өөрчлөгдөх ёстой. Миний бодлоор хүүхэд хамгааллын хамгийн гол үндэс нь хайр ба хүндлэл. Хүүхдийг зөвхөн ирээдүйн "том хүн" гэж харах бус, өнөөдрийн тэдний мэдрэмж, сэтгэлийг хүндэтгэх хэрэгтэй. Миний нүдээр хүүхэд хамгааллын хамгийн чухал хэсэг бол сонсох явдал. Томчууд бидний сурлага ,амжилтаар хэмжихийн оронд, мөрөөдөл, хүсэл тэмүүллийн минь сонсож , ойлголт үед би өөрийгөө хамгаалагдаж байгаагаа мэдэрдэг. Хүүхдийн дуу хоолойг үл тоомсорлосон нийгэм хэзээ ч жинхэнэ хамгаалалтай байж чадахгүй. Хүүхэд хамгаалал бол зөвхөн төрийн байгууллага, багш, эцэг эхийн үүрэг биш. Бид өөрсдөө ч хамгаалагч байж чадна. Найз минь ганцаардахад түүнтэй хамт байх, дээрэлхэлт өртөхөд дуугарч хамгаалах, сэтгэлээр унасан хүнд урам өгөх нь бидний хийж чадах хамгийн үнэ цэнэтэй алхам юм. Жижиг мэт санагдах энэ үйлдлүүд нь найзын минь сэтгэлд итгэл, урам зоригийн гал асаадаг.

Миний хувьд хүүхэд хамгааллын зөвхөн өнөөдөрт хэрэгтэй зүйл гэж харагдахгүй. Энэ бол ирээдүйн суурь, гэрэлтэй нийгмийг бүтээх бат бөх тулгуур. Өнөөдрийн хүүхэд хамгааллын чанар маргаашийн нийгмийн үнэт зүйл, хүний мөсний хэмжүүр болж хувирна. Тиймээс хүүхэд хамгааллыг зөвхөн хууль дүрмээр бус, хүн бүрийн зүрх сэтгэлд амьдруулах ёстой. Ирээдүйд би өөрийнхөө мөрөөдлийг хамгаалаад засахгүй, бусдын дуу хоолойг хамгаалдаг, хүүхдийн төлөө зоригтойгоор дуугардаг хүн байхыг хүсдэг. Учир нь хүүхэд хамгаалал гэдэг бол өнөөдрийн сүүдрийг арилгаж, маргаашийн гэрлийг асаах хүч билээ.

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 2р сургуулийн 11б ангийн сурагч: Х.Энхзул

III БАЙР

**Х.ЭНХЗУЛ**
2-р сургууль, 11б анги

## Хүүхэд хамгаалал миний нүдээр

Хүүхэд гэдэг бол цасанд ургаж буй өчүүхэн цэцэг шиг эмзэгхэн атлаа гэгээлэг оршихуй. Тэдний инээмсэглэлд ирээдүйн нар мандадаг, харин тэдний нулимсанд өнөөдрийн алдаа буух мэт санагддаг. Миний нүдээр хүүхэд хамгаалал гэдэг бол энэ эмзэгхэн цэцгийг салхи шуурганд навчиндаа нөмөр болох, тэдний мөрөөдлийн тэнгэрт нар мандуулах, хамгийн гол нь "чи ганцаараа биш" гэж хэлэх халуун дулаан итгэл юм. Хүүхдийг хамгаална гэдэг нь зөвхөн хатуу гарыг зайлуулж, хүчирхийллээс хол байлгахын нэр биш. Тэдний сэтгэлд итгэлийн гал асааж, мөрөөдөлд нь далавч ургуулахыг хэлдэг. Зарим хүүхэд тоглоомын талбайд биш, гудамжны тоосонд алхаж, зарим нь ангийн ширээнд биш, амьдралын хатуу хичээлд суралцаж байдаг. Тийм мөчид хүүхэд хамгаалал бол нулимсыг нь арчих алчуур, итгэлийг нь бадраах гэрэл, ирээдүйг нь холбосон гүүр болж харагддаг. Надад хүүхэд хамгаалал гэдэг нь хариуцлагаас илүү хайрын хэл. Хүүхдэд хайр өгөх нь хамгаалал, сонсож ойлгох нь хамгаалал, мөрөөдлийг нь дэмжих нь хамгаалал. Бидний өдөр тутмын өчүүхэн үйлдэл бүр тэдний ертөнцийг хамгаалж чаддаг: нэгэн инээмсэглэл, нэгэн тэвэрэлт, нэгэн энгийн Чи чадна гэсэн үг ч хамгааллын хамгийн том дархлаа болдог. Миний нүдээр хүүхэд хамгаалал бол ирээдүйн гэрлийг өнөөдөр асаахтай адил. Бид хүүхдийнхээ зүрхийг хамгаалж чадвал тэд маргаашийн ертөнцийг хамгаална. Харин хүүхдийн нулимс хэзээ ч газарт унах ёсгүй, учир нь тэр нулимсанд бидний ирээдүй нуугдаж байдаг.

Мэргэжлийн боловсролын сургуулийн Хэрэглээний програм хангамжийн 2-р курсын сурагч М. Шишлев.

IV БАЙР

**М.ШИШЛЕВ**
МБС, 2-р курс

“ХҮҮХЭД ХАМГААЛАЛ МИНИЙ НҮДЭЭР”
СЭДЭВТ ЭССЭ БИЧЛЭГИЙН

# БУСАД БҮТЭЭЛҮҮД

**14-18 НАСНЫ АНГИЛАЛ**



Хүүхэд хамгаалал миний нүдээр

Хүүхэд хамгаалал гэдэг бол зүгээр нэг нийгмийн сэдэв биш. Энэ бол хүн бүрийн үүрэг, нийгмийн ирээдүйн баталгаа, хүнлэг сэтгэлийн илэрхийлэл юм.

Өнөөдөр олон хүүхэд гэр бүл, сургууль нийгмийн орчиндоо хүчирхийлэл дарамтад өртөж байна. Зарим нь айдастай амьдарч дуу хоолой нь сонсогддоггүй. Хүүхдийг хүмүүжүүлэх нэрийдлээр шийтгэх, доромжлох хайхрамжгүй хандах хандлага түгээмэл байдаг. Үүнийг өөрчлөхийн тулд дараах шийдлүүдийг санал дэвшүүллээ. Нэгдүгээрт сургуулиудад сэтгэл зүйч ажиллуулах хэрэгтэй. Сэтгэл зүйч зөвхөн улсын төв сургуулиудад биш, орон нутгийн сургуульд ч зайлшгүй хэрэгтэй. Учир нь хүүхдүүдийн сэтгэл зүй, сэтгэл хөдлөлийн асуудал хаа сайгүй тохиолддог. Хөдөө орон нутгийн хүүхдүүд ихэвчлэн сэтгэл зүйн тусламж авах боломжгүй байдаг тул тэдэнд тэгш боловсрол, хөгжлийн орчин бүрдүүлэхэд сэтгэл зүйчийн оролцоо чухал юм. Түүнчлэн миний бодлоор хүүхдийнхээ үзэл бодол сонсох тогтолцоо бий болгосноор хүүхдийн

үзэл бодол тэдний өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлж сэтгэлзүйн аувод тогтвортой өсөхөд дэмжлэг үзүүлнэ. Эцэг эх хүүхдийн харилцаа сайжирч, ойлголцол гүнзгийрнэ гэж үзэн.

Хүүхэд хамгаалал бол зөвхөн төрийн байгууллагын ажил биш. Энэ бол хүн бүрийн үүрэг. Хэрвээ бид өнөөдөр хүүхдүүдээ хамгаалж хайрлаж чадвал Монголын ирээдүй гэрэлтэй эрүүл нийгэм бидний гарт байх болно гэдэгт би итгэдэг.

Говь-Алтай аймгийн
Дэлгэр сумын Ерөнхий боловсролын
11а ангийн сурагч Ш.Хонгорзул

**Ш.ХОНГОРЗУЛ**
Дэлгэр сум, 11а анги

"Хүүхэд хамгаалал миний нүдээр"

Хүүхэд бол гэр бүлийн баяр баясгалан, бас Монголын ирээдүйг бүтээх хүмүүс юм. Гэхдээ хүүхэд бүр ижил тэгш хамгаалагдаж, аюулгүй орчинд өсөж хөгжихгүй байна. Монголд хүүхдийн эрхийн зөрчил, хүчирхийлэл их байгааг мэдээ мэдээллээс харж болно. Энэ нь хүүхдүүд бидэнд айдастай төдийгүй сэтгэл зовинол төрүүлж байдаг. Сүүлийн гурван жилд гэхэд 5000 гаруй хүүхэд хүчирхийлэлд өртсөн гэсэн тоо барим байна.

Өнөөгийн байдлаар хүүхэд бидэнд хамгийн их тулгамдаж байгаа асуудал нь гэр бүлийн хүчирхийлэл, үе тэнгийнхний дээрэлхэлт их байна. Мөн хүүхэд хамгаалалын үйлчилгээний чанар хүртээмж хангалтгүй санагддаг.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн дийлэнх хувь нь сургуулийн орчинд үе тэнгийнхний дээрэлхэлт үйлддэг болох нь судалгаагаар нотлогдсон байдаг. Зарим эцэг эх хүүхэдтэйгээ зүй бус харилцах зарим үед гар хүрэх эсвэл буруу зөрүү зүйл хийж байсан ч үл тоох нь хүчирхийлэл гэдгийг мэдсэн ч мэдээгүй юм шиг "гэр бүлийн дотоод асуудал" гэж өөрсдийн үйлдлээ өмгөөлдөг нь буруу хандлага юм. Гэр бүлийн хүчирхийлэл нь зөвхөн хүчирхийлэлд өртөж буй хүүхэд биш тухайн хүүхдийн эргэн тойронд байгаа бүх хүүхдүүдэд нөлөөлдөг болохыг бодож тунгаах хэрэгтэй. Үл хайхрах хүчирхийлэлд өртсөн хүүхдийн харилцаа хандлага, үйлдэл нь түрэмгий, дээрэнгүй, хэт бардам болж үе тэнгийнхэний дээрэлхэлт үйлдэхэд хүргэсэн хэд хэдэн жишээг би мэднэ. Үүнийг би мэдээд чимээгүй өнгөрөх ёсгүй гэж боддог. Энэ нь түүнд таалагдахгүй, надад эрсдэлтэй байсан ч зөв аргаар шийдэх боломтой гэж үзээд эрх мэдэл бүхий хүмүүст мэдээлсэн. Миний энэ оролцоогоор тухайн хүүхэд эрсдлээс ангид байх боломж бүрдэж, сургуулийн орчинд дээрэлхэлтгүй хүүхдүүдийн харилцаа зэрэг болох юм.

Цаашид сум сургуулийн хүүхэд хамгаалах баг, нийгмийн ажилтнууд "бусдын эрх чиний эрхээр хязгаарлагдах ёсгүй" гэдэг ойлголтыг бүх насныханд ухааруулж өгөх нь чухал байна гэдгийг онцлон хэлмээр байна. Мөн хүүхдийн насны онцлогт тохирсон, чөлөөт цагийг зөв өнгөрүүлэх, зэрэг үйлийг шингээсэн хөгжөөнт өдөрлөг бусад арга хэмжээг тогтмол үр дүнтэй зохион байгуулдаг баймаар санагддаг. Хүүхэд бүрийн хүсэл мөрөөдлийг сонсож, хөгжүүлэн дэмжих үйл ажиллагааг ч шат шатандаа ажил хэрэг болгоосой гэж хүсдэг.

Миний бодлоор хүүхэд хамгаалал гэдэг нь зөвхөн хууль дүрэм бус, хүн бүр хүүхдийг "зөв хайраар" хайрлаж хамгаалан, томчууд зөв үлгэрлэл хандлагатай байх ёстой. Хүүхэд бидний ирээдүй зөв хайр хандлагаас шалтгаална.

Хүүхдээ хамгаалж, хайрлаж, хөгжүүлж чадсан нийгэм ирээдүйдээ гэрэлтэй байх болно.

Оролцогч: Говь-Алтай аймгийн Халиун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 10а ангийн сурагч С.Энхмэнд

**С.ЭНХМЭНД**
Халиун сум, 10а анги

Бигэр сумын ерөхий боловсролын сургуулийн 11а ангийн сурагч Б.Мөнхзул

## "ХҮҮХЭД ХАМГААЛАЛ МИНИЙ НҮДЭЭР"

Хүүхэд гэдэг бол гэр бүлийн аз жаргал, улс орны ирээдүй, нийгмийн гэрэл гэгээ юм. Харин тэднийгээ хамгаална гэдэг бол зөвхөн томчуудын бус, бүх хүний үүрэг гэж би ойлгодог. Миний нүдээр хүүхэд хамгаалал гэдэг нь зүгээр л хүчирхийллээс хол байлгах төдий зүйл биш. Энэ бол хайр, анхаарал, ойлголцол, итгэлцэл дээр тулгуурласан нийгмийн хамтын хариуцлага юм.Хүүхдийг хамгаална гэдэг чинь хүчирхийллээс хол байлгах төдий биш, харин тэдний хөгжих, сурч боловсрох, аз жаргалтай амьдрах орчныг бүрдүүлэхийг хэлнэ. Тэдэнд урам зориг, хайраар дүүрэн орчин хэрэгтэй.

Хүүхэд бүр мөрөөдөлтэй төрдөг ч хамгаалал дутсан газар тэдний мөрөөдөл бүдгэрч, ирээдүй нь бүдэг болдог нь тун харамсалтай... Би хөдөө орон нутагт амьдардаг.Манай суманд ч хүүхэд хамгааллын асуудал яригддаг. Зарим хүүхэд хичээлдээ явахгүй, айлын ажил хийж, хүнд нөхцөлд амьдарч байгааг харах сэтгэл өвтгөдөг. Тэдэнд "ЧИ ЧАДАХ ЮМ ШҮҮ" гэж урам өгөх ганц үг, цунхнийх нь үүрэх оосрыг засаж өгөх сэтгэл л дутаж байдаг. Хүүхдэд хамгийн жижигхэн зүйл ч хамгийн том урам болдог.

Миний бодлоор хүүхэд хамгаалал нь гэр бүлээс эхэлдэг. Эцэг эхчүүд хүүхдийнхээ үгийг сонсож, тэдэнд цаг гаргаж, сэтгэл санааг нь ойлгож байх нь хамгааллын анхны алхам юм. Дараа нь сургууль, багш нар, нийгэм хамтдаа хариуцлага үүрэх хэрэгтэй. Хүүхдийн эрх зөрчигдөхгүй, тэдний дуу хоолой сонсогддог орчинд л бид хамгаалалт ярьж чадна. Хүүхэд бол бидний маргааш. Тиймээс тэднийг өнөөдөр хамгаалж чадаагүй бол, маргааш бид юунд найдах вэ? Миний нүдээр хүүхэд хамгаалал бол хайр, хүндлэл, анхаарал, ухаалаг дэмжлэг юм. Хэрэв хүн бүр ганцхан хүүхдэд ч болов сайн сайхныг түгээж чадвал, бүх хүүхэд хамгаалагдсан ирээдүй биднийг хүлээж байгаа.

**Б.МӨНХЗУЛ**
Бигэр сум, 11а анги

## Хүүхэд хамгаалал миний нүдээр /эссэ/

Хүүхдүүд бид бол гэр бүлийн аз жаргал, нийгмийн ирээдүй, улс орны хөгжлийн бат бөх үндэс суурь юм. Тиймээс хүүхдийн эрхийг хамгаалж, тэднийг аюулгүй, хайр халамжтай орчинд өсгөх нь хамгийн түрүүнд гэр бүлээс эхэлдэг. Гэвч бодит амьдрал дээр олон хүүхэд гэр бүлийн орчиндоо хайраар дутагдаж, бие махбодын болон сэтгэл зүйн хүчирхийлэлд өртдөг. Эцэг эхийн хараа хяналт сул үл хайхарч зөнд нь орхисоноос болж хүмүүжил төлөвшлийн хувьд тогтворгүй, утасны хэрэглээ ихтэй, зарим нь хорт зуршилд уруу татагдаж байна. Сумын төвийн хувьд сургууль дээр үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийлэлд өртөх тохиолдол бараг гардаггүй. Харин ээж аав нь хөдөө байдаг, гэртээ бие даан дүү нараа харж амьдарч байгаа болон сургуулийн насны ах эгчтэйгээ хамт амьдарч байгаа хүүхдүүд гэр бүлийн зүгээс үл хайхрах хүчирхийлэлд өртөж байна. Тэдгээр хүүхдүүд хичээл сургууль, гэрийн даалгавар хийх, сонгон дугуйланд явахын зэрэгцээ дүү нараа харж хооллож үндалж, ус авч, түлээ гүүрсээ зөөж гал түлэх, гэр орны ажил хийх нь ихээхэн ачаалал болдог байх. Зарим нь хоолоо ч хийж идэж чадахгүй, ээж аваа байхгүйг далимдуулж хүүхдүүд цуглуулж утсаар тоглох, гадуур тэнэх, буруу зүйлд уруу татагдаж байгаа тохиолдлууд ажиглагддаг. Сургуулийн орчинд хаяа ялгаварлан гадуурхалт, үе тэнгийн дарамт зэрэг асуудал хүүхдийн сэтгэл зүйг гэмтээж, өөрийгөө үнэлэх үнэлэмжийг бууруулдаг.

Миний харж байгаагаар хүүхэд хамгаалал бол хууль дүрмээр хязгаарлагдах ойлголт биш, харин хүн бүрийн сэтгэлээс эхлэх үнэт зүйл юм. Иргэн бү, эцэг эх бүр, сургуулийн бүх багш, ажилчид хүүхэд хамгаалагч байх ёстой. Хүүхдүүд бидний асуудал бол дан ганц сургууль, багш, хүүхэд хамгааллын мэргэжлийн хүмүүсийн анхаарах асуудал биш. Иргэн бүр хүүхэд хамгаалагч байх ёстой. Гэр бүлийн хүрээнд эцэг эх хүүхдээ сонсож, хайрлаж, хүндэтгэж өсгөх нь хамгааллын хамгийн чухал үндэс суурь. Сургууль хүүхдийн хөгжлийг дэмжсэн зэрэг уур амьсгалтай байх ёстой бөгөөд хүчирхийлэл, дарамтыг үл тэвчих бодлого хэрэгжүүлэх шаардлагатай. Төрийн зүгээс хүүхдийн эрхийг хамгаалах үйлчилгээ, зөвлөгөө, тусламжийг хүртээмжтэй болгох, нийгмийн хандлагыг өөрчилж хүүхдийг бие даасан эрхтэй хувь хүн гэж хүлээн зөвшөөрүүлэхэд онцгой анхаарах хэрэгтэй. Асуудлыг шийдэхийн тулд юу хийх вэ?

- Гэр бүлийн хүрээнд эцэг эх хүүхдүүддээ хайр халамж, хүндлэл үзүүлэх уур амьсгалыг бий болгох, анхаарч ярилцах, том болсон гэж үл хайхрахгүй байх, зөв бурууг ойлгуулан хүмүүжил төлөвшилд нь анхаарах.
- Сургуулийн орчинд хүмүүжил төлөвшил, хандлагад эерэгээр нөлөөлөх олон ажлыг зохион байгуулж байх, багш нар хүүхдүүдтэйгээ тулж ажиллах хүчирхийллийн эсрэг хатуу дүрэм журамтай байх.
- Нийгмийн орчны зүгээс хүүхдийг бие даасан эрхтэй хувь хүн гэж хүлээн зөвшөөрөх, үзэл бодлыг хүндэтгэн, зөвлөн тусалж байх.

Энэ бүхнээс дүгнэхэд хүүхэд хамгаалал гэдэг нь нийгмийн хамтын хариуцлага бөгөөд ирээдүйн улс эх орондоо эрүүл чийрэг, эрдэм мэдлэгтэй, хүмүүжилтэй, амьдралын ухаанта, бие даасан ИРГЭНИЙ хөрөнгө оруулалт юм. Хүүхдийг зөвхөн хамгаалах биш, харин тэгш боломж олгож, хөгжих орчин бүрдүүлэх нь тэднийг өөртөө итгэлтэй, нийгэмдээ идэвхтэй иргэн болгон төлөвшүүлнэ. Хүүхдийн инээмсэглэл, аз жаргал бол зөвхөн гэр бүлийн баяр баясал биш, харин Монгол орны ирээдүйн гэрэл гэгээ, хөгжил дэвшлийн баталгаа гэдэгт би итгэдэг.

**Дэлгэр сумын ЕБС-ийн 10А ангийн сурагч Ж.Соронзонболд**

**Ж.СОРОНЗОНБОЛД**
Дэлгэр сум, 10а анги

# Хүүхэд хамгаалал миний нүдээр

~ Хүүхэд бол гэр бүлийн баялаг, улс орны ирээдүй хүн төрөлхтний ирээдүйн гэрэл билээ. Тиймээс хүүхэд бүрийн эрхийг хамгаалж, аюулгүй орчинд сурч, хөгжих боломжийг бүрдүүлэх нь бидний зайлшгүй үүрэг.

~ Миний хувьд "хүүхэд хамгаалал" гэдэг нь зөвхөн хууль дүрэмд бичигдсэн өгүүлбэр биш, харин хүн бүрийн ухамсар, хүмүүнлэг сэтгэл, бодит үйлдлээр биелдэг ариун хариуцлага гэж ойлгодог. Сургууль бол хүүхэд мэдлэг олж мөрөөдлөө бүтээх газар. Гэвч дээрэлхэлт доромжлол, ялгаварлалаар дүүрэн бол хүүхэд өөртөө итгэлгүй айдастай нэгэн болж өснө. Тиймээс багш, сурагч, эцэг эх бүгд нэгэн зорилготой байж, сургууль бүрийг хайр, хүндэтгэл, хамгааллын хамгийн эхний түшиц газар. Эцэг эхчүүд бүхэн хүүхдээ зөвхөн хоол, хувцсаар хангах бус, сэтгэлийн дулаан хайраар тэтгэх нь чухал. Өдөр бүрийн халуун дулаан үг, хайр халамж, маргаашийн аз жаргалтай, итгэлтэй иргэнийг төлөвшүүлэх хэрэгтэй. Мөн тусгай хэрэгцээт хүүхдүүдийн эрхийг үл орхигдуулж, тэдэнд бусдын адил сурч боловсрох, хөгжих бүрэн боломж олгох учиртай. Тэднийг хайрлаж, дэмжсэн нийгэм л ирээдүйд хүчтэй, шударга нийгэм болно. Би хүүхэд хамгааллыг зөвхөн сургууль, байгууллагын хийх ажил гэж харахыг хүсдэггүй. Энэ бол хүн бүрийн хамтын хариуцлага. Бидний хэлсэн эерэг үг, сунгасан гар, харуулсан нээлттэй сэтгэл бүхэн хамгаалалд тооцогдоно. Тиймээс "Хүүхэд хамгаалал бол зөвхөн бусдын ажил биш, миний, чиний, бидний хамтын үүрэг" гэж уриалмаар байна.

~ Маргаашийн сайхан ирээдүйг хүсч байгаа бол өнөөдөр хүүхдийг хамгаалах ёстой. Аз жаргалтай хүүхэд бол хүчирхэг улс орны баталгаа. Тиймээс би өнөөдрөөс эхлэн өөрөөсөө, айл өрхөөсөө эхэлж, хүүхэд хамгааллын төлөө дуу хоолойгоо өргөж бусдыг мөн уриалах болно. Учир нь хүүхэд хамгаалал бол зөвхөн хүүхдэд бус, бүхэл бүтэн нийгэмд гэрэл асаадаг үнэт зүйл юм.

НЭГДҮГЭЭРТ ХҮҮХЭД

үг: 240

Говь-Алтай аймгийн лаборатори
нэгдүгээр сургуулийн сурагч 12в
Э.Чанарав

**Э.ЧАНАРАВ**
1-р сургууль, 12в анги

Хүүхэд бол улс орны ирээдүй, гэр бүлийн баяр баясал, нийгмийн хамгийн гэгээн давхарга билээ. Миний нүдээр хүүхэд хамгаалал гэдэг нь зөвхөн хүчирхийллээс сэргийлэх бус, хүүхдийн хөгжил, боловсрол, эрүүл мэнд, сэтгэл зүйг дэмжих цогц орчныг бүрдүүлэхийг хэлнэ.

Өнөөдөр нийгэмд олон хүүхэд хүчирхийлэл, үл хайхрал, ядуурал, боловсролгүйдэлд нэрвэгдэж байна. Энэ бүхэнд томчуудын анхаарал, оролцоо чухал. Хүүхэд хамгаалал нь зөвхөн төрийн биш, аав ээж, багш, иргэн бүрийн үүрэг гэж боддог. Би ирээдүйд хүүхдүүд аз жаргалтай, аюулгүй орчинд өсөж, өөрийн эрх, орон зайгаа ойлгож мэддэг байгаасай гэж хүсдэг. Үүнд бид хүүхдийн эрхийг хүндэтгэх, сонсох, дэмжих, туслах замаар хувь нэмрээ оруулах боломжтой. Хүүхэд бүр аз жаргалтай байх эрхтэй. Хүүхдийг зөв хүн болгон төлөвшүүлэхэд багш, аав ээж, төр, нийгмийн оролцоо хамгийн чухал юм.

Хүүхэд хамгаалах нь зөвхөн хуулийн заалт биш, харин хүний ёс суртахууны дээд хариуцлага юм. Хүүхдэд ээлтэй нийгмийг бий болгоход бид өөрсдөө гэсэн хичээх ёстой гэж үздэг. Учир нь хүүхэд хамгаалал бол хүн бүрийн зүрх сэтгэлээс эхэлдэг.

(Төгрөг)

**Н.АНУЖИН**
Төгрөг сум, 12а анги

Овог, нэр: Д. Буянхишиг

Сургууль, анги: 1р сургууль, 12г анги

Огноо: 2025 оны 10 сарын 02

## Хүүхэд хамгаалал

*Сургууль болон гэр бүлийн орчин дахь аюулгүй байдал*

Би энгийн л нэг сурагч. Өглөө бүр сургуульдаа яваад найзуудтайгаа уулзахдаа баярладаг ч зарим зүйлс намайг тухгүй болгодог. Хүүхэд бүр сургууль дээрээ болон гэртээ өөрийгөө хамгаалагдсан, хайрлагдсан гэж мэдрэх ёстой. Гэтэл заримдаа бидний орчинд дарамт, үл ойлголцол, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт зэрэг асуудал гардаг нь үнэхээр харамсалтай. Тиймээс энэхүү том асуудлын өчүүхэн нэг хэсгийг бичээд сууж байгаа билээ.

Сургуулийн орчинд хүүхдүүдийн хооронд үргэлж зөрчил үүсдэг. Зарим хүүхдүүд бусдыг дээрэлхэх, шоолох, шоглох нь элбэг. Энэ үед хүүхдүүд өөрсдөө зоригтой дуугарч, "Энэ бол буруу зүйл" гэж хэлэх хэрэгтэй гэж би боддог. Гэвч зарим нь айж дуугүй өнгөрөөдөг. Тиймээс багш, эцэг эх бидний дуу хоолойг сонсож, биднийг хамгаалж, зөлдөг уур амьсгал бүрдүүлэх нь маш чухал.

Миний хувьд гэр бүлийн орчин хүүхдийн хамгийн аюулгүй газар байх ёстой гэж боддог. Гэвч зарим хүүхдэд гэртээ хайр халамжаар дутмаг, үргэлжид зөрчилтэй орчинд байх нь энгийн зүйл болсон. Тэдний дуу хоолойг сонсдоггүй, заримдаа хүч хэрэглэдэг эцэг эх ч байдаг. Ийм хүүхдүүдийн оронд өөрийгөө тавьж үзэхэд үнэхээр хэцүү, тэвчиж болмооргүй санагддаг. Гэр гэх зүйл хамгийн халуун дулаан орчин бус хүйтэн хөндий орчин болсон гэж үү? Бид гэртээ хамгийн тайван, хамгийн өөрийнхөөрөө, хамгийн хайрлагдсан байдаг байх ёстой биш гэж үү?

Миний бодлоор энэ асуудлуудад хүүхэд бидний оролцоо ч мөн маш чухал. Жишээ нь: сургууль дээр хүүхдийн төлөө тэдний санаа бодлыг сонсдог клуб нээж, тэнд хүүхдүүд өөрсдийн санаа бодлоо илэрхийлэх боломжтой мөн маш хүртээмжтэй болгох хэрэгтэй. "Сургуулиа илүү аюулгүй, илүү сайхан болгохын тулд бид юу хийх вэ?" гэсэн асуултад бид өөрсдөө хариулж, шийдэл гаргаж чадна шүү дээ. Харин биднийг сонсож, дэмжлэг хүмүүс ч бас хэрэгтэй. Гэртээ ч гэсэн хүүхдүүдийн санал бодлыг эцэг эх нь сонсож, хамтдаа асуудлыг шийддэг байвал хүүхэд өөрийгөө үнэ цэнтэй, хамгаалагдсан гэж мэдрэх болно.

Хүүхэд хамгааллын тухайд бид зөвхөн үгээр бус үйлдлээрээ хамгаалагдах нь их чухал гэж би боддог. Сургууль бүр хүүхдийн эрхийн булан ажиллуулж, хүүхэд асуудалтай тулгарвал хэнд хандахаа мэддэг байх хэрэгтэй. Тусгай хэрэгцээтэй хүүхдүүд ч бидний адил. Тэднийг анги хамт олон дэмжиж, ялгаварлахгүй, найзууд шигээ хайрлаж, тоглож, хамтдаа сурч, хөгжиж чадвал илүү аз жаргалтай, хайрлагдсан байх болно. Тэдний аюулгүй байдалд онцгойлон анхаарах нь бидний үүрэг юм.

Эцэст нь хэлэхэд, сургууль болон гэр бүлийн орчин хүүхдэд хамгийн дулаахан орон зай байх ёстой. Бид энэхүү газруудад л сурч хөдөлмөрлөж, хайрлагдаж, хамгаалагдаж чадна шүү дээ! Хүүхэд өөрийнхөө дуу хоолойг зоригтой илэрхийлж чаддаг, түүнийгээ сонсдог томчуудтай бол бид илүү тайван, аз жаргалтай, аюулгүй байна. Миний мөрөөдөл бол сургуульд маань инээд баясал дүүрэн, гэрт минь хайр халамж цацарсан, бүх хүүхэд ялгаваргүйгээр хамгаалагдсан орчин бүрдэх юм. Бид бол Ирээдүй. Ирээдүйгээ хайрлацгаая.

**Д.БУЯНХИШИГ**
1-р сургууль, 12г анги

Овог нэр: Г. Цэцэнбилэг

Сургууль, анги: 1-р сургууль 12Г анги

Огноо: 2025 оны 10-р сарын 2

**Хүүхэд хамгаалал миний нүдээр**

Хүүхэд бүр цэвэр аюулгүй орчинд хүмүүжиж, тоглох талбай нь аюулгүй, хэрэглэх хүнс нь эрүүл байх нь тэдний наад захын эрх биш гэж үү? Хүний эрх гэдэг нь хүн болж төрсний хувьд жам ёсны болон хууль ёсны эдэлвэл зохих эрх чөлөө юм. Харин манай улсын хувьд тоглоомын талбай нь тоглоход зохимжгүй, унаж бэртэх эрсдэлтэй, идэж буй хоол хүнс нь эрүүл ахуйн шаардлага хангаагүй байх нь элбэг байдаг. Түүнчлэн цахим орчинд тавигдах олон мэдээллээс дийлэнх нь бага насны болон насанд хүрээгүй хүүхдүүдийн хүчирхийлэл, дээрэлхэлт, хулгайн хэргүүд олшрох нь хэцүүхэн. Миний бие энэхүү эссээгээрээ өөрийн үзэл бодол сэтгэгдлээ илэрхийлэн цөөн ч болов хүүхдийн дуу хоолой болохыг зорилоо.

Өнөөгийн нийгэмд хүүхэд хамгаалал нь олон талт ойлголттой. Тэдний эрүүл мэнд, боловсрол, сэтгэл зүйн эрх чөлөөг хамгаалах нь нийгмийн хөгжилд шууд нөлөө үзүүлдэг. Хэрэв хүүхэд өөрийн байгаа орчинд аюулгүй хайр халамж дүүрэн өсөж чадахгүй бол ирээдүйд нийгэмд хор учруулах нэгэн болж болзошгүй. Жишээлбэл, гэр бүлийн хүчирхийлэл, сургууль дээрх дарамт, үе тэнгийн дээрэлхэлт, орчин цагийн цахим аюул гэмт хэрэг нь хүүхдийн сэтгэлзүйд гүнзгий нөлөө үзүүлдэг. Хүчирхийллээс хүчирхийлэл гэдгийн үлгэрээр нийгмийн муу нөлөөнд хүүхэд сэргээр өөрчлөгдөнө.

Хүүхэд хамгааллын гол арга нь хууль эрх зүйн зохицуулалт юм.Монгол Улсад хүүхдийн эрхийг хамгаалах олон хууль дүрэм журмууд батлагдсан бөгөөд үүнд: "Хүүхдийн эрхийн тухай хууль", "Гэр бүлийн тухай хууль" зэрэг орно.Гэвч дан ганц хууль батлах нь хангалтгүй. Түүний хэрэгжилтэд Багш, сурган хүмүүжүүлэгч, эцэг эх, асран хамгаалагч, эмч, насанд хүрэгчид зэрэг хүмүүс оролцох шаардлагатай.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1-д зааснаар хүүхэд хамгаалал гэдэг нь нийгмийн бүх орчинд хүүхэдтэй зүй бус харьцах хүүхдийг хүчирхийлэл мөлжлөгт өртөхөөс хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн цогц бодлого үйл ажиллагаа, үйлчилгээ гэж заасан байдаг.

Миний бодлоор хүүхэд хамгаалал нь зөвхөн хамгаалах үйлдэл биш харин хүүхдийн хөгжилд суралцах боломжийг дэмжих үйл ажиллагаа юм. Жишээлбэл, ур чадваржуулах сургалт, дугуйлан, арга хэмжээ зэрэг орно. Мөн хүүхдэд зориулан эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх нь аюулгүй байдлыг хангахаас гадна нийгэмд эерэг нөлөө үзүүлэхэд чухал. Түүнчлэн эрүүл мэндийн үйлчилгээг ямар нэг саад бэрхшээлгүй авах хэрэгтэй.

Тэгвэл хэрхэн хүүхдийн эрхийг хамгаалж хангах вэ? Хүүхэд хамгаалал гэдэг нь зөвхөн гэр бүл төдийгүй нийгмийн бүх гишүүдийн хамтын хариуцлага. Дэлхийн нэрт удирдагч сэтгэгчдийн хэлснээр хүүхдийн боловсрол, хайр халамж, хамгаалалт хийсэн хөрөнгө оруулалт нь нийгмийн хамгийн үнэ цэнтэй хөрөнгө оруулалт юм. Тиймээс дан ганц хангаж хамгаалах тухай хууль хэрэгжүүлэхээс гадна аюулгүй орчин бүрдүүлэх, гар бие оролцох, сэтгэл санаагаар дэмжих, эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангах нь насанд хүрсэн гэлтгүй хүн бүрийн үүрэг хариуцлага болно.

Сэтгэл санаа бие махбодоор гэмтэж хохироход нь хандах нэгэн нь та байгаарай. Эрх нь зөрчигдөж хэнд ч хэлж чадахгүй үед нь та сонсоорой. Жаргалтай зовлонтой мөчид нь хуваалцдаг нэгэн нь байгаарай гэж хүсье.

Философич Жан Жак Росо "Хүүхэд төрөхөөсөө эрх чөлөөтэй бөгөөд хамгаалахад хамааралтай. Тэдний сайн сайхан байдал нь нийгмийн хөгжлийн үндэс юм."хэмээсний дагуу бид өнөөдөр олон хүүхдийн хүний эрх болон хүүхдийн эрхийг хангах хууль баталсан билээ. Дагаж мөрдөн сахин биелүүлэх нь та бидний үүрэг юм шүү.

**Г.ЦЭЦЭНБИЛЭГ**
1-р сургууль, 12г анги

Хүүхэд хамгаалал миний нүдээр /эссэ/

Би заримдаа боддог, томчууд биднийг хүүхэд гэдэг нэрээр хаяа дорд үздэг. "Чи жаахан юм чинь, ойлгохгүй" гэж хэлэхэд нь би дотроо уурладаг ч гаднаа дуугүй өнгөрөөдөг. "Би хүүхэд, гэхдээ яг үнэндээ юу гэсэн үг юм вэ? Хүүхдүүд бүх зүйлийг ойлгодог, суралцдаг. Би өөрөөсөө асуудаг "Хүүхэд болохоор үнэхээр бүхнийг ойлгохгүй гэж үү? Заавал ингэж ялгавалагдах ёстой гэж үү? Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хуульд "хүүхэд ялгаварлан гадуурхагдахгүй, хамгаалагдах эрхтэй" гээд тодорхой заасан байдаг. Гэхдээ бодит амьдрал дээр тэр хууль заримдаа цаасан дээрээ л үлддэг. Сошиал орчноос уншсан нэг судалгааг дурьдхад 2023 онд гэхэд л 3000 гаруй хүүхэд хүчирхийлэлд өртсөн гэсэн албан ёсны тоо мэдээлэл гарсан. Би энэ тоог хараад их цочирдсон. 3000 гэдэг тоо бол зүгээр нэг тоо биш, миний насны, миний орчин тойрны хүүхдүүд шүү дээ.

Хүүхэд хамгаалал гэдэг зөвхөн томчуудын хиих ёстой үйлдэл биш ч юм шиг. Анги доторoo бид ч бас нэгнээ шоолох, гадуурхах, үл тоох үед энэ үзэгдэл ажиглагддаг. Би бодохдоо "Би өөрөө бусдыг дээрэлхээгүй ч, харж байж дуугүй өнгөрсөн бол бас л оролцсон гэсэн үг биш гэж үү? Энэ бодол намайг үнэхээр гэмшүүлдэг. Хуульд нэмэлт өөрчлөлт орж үе тэнгийн хүчирхийлэл үйлдсэн хүүхдийн эцэг эх хариуцлага хүлээнэ гэсэн заалт орсон нь үнэхээр сайн хэрэг. Хүмүүсийн хандлага өөрчлөгдөхгүй бол хууль хэрэгжихгүй, томчууд хуулиа даган биелүүлж хүүхдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх хэрэгтэй.Тэгвэл би өөрөө юу хийж чадах юм бол? Миний хийх жижигхэн зүйлс гэвэл Найзыгаа шоолох биш, дэмжих. Хараад дуугүй өнгөрөхийн оронд хамгаалах. Хуулийн талаар уншиж, бусдад ойлгуулах. Энэ бол миний хийх боломжтой хамгийн жижиг алхамууд. Гэхдээ олон хүүхэд ингэж бодвол том өөрчлөлт эхэлнэ.

Ахлах ангид суралцаж буй надад хүүхэд хамгаалал гэдэг ойлголт зөвхөн хуулийн заалт эсвэл багш, эцэг эхийн анхааруулга биш, харин бидний өдөр тутмын үйл ажиллагаанд хамгаалж хэрэгжүүлж байх ёстой үнэт зүйл мэт санагддаг. Миний нүдээр хүүхэд хамгаалал гэдэг нь хүүхэд бүхэн тайван, аюулгүй орчинд сурч боловсорч, хүссэнээрээ мөрөөдлөө төсөөлөн бүтээх боломжийг олгох явдал юм. Миний мөрөөдөл бол бүх хүүхэд аюулгүй орчинд сурч боловсорч, өөрийгөө чөлөөтэй илэрхийлж, хүссэн мөрөөдлөө биелүүлэх боломжтой нийгэмд амьдрах. Үүнд зөвхөн эцэг эх, багш, төрийн байгууллага гэлтгүй бид хүүхэд бүр өөрсдийн оролцоогоор хамгаалагч байх хэрэгтэй. Миний, чиний хэлсэн үг маргаашийн өөрчлөлтийн эхлэл байж чадна."

Дэлгэр сумын ЕБС-ийн 11Б ангийн сурагч Б.Сумъяабаяр

**Б.СУМЪЯАБАЯР**
Дэлгэр сум, 11б анги

"Хүүхэд хамгаалал миний нүдээр"

Хүүхэд бүр аз жаргалтай инээмсэглэж, сурч боловсрох, мөрөөдлөө биелүүлэх эрхтэй. Гэвч заримдаа хүүхдүүд хүчирхийлэл, үл хайхрал, ялгаварлалаас болж эрхээ хамгаалуулж чаддаггүй. Миний нүдээр хүүхэд хамгаалал гэдэг бол хүүхэд бүрийг хайрлаж, хамгаалж, хүндэтгэж, тэдний дуу хоолойг сонсох явдал юм.

Гэр бүл бол хүүхдийг хамгаалах хамгийн эхний орчин. Эх аавын хайр халамж, халуун дулаан үг нь хүүхдийн сэтгэлийг амар тайван итгэл дүүрэн болгодог. Харин сургууль, багш, найз нөхөд хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, шударга, тэгш орчин бүрдүүлэх ёстой гэж боддог.

Хүүхэд хамгаалал бол зөвхөн нэгний биш, бүх нийтийн үүрэг. Хүүхэд хамгаалагдсан нийгэм бол аз жаргалтай, гэрэлтэй ирээдүй юм.

10а Д.Санчирмаа
/Төгрөг/

**Д.САНЧИРМАА**
Төгрөг сум, 10а анги

# Хүүхэд Хамгаалал Миний Нүдээр

Хүүхэд гэдэг бол гэр бүлийн аз жаргал нийгмийн ирээдүй, улс орны баялаг. Харин хүүхэд хамгаалал гэдэг бол тэднийг зөвхөн аюулгүй байлгаж хамгаалах төдий бус тэдний эрх, хүсэл мөрөөдөл, хөгжих боломжийг баталгаажуулах чухал ойлголт гэж би боддог.

Миний нүдээр хүүхэд хамгаалал гэдэг нь эхлээд гэр бүлээс эхэлнэ. Эцэг эхийн хайраар тэтгэгдэж, ойлгогдож, дэмжигдсэн хүүхэд өөрөө итгэлтэй, аз жаргалтай өсдөг. Гэвч зарим хүүхдүүд хүчирхийлэл, үл хайхрах, үл ойлгох хандлагад өртдөг. Ийм үед зөвхөн эцэг эх төдийгүй сургууль, нийгэм, төрийн байгууллагуудын оролцоо маш чухал.

Хүүхэд бол ирээдүйн мөрөөдөл, өнөөдрийн баяр хөөр, маргаашийн ирээдүй. Харин тэднийг зөв өсгөж хүмүүжүүлэхийн тулд хүүхэд хамгаалал чухал гэж би боддог. Хүүхэд хамгаалал гэдэг нь зөвхөн аюулгүй байлгаж хамгаалах бус, тэднийг хайрлах, эрхийг нь хүндэтгэх, хүсэл мөрөөдлийг нь дэмжих гэсэн өргөн ойлголт юм. Жишээ нь: хүүхэд чөлөөтэй тоглох, өөрийн үзэл бодлоо, өөрийн авьяасаа хөгжүүлэх боломжтой байх нь хамгааллын нэг хэлбэр гэж боддог.

Өнөөдөр олон хүүхэд цахим орчинд цагийг өнгөрөөдөг болсон. Энэ нь тэдэнд шинэ мэдлэг, мэдээлэл олдог ч бас эрсдэл дагуулдаг. Тиймээс хүүхдийг зөвхөн бие махбодын хувьд төдийгүй цахим орчинд ч бас хамгаалах шаардлагатай. Энэ бол эцэг эх биш, нийгмийн хамтын хариуцлага юм. Хэрэв бид өнөөдөр хүүхдийг хамгаалж чадвал маргаашийн Монгол улс эрүүл, хөгжилтэй, хүчирхэг байх болно.

Иймээс хүүхэд хамгаалах ажилд хүн бүр өөрийн хувь нэмрээ оруулах ёстой гэж би үздэг. Гэр бүлдээ, сургуульдаа, нийгэмдээ хүүхдийг хайрлаж хамгаалж чадвал бид ирээдүйгээ хамгаалж байна гэж үг.

**Д.УРТБАЯР**
1-р сургууль, 11а анги

## Хүүхэд хамгаалал миний нүдээр

Хүүхэд гэдэг бол гэр бүлийн аз жаргал, нийгмийн үнэт баялаг, улс орны ирээдүйн гэрэл юм. Гэвч хүүхдүүд бол хамгийн эмзэг, хамгаалалт шаарддаг хүмүүсийн нэг. Миний нүдээр хүүхэд хамгаалал гэдэг нь зөвхөн хүчирхийллээс хол байлгах төдийгүй тэднийг хайрлаж, сонсож, сурч хөгжихөд нь бүх боломжийг нээж өгөхийг хэлнэ. Хүүхдийн сайн сайхан орчин, аз жаргалтай амьдрал нь зөвхөн тэдний бус, нийт нийгмийн хөгжил, ирээдүйтэй шууд холбоотой. Юуны өмнө хүүхэд хамгаалал нь гэр бүлээс эхэлдэг гэж боддог. Халуун дулаан уур амьсгалтай, ойлголцолтой гэр бүл бол хүүхдийн хамгийн том хамгаалалт. Хүүхдэд хэт хатуу, ширүүн хандах нь тэднийг айдас, түгшүүртэй болгож, өөрийнхөөрөө хөгжих боломжийг хааж, заримдаа бүр гадуурхагдсан мэт мэдрэмж төрүүлдэг. Ийм орчинд өссөн хүүхэд өөрийн дуу хоолойгоо илэрхийлж чаддаггүй, бусдаас хэт хамааралтай нэгэн болон төлөвших нь бий. Харин ойлгож сонсдог, ярилцдаг, алдааг нь уучилдаг, дэмждэг эцэг эх бол хүүхдийн хамгийн найдвартай хамгаалагч. Тэдний хайр, урамшуулал нь хүүхдэд өөрийгөө үнэлэх итгэл төрүүлж, амьдралынхаа замыг өөрөө сонгон хөгжихөд хүч өгдөг. Мөн сургуулийн орчин хүүхдийн хамгааллын чухал хэсэг. Сургууль бол зөвхөн мэдлэг олгодог газар биш, харин хүүхдийн сэтгэл зүйг хамгаалж, тэгш харилцаа бий болгодог орон зай байх ёстой. Гэвч харамсалтай нь зарим сургуулийн орчинд дээрэлхэх, доромжлох, ялгаварлан гадуурхах байдал ажиглагддаг. Энэ бол хүүхдийн эрхэнд халдсан хамгийн том зөрчил бөгөөд тэдний сэтгэл зүйд гүн шарх үлдээж болно. Тиймээс багш, эцэг эх, сурагчдын хамтын оролцоотойгоор хүүхдэд ээлтэй, аюулгүй орчин бий болгох нь хамгийн чухал. Хүүхэд өөрийгөө хамгаалагдсан гэж мэдэрвэл илүү итгэлтэй, идэвхтэй суралцаж, өөрийн авьяасаа нээн хөгжүүлэх боломжтой болдог. Миний нүдээр хүүхэд хамгаалал гэдэг нь зүгээр нэг хууль дүрмээр тогтоосон ойлголт биш. Харин өдөр тутмын амьдралд хүүхдийг сонсох, хүндэтгэх, хайрлаж хамгаалах энгийн үйлдлүүдээс эхэлдэг зүйл. Жишээ нь, хүүхдийн сэтгэлийг сонсох, санал бодлыг нь үл тоомсорлохын оронд хүлээж авах, мөрөөдлийг нь дэмжих, аюулгүй орчин бүрдүүлэх зэрэг нь хамгааллын бодит илэрхийлэл юм. Хүүхэд бол сул дорой нэгэн биш, харин өөрийн гэсэн үзэл бодол, мөрөөдөлтэй иргэн. Гагцхүү тэдний мөрөөдлийг нь гишгэлэх бус, харин тэтгэж өгөх нь насанд хүрсэн хүмүүсийн үүрэг. Миний бодлоор хүүхэд хамгаалал гэдэг бол зөвхөн төр, хууль эрх зүйн хүрээнд хязгаарлагдах зүйл биш. Хүн бүрийн ухамсар, сэтгэл зүрхэнд хүүхдийг хайрлаж хамгаалах үзэл бат суух ёстой. Эцэг эх, багш, нийгмийн бүх гишүүд хүүхдэд хандахдаа энэрэнгүй, зөлдөг, шударга байж чадвал бидний нийгэмд хүүхэд хамгаалагдсан уур амьсгал жинхэнэ утгаараа бүрдэнэ. Эцэст нь хэлэхэд, ирээдүйдээ итгэлтэй, өөрийгөө чөлөөтэй илэрхийлдэг, бусдаас хэт хамааралгүй, аз жаргалтай хүүхдүүд өсвөл манай улс хөгжинө. Хүүхэд хамгаалагдсан нийгэмд өссөн хүүхэд маргаашийн боловсролтой, ухамсартай, хариуцлагатай иргэн болон төлөвшинө. Тиймээс хүүхэд хамгаалал бол миний нүдээр хамгийн чухал, нэн тэргүүний үүрэг бөгөөд энэ бол зөвхөн төрийн бус, хүн бүрийн оролцоо шаардсан амьд үнэт зүйл юм.

**Б.ЭНХЖИН**
1-р сургууль, 12г анги

Хүүхэд хамгаалал миний нүдээр.

Хүүхэд бол нийгмийн хамгийн эмзэг, хамгийн анхаарал халамж шаардагдах бүлэг юм. Хүүхдийн эрхийг хамгаална гэдэг нь зөвхөн аав ээжүүд асран хамгаалагчийн хариуцлага биш бүхэл бүтэн нийгмийн хариуцлага байдаг юм. Өнөөдөр зөвхөн Монгол гэлтгүй дэлхий даяар хүүхдийн хүчирхийлэл, үл хайхрал, тэдний эрхийг зөрчсөн асуудлаар маш их мэдээ мэдээлэл сэдвүүд гарч байна. Энэ нь хүүхэд хамгаалал сул байгаатай шууд холбоотой юм. Хүүхэд хамгаална гэдэг нь тэдний зөвхөн өнөөдрийн бус ирээдүйг нь хамгаалж буй үйл хэрэг юм.

Хүүхэд бүр сурч боловсрох, эрүүл орчинд өсөж хөгжих, хамгаалагдах эрхтэй. Гэвч нийгэмд ядуурал, гэр бүлийн хүчирхийлэл, хайнга хандлага зэрэг хүчин зүйлээс шалтгаалан энэ эрх нь зөрчигдөх тохиолдол олон бий. Дараагаар хүүхэд хамгаалах ажил бол зөвхөн хүчирхийллээс хамгаалах төдийгүй тэдний авьяас чадварыг нээж хөгжүүлэх, эрүүл өсөх нөхцөлийг бүрдүүлэх явдал юм. Ингэснээр хүүхэд зөв хүн болон төлөвшиж, ирээдүйд нийгэмдээ эерэг хувь нэмэр оруулна.

Дүгнэж хэлэхэд, хүүхэд хамгаалал бол нийгмийн хамгийн чухал үнэт зүйлсийн нэг юм. Хүүхдээ хамгаалсан нийгэм л эрүүл, тогтвортой, ирээдүйтэй нийгэм байдаг.

1р сургуулийн 10е ангийн сурагч А. Есүгэн.

**А.ЕСҮГЭН**
1-р сургууль, 10е анги

# Хүүхэд хамгаалал миний нүдээр

Хүүхэд бол өнөөдрийн төдийгүй ирээдүйн эзэд. Гэр бүл, сургууль, нийгэм, төр улс, бүгд хүүхдийн аюулгүй байдал, эрх ашгийг хамгаалах үүрэг хариуцлагатай. Гэвч заримдаа хүүхдүүдийн эрх зөрчигдөж, хүчирхийлж, үл хайхралд өртдөгийг бид нүдээрээ харж, чихээрээ сонсож байна. Тиймээс хүүхэд хамгаалал гэдэг нь надад зүгээр нэг албан хууль ёсны дүрэм бус хүн бүрийн сэтгэлээс гарах хариуцлага гэж би ойлгодог. Хүүхдийг хамгаалах ажил зөвхөн эцэг эхийн үүрэг биш. Сургууль дээр багш нар, гудамжинд хөршүүд, улс орны хэмжээнд, төрийн байгууллага, иргэний нийгэм бүгд хамтдаа анхаарах хэрэгтэй. Хүүхдийн дуу хоолойг сонсож асуудлыг нь ойлгож шийдэлд хүргэдэг нийгэм байж чадвал бид жинхэнэ "хүүхэд хамгаалал"-ыг хэрэгжүүлж чадна. Хүүхэд хамгаалал нь миний бодлоор гурван үндсэн чухал зүйл дээр суурилдаг:

- Эхнийх нь хайр халамж: Хүүхэд хайрлагдсан орчинд өсөхдөө өөрийгөө үнэлж, бусдыг хайрлаж, хүнлэг иргэн болж төлөвшдөг.

Хоёрдугаарт, боловсрол: Чанартай боловсрол авсан, хүүхэд зөвхөн мэдлэгтэй хүн болохоос гадна, өөрийн гэсэн үзэл бодолтой, зөв хандлагатай иргэн болж төлөвшдөг.

- Гуравдугаарт хамгаалал: Энэ нь зөвхөн бие махбодийн аюулгүй байдал биш, сэтгэл зүйн эрүүл мэндийг хамгаалахыг хэлдэг.

Бас зөвхөн аюулаас хамгаалах бус сэтгэл зүрхээр нь хамгаалах ёстой. Жишээ нь:

- Сургууль дээр багш нар хүүхдийг хичээлээ ойлгохгүй байна гэж загнадаг биш, тайвнаар ойлгуулаасай хичээл
- Гэртээ аав ээжүүд нь загнахын оронд намайг юу мэдээгүй байгааг асуувал

Энэ бүхэн нь хүүхэд хамгаалал биш гэж үү?

Зарим хүүхэд гэр бүлтэй ч, хайр халамжаар дутдаг. Зарим нь гэр оронгүй, сургууль завсардсан ч хэн ч анзаараагүй. Тийм хүүхдүүдийг харахаар миний сэтгэл өвддөг. Хүүхэд бүр гэр бүлтэй, аюулгүй орчинд амьдрах эрхтэй. Бидний инээд, нулимс, мөрөөдөл бүр адил ч үнэ цэнэтэй байх ёстой. Ирээдүйд би том хүн болоод хүүхдийг хамгаалдаг, сэтгэл зүрхээр нь ойлгодог нийгмийг бүтээхэд оролцмоор байна. Учир нь би ч бас хүүхэд. Хүүхэд хамгаална гэдэг нь өөрийгөө ч гэсэн хамгаалж байгаа хэрэг гэж би боддог.

Говь-Алтай аймгийн Хөхморьт
сумын ЕБС-н 9а ангийн
сурагч Г.Болорцэцэг.

**Г.БОЛОРЦЭЦЭГ**
Хөхморьт сум, 9а анги

# Хүүхэд хамгаалал миний нүдэнд

Хүүхэд бол гэр бүлийн баяр баясгалан, нийгмийн тулгуур, улс орны ирээдүйг бүтээх хамгийн үнэт баялаг билээ. Тиймээс хүүхдийн эрхийг хамгаалах асуудал зөвхөн төрийн бодлого, хууль тогтоомжоор хязгаарлагдахгүй. Харин гэр бүл, сургууль, олон нийт, хүүхэд бүрийн оролцоогоор бүрдэх ёстой гэж би боддог. Миний нүдэнд хүүхэд хамгаалал гэдэг нь хүчирхийллээс хамгаалах төдийгүй хүүхдэд аюулгүй, эрүүл, аз жаргалтай орчин бүрдүүлж сурч хөгжих, хүсэл мөрөөдлөө биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлэхийг хэлнэ. Хүүхдийн дуу хоолойг үл тоомсорлож, тэдний санал бодлыг сонсдоггүй хандлага нь сул тал юм. Өнөөдөр манай нийгэмд хүүхдийн эрх зөрчигдөх олон асуудал байсаар байна. Зарим хүүхэд сургуулийн орчинд гадуурхалт, дээрэлхэлтийг мэдэрдэг. Зарим нь гэр бүлдээ хайр халамж дутсанаас болж ганцаардал, айдастай үлддэг. Мөн бага наснаасаа ажил хийх, хүнд хөдөлмөрт хүчээр татагдах хүүхдүүд ч байдаг. Эдгээр нь бидэнд хүүхэд хамгааллын чухал сорилтууд юм.

Хүүхдийн эрхийг хамгаалах хамгийн анхны алхам бол тэднийг сонсож ойлгох гэж би үздэг. Жишээлбэл: гэртээ ээж аав хүүхдээ өдөр хэдхэн минут ч болов сонсож ярилцах нь хамгааллын эхлэл. Сургууль дээр найз нөхөд хоорондоо нэгнээ дэмжин гадуурхалгүй хамтдаа хөгжих нь хамгааллын нэг хэлбэр. Түүнчлэн багш нар сурагчдынхаа үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлэх боломж олгох нь маш чухал.

Миний бодлоор хүүхдийн оролцоо хамгааллын гол түлхүүр юм. Хүүхэд өөрийн санал бодлыг илэрхийлж, шийдвэрт оролцож чадвал үедээ өөрийгөө үнэлэгдэж, хамгаалагдаж байна гэж мэдэрдэг. Эцэст нь хэлэхэд миний нүдэнд хүүхэд хамгаалал бол хайр, халамж, итгэмжил, ойлголцлын нэгдэл юм. Хүүхэд бүрийн инээмсэглэл хамгаалагдсан, мөрөөдөл нь биелэх боломжтой нийгэм бол бидний хүсэж буй ирээдүй. Хүүхдийг хамгаална гэдэг нь зөвхөн өнөөдрийн төлөө бус, маргаашийн гэрэлт ирээдүйг хамгаалж буй хэрэг гэж би итгэдэг.

**Б.БАДАМЦЭЦЭГ**
3-р сургууль, 10б анги

## Хүүхэд хамгаалал миний нүдээр

Хүүхэд гэдэг бол гэр бүлийн аз жаргал, улсын ирээдүй, нийгмийн хамгийн үнэт баялаг юм. Хүүхэд бүрт эрүүл аюулгүй орчин хэрэгтэй.

Өсөж том болох насандаа зөв, буруу зүйлийн ялгааг таних мэдлэггүй бүхнийг сонирхож өөрөө оролдож хийж үзэхийг хичээдэг. Энэ үед өсвөр насны сонирхолтой бид хэнтэй ч нөхөрлөж, юу ч хийж, бүхнийг сонирхож явахдаа зөв замаар л залагдаагүй бол нэг хазгай гишгэвэл хүнд маш гүн харанхуй хонгил руу хүчтэй шидэгдэхэд хүргэж байдаг. Нийгмийн өнөөгийн өнгө төрх ямар их зангилаатай харанхуй болсон билээ. Ийм нийгэмд хүүхэд багачуудаа зөв төлөвшүүлнэ гэдэг маш хэцүү. Эцэг эхийн хараа хяналт алдаад өсвөр насны хүүхдүүдтэйгээ ярилцаагүйгээс болж хүүхдүүд маш их хохирдог.

Жил ирэх тусам хүүхдүүд цахим орчинд татагдах нь тэднийг цахим дуурайлал итгэл санаа болон бэлгийн хүчирхийлэл, бэлгийн дарамтад орох эрсдэлд хүргэж байна. Эцэг, эх, асран хамгаалагчид хүүхдүүдтэйгээ ярилцаж сайн найз байж чадалгүйгээс бидний үе тэнгийнхэн цахим орчинтой муу хүмүүстэй нөхөрлөж үр дагавар нь сөрөгөөр л дуусдаг.

Саяхан тохиолдсон бидний гэрт харамсалтайгаар амь насаа алдсан 16 настай охины аймшигт хэрэг ч мөн адил асран хамгаалагчийн хараа хяналт сулаас болсон байх гэж би бодож байгаа. Эцэг, эх, асран хамгаалагч, багш эрт цагтаа энэ хүүхдийг анзаарсан байх байсан. Яагаад гэвэл аав, ээж охиныг сонсож, ойлгож, ярилцдаггүйгээс болж (айлын ганц хүүхэд) дотроо ганцаараа болсон байх. Ийм үед түүнд түшиг болох хүн нь найз нь санагдсан учраас найздаа өөрт хэцүү байгаа зүйлээ ярьж, тэр нийлэн цахим орчинд буруу хүмүүстэй танилцаж найзласнаас болж аймшигт хэргийн суурь ч болсон байж магадгүй. Ийм л ГЭР БҮЛИЙН ОРЧИН, СУРГУУЛИЙН ОРЧИНД хүүхдийг маш сайн анзаарч ойлгох юм болов уу

Хүүхэд, томчуудын хэлснийг л дагах биш, харин өөрийнхөө үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлж, өөрийгөө хамгаалах хэрэгтэй.

Миний бодлоор хүүхэд хамгааллыг бодитой хэрэгжүүлэхийн тулд:

- Эцэг эх хүүхдээ сонсож сурдаг байх
- Нийгэм нийтээрээ хүүхдийг хайрлан хамгаалах хандлагатай байх
- Албан байгууллагын ажилтнууд ч хүүхдийн өсөлт, дүйг ажиглах, хүчирхийлэл гадуурхалтаас сэргийлэх мэдлэгтэй байх
- Хамгийн чухал нь хууль дүрэм гаргах биш, түүнийг бүх хүмүүст эрх тэгш хэрэгжүүлж, үйлчилж байх нь маш чухал.

Өнөөдөр хүүхдийн эрх, хамгааллын талаар олон хууль дүрэм бий. Гэхдээ хууль цаасан дээр үлдэж, бодит амьдралд хэрэгжихгүй байгаа нь "Хууль нь хууль болохоор" мэт санагдана. Энэ үед хүүхэд хамгаалал хоосон үг болж хүүхэд хүчирхийлэл, гадуурхал, үл хайхралд өртөх аюултай. Мөн төрийн байгууллагууд хууль хэрэгжилтийг тогтмол хянаж, зөрчил илэрвэл шуурхай арга хэмжээ авдаг байх нь хамгааллын баталгаа болно. Мөн иргэдийн оролцоо чухал. Хүүхдийн асуудал бол зөвхөн гэр бүлийн биш бүх нийгмийн хариуцлага юм.

Түмэн эцэг, эх та бүхэн хүүхдүүдтэйгээ ярилцаж тэдний дуу хоолойг сонсоорой гэж хүсмээр байна. Харин төр, хууль хяналтын байгууллагууд нь хүүхдийн төлөө гаргасан хуулиа үнэхээр хэрэгжүүлж, цаасан дээр бус амьдрал дээр амьдруулахыг уриалмаар байна. Учир нь хүүхдийн төлөө ажил бүр өнөөдрийн бидний сэтгэлээс хамаарч, маргаашийн Монголын ирээдүйд гэрэл асаадаг билээ. Эцэст нь хэлэхэд, хүүхдийн хамгаалал гэдэг бол зөвхөн өнөөдөр биш, ирээдүйн Монгол Улсаа хамгаалж байна гэж үг юм. Миний нүдэнд хүүхэд хамгаалал бол хайраар дүүрэн итгэлтэй, аз жаргалтай өсөх боломжийг хүүхэд бүрт олгох явдал юм.

Овог: Ганзориг
Нэр: Булгансор
Анги: Төр нийгмийн нэрт зүтгэлтэн Ц. Дашдоржийн нэрэмжит ЗАА-ийн Цээл сумын 11а ангийн сурагч

**Г.БУЛГАНСОР**
Цээл сум, 11а анги

# Хүүхэд хамгаалал миний нүдээр

Хүүхэд бол гэр бүлийн баяр баясгалан, нийгмийн ирээдүй, улс орны хөгжлийн баталгаа юм. Гэхдээ энэ бүхнийг бодит болгохын тулд хүүхэд бүрийг хамгаалах, хайрлах, эрхийг нь хүндэтгэх шаардлагатай гэж би боддог. Миний нүдээр хүүхэд хамгаалал гэдэг нь зөвхөн хүчирхийллээс хол байлгах бус, харин биднийг тэгш эрхтэй, аюулгүй орчинд өсгөхийг хэлнэ. Би сургуульдаа явахдаа тайван, айдасгүйгээр хичээлээ хийж, багш нарынхаа туслалцаа дэмжлэгийг мэдрэхэд хүүхэд хамгааллын үнэ цэнэ илүү тод харагддаг. Гэртээ очиход ээж аавын минь халуун дулаан үг, хайр халамж намайг хамгаалж байгааг мэдэрдэг. Харин зарим хүүхэд гэр бүлдээ хайраар дутдаг, зарим нь сургуулийн орчинд дээрэлхүүлдэг, эсвэл цахим орчинд доромжлолд өртдөг нь үнэхээр харамсалтай.

Тиймээс хүүхэд хамгаалал бол нэг хүний бус, бүх хүний хариуцлага гэж би боддог. Миний харж байгаагаар хүүхэд хамгаалал дараах зүйлсийг агуулдаг: Эрх тэгш боловсрол: Хүүхэд бүр сурч хөгжих эрхтэй байх Эрүүл, аюулгүй орчин: Сургууль, гэр бүл, олон нийтийн орчин хүүхдэд ээлтэй байх Сэтгэл санаа болон бие махбодын хамгаалалт: Ямар ч хэлбэрийн хүчирхийллээс ангид байх Хүүхдийн дуу хоолойг сонсох: Бидний санал, сэтгэгдлийг үнэлж шийдвэрт тусгах Надад хүүхэд хамгаалал гэдэг бол нэгэн төрлийн дулаахан гэрэл шиг санагддаг. Энэ гэрэлд бид айх айдасгүйгээр сурч боловсорч, мөрөөдлөө биелүүлэх замдаа тайван алхах боломжтой. Хэрэв энэ гэрэл бүдгэрвэл олон хүүхдийн мөрөөдөл тасарч, ирээдүй бүдгэрнэ. Харин гэрэл улам тод байвал хүүхэд бүрийн ирээдүй гэгээтэй болж, нийгэмд аз жаргал, хөгжил авчирна.

Эцэст нь хэлэхэд, хүүхэд хамгаалал бол зөвхөн хууль тогтоомжийн хүрээнд бус, өдөр тутмын амьдралд хэрэгжих ёстой ойлголт юм. Эцэг эхийн халамж, багшийн анхаарал, төрийн дэмжлэг, олон нийтийн оролцоо бүгд нийлж байж хүүхэд хамгаалал бүрэн хэрэгжинэ. Хүүхэд бүр хамгаалагдаж, хайрлагдаж, мөрөөдлөө биелүүлэх боломжтой болсноор бидний ирээдүй гэрэлтэй байх болно.

**О.ХИШИГЖАРГАЛ**
МБС, 1-р курс

Хүүхэд хамгаалал миний нүдээр

Хүүхэд хамгаалал миний нүдээр. Төв Аймаг Дэлгэр сумын бүрэн дунд сургууль 12а ангийн Эрдэнэ-Оч.
Хүүхэд бол гэр бүлийн аз жаргал, нийгмийн ирээдүй, үндэсний баялаг юм.
Тэдний тэдний аюулгүй байдал, эрх сайн сайхан байдлыг хамгаалах нь зөвхөн эцэг
эхчүүдийн бус, нийгмийн бүх хүмүүсийн үүрэг гэж би боддог. Миний нүдээр бол
хүүхэд хамгааллыг гэдэг нь хүүхдийг бие махбод, сэтгэл санаа, оюун санааны
аливаа хүчирхийлэл, үл хайхралтаас хамгаалах, тэдэнд эрүүл, аюулгүй
орчин бүрдүүлэх, өөрийн эрхийг мэдэх, хамгаалуулах чадвартай иргэн болгон нь
төлөвшүүлэх явц юм. Өнөөгийн нийгэмд
сэтгэл зовоосон асуудал. Тухайлбал, гэр бүлийн хүчирхийлэл, сургууль дээрх дээрэл-
-хэлт, цахим орчин дахь дарамт зэрэг нь хүүхдийн сэтгэлзүйд гүн шарх үлдээж
болзошгүй. Иймд хүүхдийн эрхийг хамгаалах нь зөвхөн хууль дүрмийн хүрээнд бус,
хүн бүрийн ухамсар, хандлагаас эхэлдэг гэж би үздэг. Би өөрөө сурагчийн хувьд, найзууд
минь сургууль дээр дээрэлхүүлэх, зарим нь гэр бүлдээ анхаарал халамж дутаж
байгааг харах үед хүүхэд хамгааллын асуудал маш чухал болохыг ухаарсан.
Хүүхэд бүр аз жаргалтай, аюулгүй орчинд өсөж хүмүүжих (?) ёстой. Үүнд зөвхөн багш,
эцэг эх төрийн байгууллага бус, бид өөрсдөө ч хариуцлагатай оролцох байх ёстой.
Тухайлбал, найз минь гунигтай байвал асууж, сонсож, түүнийг ~~[illegible]~~ асуудал
хүчирхийлэлд өртөж байгаа анзаарвал итгэлтэй насанд хүрэгчид мэдэгдэх нь өөрөө хүүхэд
хамгааллын оролцоо бий нэг хэлбэр юм. Бид бүгд энэ хүүхдийн хүүхдийн сайн сайхны төлөө
хамтдаа зүтгэх ёстой

**Т. ЭРДЭНЭ-ОЧИР**
Дэлгэр сум, 12а анги

## Хүүхэд хамгаалал. Миний нүдээр

Би 15 настай. Заримдаа хүүхэд байх амархан
эт болов ч үнэндээ хамгийн эмзэг, хамгийн хамгаалалт
эрэгтэй үе юм шиг санагддаг. Энэ насанд хүн өөрийгөө
айж, ертөнцийг шинээр таньж, бусдын хариуар
өрийгөө үнэлж эхэлдэг. Тиймээс хүүхэд хамгаалал
эдэг зөвхөн томчуудын асуудал биш, харин бидний
дөр бүрийн амьдрал дунд оршдог.

Саяхан өсвөр насны охин үеийхэндээ зодуулж нас
барсан тухай сонсоод би маш их бодолд автсан. "Би
тэр охины оронд байсан бол? Хэн намайг хамгаалах
байсан бол" гэж өөрөөсөө асуулаа. Би хүчтэй байж
аддаг ч бүх хүүхэд адилхан биш. Зарим нь дуугүй,
арим нь зоригүй, зарим нь хэт мэдрэмтгий байдаг.
Тийм хүүхдүүдийг хамгаалах нь бидний үүрэг.

Хүүхэд хамгаалал гэдэг нь зөвхөн хууль тогтоомж,
айгууллагын ажил биш. Харин яг амьдралын дунд
мэдрэгддэг зүйл. Найз минь уйлаад сууж байхад
эргэд нь чимээгүй хамт сууж, гэртээ буцаад ирэхэд
ээж минь намайг асууж, сонсож байгаа нь, эсвэл
багш маань нэг үгээр урам өгч байгаа нь - энэ
бүгд өөрөө хамгийн том хамгаалалт болно.

Миний бодлоор хүүхдийг хамгаалах хамгийн эхний
алхам бол хүүхдүүд өөрсдөө нэг нэгнийгээ хамгаалах
явдал. Би өөрөө тэгж хичээдэг. Ангид хэн нэгнийг
шоолоод эхлэхэд би зүгээр хараад зогсохыг хүсдэггүй.
Хэрэв бид бүгд ийм байж чадвал сургуульд дээрэлхэлт

сургахыгаа дагасна гэж бодлоо.

Би ирээдүйд том хүн болохоосоо өмнө өнөөдөр ч өөрийн чадах хэмжээгээр хүүхэд хамгааллын төлөө оролцмоор байна. Хүүхэд бүр айдасгүй, тэгш боломжтой, хайр халамж дунд өсөх ёстой. Миний бодлоор хүүхэд хамгаалал гэдэг нь ирээдүйн тухай мөрөөдөл биш, яг одооноос эхлэх ёстой бодит амьдрал юм.

1-р сургуулийн 10г ангийн Б. Сувд-Эрдэнэ

**Б.СУВД-ЭРДЭНЭ**
1-р сургууль 10г анги

# ХҮҮХЭД ХАМГААЛАЛ МИНИЙ НҮДЭЭР

Хүүхэд бол нийгмийн хамгийн эмзэг бөгөөд хамгаалалт шаардсан бүлэг юм. Ирээдүйн хүн хүч, улс орны хөгжлийн баталгаа болохын зэрэгцээ тэд өөрийгөө бүрэн хамгаалах чадваргүй тул эрхийн зөрчил хамгийн түрүүн өртдөг. Тиймээс хүүхэд хамгаалал бол зөвхөн хууль эрх зүйн хүрээнд бус нийгмийн бүх хүрээ, хувь хүний ухамсар, соёлын төвшинд оршин байх ёстой цогц ойлголт юм.

Хүний эрхийн тухай олон улсын баримт бичгүүдэд хүүхдийн эрхийг хамгаалах асуудлыг онцгойлон тусгасан байдаг. Тухайлбал 1989 онд батлагдсан НҮБ-ын " Хүүхдийн эрхийн конвенц " нь хүүхэд бүрийн амьд явах, хөгжих, хамгаалуулах, оролцох эрхийг бүхэлд нь баталгаажуулсан. Монгол улс уг конвенцийн оролцогч орны хувьд "Хүүхдийн эрхийн тухай хуулийг хэрэгжүүлж буй боловч бодит амьдрал дээр хүүхдийн эрхийн зөрчил түгээмэл байсаар байна. Сургуулийн орчин дахь сэтгэл зүйн дарамт, гэр бүлийн хүчирхийлэл, үл хайхрах байдал нь хүүхийн үндсэн эрхийг ноцтой зөрчиж буй жишээ юм. Хүүхэд хамгаалал бол хүний эрхийн зарчим амьдрал дээр хэрхэн хэрэгжиж буйг хэмжих шалгуур гэж хэлж болно.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын хийсэн судалгаагаар хүүхэд сургуульдаа аюулгүй хамгаалагдсан гэж мэдэрдэг улс орнуудад сурагчдын бүтээлч болон сурлагын амжилт өндөр байдгийг тогтоосон байна. Үүний эсрэгээр хүчирхийлэл, үл хайхралд өртсөн хүүхдүүдийн сэтгэл зүй доройтож, боловсрол эзэмших хүсэл чадавх буурдаг. Монголийн зарим сургуульд сэтгэл зүйч ажиллуулах, хүүхэд хамгааладлын өрөө нээх зэрэг шинэчлэл хийгдэж буй нь зөв алхам хэдий ч хангалтгүй байна. Суралцах орчны аюулгүй байдал нь хүүхэд хамгааллын гол нөхцөл бөгөөд үүнийг хангахгүйгээр боловсролын чанарыг сайжруулах боломжгүй юм.

Хүүхдийг хамгаалах нь зөвхөн өнөөдрийн асуудал бус, маргаашийн нийгмийн хөгжлийг тодорхойлох хүчин зүйл юм. Судалгаагаар бага насандаа хүчирхийлэлд өртсөн хүүхдийн 30 гаруй хувь нь насанд хүрээд хүчирхийлэл үйлдэх магадлал өндөр байдаг бол хайр халамж дор өссөн хүүхэд харин нийгэмд эерэг хувь нэмэр оруулдаг. Асрамжийн газрын хүүхдүүдийг сайн дурынханы оролцоотой дэмжих төслүүдийн үр дүнд тэд сурлагын амжилтаа ахиулж ирээдүйн энэ баримтыг батлаж байна. Иймд хүүхэд хамгаалал бол улс орны ирээдүйд хийгдэж буй стратегийн хөрөнгө оруулалт юм.

Хүүхэд хамгааллыг миний нүдээр харахад, энэ бол хүний эрхийн суурь зарчмийг амьдрахад хэрэгжүүлэх хэрэгсэл, боловсролын чанарын баталгаа, нийгмийн ирээдүйд оруулж буй хамгийн үнэ цэнэтэй хөрөнгө оруулалт юм. Төрийн бодлого, хуулийн хэрэгжилтээс гадна эцэг эх, багш, иргэний ухамсарт орших үнэт зүйл гэдгийг ухамсарлах шаардлагатай. Хүүхэд хамгааллыг бодит амьдрал дээр хэрэгжүүлж чадсан нийгэм л хүмүүнлэг, тогтвортой, хөгжлийн ирээдүйтэй байх болно.

**Н.СОНИНБИЛЭГ**
1-р сургууль 12г анги

## Хүүхэд хамгаалал миний нүдээр

Хүүхэд гэдэг бол ирээдүйн гэрэл гэгээ, маргаашийн нийгмийн тулгуур юм. Бидний эргэн тойронд байгаа бяцхан хүүхдүүдийн инээмсэглэл, тоглож наадах чөлөөт цаг, мөрөөдөлтэй нь хамт тэдний эрхийг хамгаалах, хайрлаж өсгөх асуудал үргэлж яригдах учиртай. Миний нүдээр хүүхэд хамгаалал гэдэг нь зөвхөн хууль дүрэм бус, хамгийн түрүүнд хайр, халамж,анхаарал, юм

Харин таны нүдээр хүүхэд хамгаалал, хүүхдийн эрх гэж юу вэ? Жилд дунджаар хэчнээн хүүхэд хүчирхийлэлд өртдөгийг та мэдэх үү? Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тооцооллоор жил бүр ойролцоогоор 1 тэрбум хүүхэд ямар нэгэн хэлбэрийн хүчирхийлэлд өртдөг байна. Харин UNICEF-ийн 2024 оны мэдээллээр 400 сая орчим бага насны хүүхэд гэр бүлийн хүрээнд хүчирхийлэл, хатуу шийтгэлд тогтмол өртдөг гэсэн судалгаа бий. Бодит тоо үүнээс ч өндөр байх магадлалтай. Учир нь олон хүүхэд айдас, ичгүүрээсээ болж хүчирхийллийг ил гаргадаггүй.

Тэгвэл таны хүүхэд болон таны эргэн тойрны хүүхдүүд хайр халамжтай, аюулгүй орчинд амьдарч, айдасгүй нүдээр инээж чадаж байна уу?

Миний эргэн тойронд зарим хүүхдүүд сургуульд явах боломжгүй, эсвэл гэр бүлийн орчноос шалтгаалан хүчирхийлэлд өртөж байгааг сонсоход сэтгэл үнэхээр өвддөг. Энэ бүхэн хүүхэд хамгааллын ач холбогдлыг улам тод харуулдаг. Миний бодлоор хүүхэд хамгаалал нь зөвхөн төрийн байгууллага, багш сурган хүмүүжүүлэгчдийн үүрэг биш. Ээж аав, ах эгч, найз нөхөд гээд хүн бүрийн оролцоо хэрэгтэй. Хүүхдийн санаа бодлыг сонсох, алдааг нь зэмлэхээс илүү зөв чиглүүлэх, мөрөөдлийг нь дэмжих нь хамгийн том хамгаалалт юм.

Гэвч хүүхэд бүр мөрөөдлөө дэмжүүлж, санаа бодлоо чөлөөтэй илэрхийлж, хүчирхийлэл дарамтгүй орчинд амьдарч чаддаг болов уу? Энэ бол бид бүгдийн өмнө тулгараад буй хамгийн том асуулт юм. Тиймээс та өөрөөсөө нэг асуугаад үзээрэй: Миний хүүхэд айдасгүй нүдээр инээж, аав ээжтэйгээ чөлөөтэй ярилцаж чадаж байна уу? Эцэг эхчүүд бид хүчирхийллийн эсрэг зогсож, хүүхдээ аюулгүй байлгаж чаддаг уу?

Хүүхдийн хүчирхийллийг бууруулахын тулд эхлээд гэр бүлээс эхлэх хэрэгтэй. Эцэг эх хүүхдээ сонсож, хайр халамж өгч, сургууль хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлэх, төр нийгэм хууль журмаа хэрэгжүүлэх нь хамгааллын хамгийн чухал алхам. Харин хүн бүр өдөр тутамдаа хүүхдэд зөлдэг хандаж, зөв үлгэр дуурайл үзүүлж чадвал хүчирхийлэл багасах боломжтой.

Хүүхэд хамгаалал бол бидний ирээдүйн баталгаа. Хүүхдийн инээмсэглэл хамгаалагдаж, айдасгүй нүдээр дэлхий рүү харах боломжтой байхын төлөө өнөөдрөөс эхлэн хүчирхийллийн эсрэг дуу хоолойгоо нэгтгэцгээе!

Говь Алтай аймгийн Баян Уул сумын 12б ангийн сурагч Б. Лхагвамаа

**Б.ЛХАГВАМАА**
Баян-Уул сум, 12б анги

# Хүүхэд хамгаалал миний нүдээр

Нэгдсэн үндэсний байгууллагын хүний эрхийн конвенцид 18 нас хүртэлх бүх хүнийг хүүхэд гэж гэж заасан байгаа.

Хүүхэд бол гэр бүлийн баялаг, улс үндэстний үнэт зүйл юм. Хүүхэд бүр тэгш эрхтэй. Монгол Улсын үндсэн хуульд хүүхэд нь эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, оролцох эрхтэй гэж хуулиар заагаад өгсөн байдаг. Манай улсад эрх нь зөрчигдөж байгаа хүүхдийг хамгаалах үүрэг бүхий албан байгууллага, хүмүүс олон байдаг.

Гэтэл өнөөдрийн нийгэмд эрх нь зөрчигдөж байгаа хүүхэд олон байна. Хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг хүмүүс тухайн нутаг дэвсгэрийнхээ эрх бүрийн эрдмийн судалгаа сайн гаргаж анхаарал татахуйц хүүхдүүдээ илрүүлж ажлаа сайн хийгээсэй гэж хүсэж байна.

Миний бодлоор хүүхэд хамгаалах гэдэг нь томчууд бяцхан үрсээ эрсдэлт хүчин зүйлүүдээс хамгаалах тэднийгээ хайрлах, сайтар сонсож хөгжүүлэхийн эхлэл. Бидний үеийн хүүхдүүд сургуулийн орчин дахь тэнгийн дээрэлхэлт, гэр бүлийн хүчирхийлэл, эцэг эхчүүд, асран хамгаалагчдын үл хайхрах хүчирхийлэлд өртөж эрхээ эдэлж чадахгүй үл хайхрах хүчирхийлэлд өртөж эрхээ эдэлж чадахгүй байна.

Гэр бүлийн гишүүд буюу эцэг эх, асран хамгаалагчид хүүхэдэд хайр халамжаа харамгүй өгч, сургуульд суралцаж, мэдлэг боловсролоо эзэмших нөхцөлөөр хангаж, оюуны өргөнд өсгөж хүмүүжүүлэх үүрэгтэй.
Хүүхэд нэг дүгээрт гэж уриан доор Хүүхдийн байгууллагын хамт олон хүүхэд рүү чиглэсэн үйл ажиллагаа явуулсаар ирсэн.
Манай оронд хүүхэд хамгаалах бодлого их байдаг ч бодит амьдрал дээр хэрэгжихгүй байна. Хүүхдийн асуудлыг хараад өнгөрөх биш харин сонсож, тусалж, ярилцаж, хүмүүжүүлж төлөвшүүлж, хамгаалах нь чухал. Миний нүдээр хүүхэд хамгаалах нь жижиг зүйлээс эхэлнэ.
Хүүхдийн хүмүүжлийн буруу дадал зуршлыг ам болох бага дээр нь засаж өгөхгүй бол явсаар явсаар улам даамжирч засахын аргагүй болно.
Зөв хүмүүжүүлээд төлөвшүүлж хүүхдээ сонсож, хүүхдээ дэмжиж, хүүхдээ хайрладаг сэтгэлтэй байх нь хүүхдээ хүн болгоход оруулж буй хамгийн том хувь нэмэр юм.
Хэрвээ бид ингэж чадвал иргэн бүрийн зөв хүмүүжилтэй, зөв төлөвшилтэй, зөв хүн болгон төлөвшүүлж, илүү сайхан нийгмийг бүтээж чадна.

Хаяг: Говь-Алтай аймгийн
Ерөнхий боловсролын 2-р сургуулийн
9в ангийн сурагч М. Янжинлхам

**М.ЯНЖИНЛХАМ**
2-р сургууль, 9в анги

Хүүхэд хамгаалах миний нүдээр

Хүн бүрийн амьдралын хамгийн үнэ цэнтэй, хамгийн эмзэг үе бол хүүхэд нас юм. Энэ үеийг хайр халамж, аюулгүй орчин, боловсролын дэмжлэг дунд өнгөрүүлэх нь хүүхдийн ирээдүйн суурь болдог. Тиймээс хүүхэд хамгаалах асуудал зөвхөн эцэг эх, сургууль, төр засгийн биш — хүн бүрийн оролцоо, ухамсар, хариуцлагатай холбоотой асуудал гэж би үздэг. Би өөрөө ч энгийн нэгэн иргэн хүний нүдээр харвал "хүүхэд хамгаалал" гэдэг нь том онол, хууль дүрэм гэхээс илүү өдөр тутмын энгийн үйлдлээс эхэлдэг зүйл юм. Хүүхэд хамгаалах гэж юу вэ? Хүүхэд хамгаалах гэдэг нь хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөг, ялгаварлалт, хайхрамжгүй байдал, үл тоомсорлолоос урьдчилан сэргийлэх, тэдэнд аюулгүй, хайр энэрэлтэй орчин бүрдүүлэх бүхий л арга хэмжээг хэлдэг. Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хуульд "хүүхэд хамгаалал" нь төр, иргэн, байгууллага, гэр бүл хамтдаа хэрэгжүүлэх ёстой хариуцлага гэж заасан байдаг. Хүүхэд хамгаалал зөвхөн хүчирхийлэл гарсны дараа оролцох биш, харин гаргахгүй байхаар урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа гэдгийг бид ойлгох ёстой. Үүнд эцэг эхийн анхаарал халамж, нийгмийн хандлага, орчны аюулгүй байдал, боловсрол, мэдээлэл хүртээмжтэй байдал бүгд ордог. Миний оролцсон нэг бодит жишээ Хүүхэд хамгаалах сэдэв надад анх энгийн нэгэн өдөр амьдрал дээрээс хүчтэй туссан юм.

Манай хороонд 9 настай нэг хүү байлаа. Түүнийг би тогтмол орцонд ганцаараа сууж байгааг хардаг байсан. Заримдаа хувцас нь хиртэй, цүнх нь урагдсан байдалтай сургуульдаа явж ирдэг байсан нь анзаарагдсан. Эхэндээ би энэ бүхнийг анзаарсан ч "гэрийн асуудал байлгүй дээ" гэж бодоод өнгөрдөг байв. Гэвч нэг өдөр тэр хүү уйлж байгааг олж харсан нь надад бодлогошруулсан дохио болсон. Түүнтэй ярилцаж үзэхэд, ээж нь ажилгүй, архины асуудалтай, аав нь гадаадад ажиллаж байгаа, өөрийг нь ихэнхдээ орхидог тухай ярьсан. Заримдаа хоолгүй хонодог, сургуулийн хичээлээ хийж чаддаггүй, бусад хүүхдүүдийн доромжлолд өртдөг гэж хэлсэн нь сэтгэл шимширмээр байсан. Энэ тохиолдолд би зүгээр харж суух биш, арга хэмжээ авах ёстой гэж шийдсэн. Эхлээд сургуулийн багштай нь ярилцаж, дараа нь хорооны нийгмийн ажилтанд хандсан. Ингэснээр хүүг хорооны "эрсдэлтэй хүүхдийн бүртгэлд" оруулж, түр хамгаалалт болон дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авсан. Ээжтэй нь уулзалт хийж, архинаас гарах хөтөлбөрт хамруулах санал тавьсан бөгөөд хүү сургуульдаа хоолны тусламж, хичээлийн хэрэгсэл авдаг болсон. Энэ явдал надад нэг том сургамж өгсөн Хүүхэд хамгаалах гэдэг нь "хүний асуудал" биш, харин миний ч үүрэг юм. Хэрвээ тэр үед би зүгээр өнгөрөөсөн бол магадгүй тэр хүүгийн амьдрал өөр зүгт эргэх байсан байж мэднэ. Хүүхэд хамгааллын асуудал биднээс эхэлдэг Бид хүүхэд хамгааллыг зөвхөн төрийн байгууллагаас хүлээх хандлагатай байдаг. Гэтэл хүүхдийг

хүчирхийллээс хамгаалах эхний хамгаалалтын шугам бол эцэг эх, гэр бүл, хөрш, найз нөхөд, багш нар юм.

Миний бодлоор дараах гурван зүйл хамгийн чухал. Анзаарах – Хүүхдийн зан ааш, сэтгэл санаа, хувцас хунар, биеийн байдал, суралцах чадварт гарч буй өөрчлөлтийг анзаарах. Жишээ нь, гэнэт дуугүй болох, айдастай болох, шархтай ирэх зэрэг нь хүчирхийллийн шинж байж болно. Сонсох – Хүүхдийн хэлэх гэж буй зүйлийг үл ойшоохгүй, хүлээцтэйгээр сонсох. Заримдаа тэдэнд зүгээр нэг хүн сонсоно гэдэг маш том хамгаалалт болдог. Үйлдэх – Хэрвээ хүүхэд эрсдэлд байгааг анзаарсан бол зохих байгууллагад мэдээлэхээс бүү ай. Энэ нь хов биш, харин хүний амьдрал аварч болох алхам юм. Хүүхэд хамгааллын өнөөгийн сорилт Монголд хүүхдийн эсрэг хүчирхийллийн тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа нь анхаарал татаж байна. Хүчирхийлэл зөвхөн бие махбодийн бус, сэтгэл зүй, цахим орчин дахь дарамт ч багтдаг. Зарим эцэг эх хүүхдээ "сургах" нэрээр зоддог, сургууль дээр үе тэнгийн дарамт хүчтэй байдаг, цахим сүлжээнд хүүхдүүд хорт мэдээлэлд өртдөг гэх мэт олон асуудал бий. Нөгөө талаар олон эцэг эх ажлын ачааллаас болж хүүхддээ цаг гаргадаггүй, анхаарал халамж дутагдсанаас хүүхэд ганцаардалд ордог. Энэ нь дарамт, хүчирхийлэлд өртөх суурь шалтгаан болж өгдөг. Миний уриалга Би хүүхэд хамгааллыг зөвхөн асуудал гарсны дараа бус, урьдчилан сэргийлэх соёл гэж хардаг. Хэрвээ бид бүгд доорх гурван зарчмыг баримталбал хүүхэд хамгааллын орчин улам сайжирна гэж итгэдэг: "Хүүхэд бол ирээдүй" гэдэг үгийг хий хоосон уриа биш, өдөр тутмын үйлдлээр батлах.Хүүхэдтэй харилцахдаа насанд хүрэгчдийн хэмжүүрээр биш, хүүхдийн нүдээр харж ойлгох.Хүүхдийн төлөө дуугарахаас бүү ай – мэдээлэл өгөх, анхааруулах, туслах нь буруу биш Хүүхэд хамгаалах гэдэг нь том, хэцүү зүйл мэт боловч үндэсдээ бидний өдөр тутмын анхаарал, хайр, хариуцлагаас эхэлдэг. Би өөрөө нэг хүүгийн амьдралд багахан өөрчлөлт хийж чадсан шиг, хүн бүр өөрийн хүрээнд оролцвол олон хүүхдийн амьдрал өөрчлөгдөх боломжтой. Хүүхэд хамгаалал бол ганц хүний үүрэг биш, харин бүх нийтийн хариуцлага юм. Хүүхдийн иннэмсэглэл бүхэн хамгаалагдсан байх ёстой. Миний нүдээр харвал хүүхэд хамгаалах гэдэг нь зүгээр нэг хууль, бодлого бус, харин сэтгэлтэй иргэн бүрийн хийж чадах хамгийн ариун үүрэг юм.

**Э.ГАРАВСҮРЭН**
МБС, 1-р курс

Хүүхэд хамгаалал миний нүдээр

Өнөө үед хүүхдийн эрх маш их зөрчигдөж байна. Үе тэнгийн дарамт, гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүл ба үе тэнгийн үл тоомсорлол гадуурхал гэх мэт. Эдгээр асуудлыг таслан зогсоохоор улс, боловсролын яам, аймгийн засаг газар сургуулиуд ажиллаж байна. Гэвч тусгай хэрэгцээт хүүхдүүдийн талаар мартсан мэт тэдэнд зориулсан арга хэмжээ үйл ажиллагаа ховорхон явагдаж байна. Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн алхам тутамд бэрхшээл саад тулгардаг.

Жишээ нь: Манай аймагт тусгай хэрэгцээт хүүхдүүдэд зориулсан сургууль цэцэрлэг байхгүй манай аймагт ч бүс бусад аймгууд Улаанбаатарт хүртэл маш хол. Тэгвэл хэрхэн яаж сурах вэ? Энгийн хүүхдүүдтэй хамт сурлаа гэж бодоход яаж [illegible] орох вэ? шатаар яаж гарах вэ? ангийнхан нь түүнд хэрхэн яаж хандах бол? Гадуур явья яаж дугуйр орох вэ? удамт тойбигаар чөлөөтэй явж чадах уу? Эмнэлэг хүртэл тэдэнд зориулсан шатгүй шүү дээ!

Хараагүй бэрхшээлтэй хүн авах зайч үгүй тэдний хувьд амьдрал бартаа саадаар дүүрэн байна. Эдгээр асуудлыг хэрхэн яаж шийдэх вэ? Олон нутаг улсаас тусгай хэрэгцээт хүүхдүүдэд тусламж дэмжлэг үзүүлэх.

тээврийн хэрэгсэл зам шат зэргийг тэдэнд зориулан засварлах эрүүл мэндийн байгууллага сургуулийг зэрэг тэдэнд анхааран тэдэнд тус болох орчинг бусад хүүхдүүдийн адилаар мэдрэхэд нь туслах, ялгаварлан гадуурхалгүй хандах орчныг гэх мэт. Хүүхдүүд бид мөн тэднийг бас тэдний өрөвдөх, тэтгэж шууд ойлгох туслах гэх мэт Монгол улсын үндсэн хуулийн 19-р зүйлд зааснаар хүн бүр үндсэн боловсролыг үнэ төлбөргүй эзэмших эрхтэй тэд үнэгүй эзэмшиж чадаж байна уу? 24-р зүйл эрүүл мэндийг хамгаалуулах эрх, тэдэнд зориулсан эмнэлгийн үйлчилгээ бий юу? 34-р зүйл нийгмийн фондоо хамгаалуулах эрх тэд нийгмийн үйл ажиллагаанд чөлөөтэй оролцож байгаа юу? Нийгмийн байгууллагуудад чөлөөтэй үйлчлүүлж чадаж байна уу? Сургуулийн орчинд ялгаварлан гадуурхалтаас ангид байна уу? Хүн бүр адил тэгш эрхтэй тэгвэл тэд бидэнтэй адил эрх эдэлж чадаж байна уу? Хэтэн хүртэй байгаадаа эрх чөлөөтэй байхад, Эрх чөлөө гэдэг үг тэдэнд дэндүү хол санагддаг байх. Бидний тусламж тэдэнд хэрэгтэй байна тусламжийн гараа харамгүй сунгаарай

**Б.СУВДМАА**
1-р сургууль, 10д анги

## Хүүхэд хамгаалал миний нүдээр

Хүүхэд бүр хүчирхийллээс хамгаалагдах эрхтэй ч Монголд энэ эрх хэрэгжилтийн талаар бодит нөхцөл байдал хангалтгүй хэвээр байсныг харуулсан 16 настай Ч.Шинэхоран охины амь нас хүчирхийлэгдэж алдсан хэрэг олон нийтийг цочирдуулсан. Энэ явдал хүүхдийн эрх хамгааллын тогтолцоо сул байгааг бодитоор харуулсан жишээ болсон.

Бид хүүхдийг зөвхөн гэр бүлдээ төдийгүй сургуулийн орчин, олон нийтийн дунд ч хамгаалах ёстой. Шинэхоран охины хэрэг гарсан нь зөвхөн нэг охины эмгэнэл бус бүх хүүхдийн амар амгалан өсөх орчин алдагдсаны дохио байсан. Хэрэв хамгааллын систем илүү шуурхай хүрэлцээтэй бас цагдаа, хүчирхэж илүү ажиллах орчин хангасан байсан бол ийм хэргүүд гарахгүй байсан.

Миний бодлоор хүүхэд хамгаалал гэдэг бол зөвхөн хүчирхийллээс хамгаалах бус хүүхдийн сэтгэл зүй, аюулгүй орчин бүрдүүлэх явдал. Хүүхэд бидний санал бодлыг сонсож тэдний хүндэтгэж харьцах нь хамгийн чухал алхам юм. Ч.Шинэхораны хэрэг бидэнд нэгийг сануулсан "Хүүхэд хамгаалал бол албан байгууллагын үүрэг төдийгүй бүх нийгмийн хамтын хариуцлага юм. Түүнээс зөвхөн энэ хэргийн талаар л авч үзэн боловч дурдагдаагүй бидний мэдэхгүй маш олон асуудлууд бий.

Тиймээс би хүүхэд хамгааллыг зөвхөн нэг бодлого бус хүн бүрийн зүрх сэтгэлд асаасан гал байх ёстой гэж бодсон. Хүүхэд бүр хамгаалагдсан нийгэм хамгийн шударга хүчтэй нийгэм шүү.

**В.АНГИРМАА**
Дэлгэр сум, 11а анги

## Тусгай хэрэгцээт хүүхдийн асуудлууд

Бид хүүхэд бүрийг адилхан үнэ цэнтэй гэж боддог атлаа үнэндээ тэднийг бүгдийг нь ижил боломжтой байлгаж чаддаг уу ? Хичээлийн танхимд ижил мөрөөдөлтэй сууж байгаа ч зарим нь илүү их саадтай , илүү их дэмжлэг шаарддаг нь нууц биш. Тэд бол нийгмийн нэгэн чухал хэсэг болсон тусгай хэрэгцээт хүүхдүүд билээ. Тэднийг "өөр " гэж харах бус, бусдын адил мөрөөдлөө биелүүлэхэд нь шаардлагатай нэмэлт дэмжлэг , хүртээмжтэй орчинг бүрдүүлэх хэрэгтэй гэдгийг нэг бодоод үзээрэй.

Тэгвэл Монгол улсад тусгай хэрэгцээт хүүхдүүдэд тулгамдаж буй түгээмэл асуудлуудыг дурдъя.

1. Мэргэжлийн багшийн дутагдал
2. Нийгмийн оролцоо тэгш боломж
3. Орчны ээлгүй байдал

Тусгай хэрэгцээт хүүхдүүдэд боловсрол олгоход хамгийн чухал хүчин зүйл бол мэргэшсэн тэдний онцлогийн ойлгох багш нар билээ.Сүүлийн 5 жилийн хугацаанд Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн "Тусгай хэрэгцээт боловсролын багшийн" ангийн 148 оюутан төгссөний ихэнх нь өндөр цалинтай хувийн сургуульд ажиллахыг сонгож байгаа гэсэн мэдээлэл нь улсын сургуульд багшийн орон тоо дутуу дулимаг байгааг харуулж байна. Мөн Монгол улсад сүүлийн жилүүдэд "тэгш хамруулах боловсрол"-н бодлого хэрэгжиж байгаа ч ихэнх нь мэдлэг , арга зүй дутмаг хэвээр байна гэсэн судалгаа байна.2021 онд БШУЯ-ны хийсэн судалгаагаар ерөнхий боловсролын сургуулийн багш нарын 60 орчим хувь нь тусгай хэрэгцээт хүүхдэд хичээл заах арга зүйн сургалтад хамрагдаагүй байсан нь энэ асуудлын талаарх ойлголт нийгэмд ялангуяа багш нарт бага байгааг харуулж байна.

Үүнийг шийдвэрлэхийн тулд багш нарыг жил бүр тусгай хэрэгцээт боловсролын сургалт семинарт тогтмол хамруулж , цахим гарын авлага , зөвлөмжийг хэрэглэхийг уриалах гэх мэт шийдлүүдийг тусгаж өгч болно.

Өнөөдөр олон нийтийн дунд тусгай хэрэгцээт хүүхдүүдийг "өөр" гэж хүлээн авах хандлага хүчтэй хэвээр байна. Энэ нь хүүхдийн өөртөө итгэх итгэлийг бууруулахаас гадна гэр бүл эцэг эхчүүдийг ч хэцүү байдалд оруулдаг. 2020 онд хийсэн "Хүүхэд хамгааллын үндэсний судалгаанд "тусгай хэрэгцээт хүүхдүүдийн 40 орчим хувь нь сургууль цэцэрлэгийн орчинд ялгаварлан гадуурхалт мэдэрсэн гэсэн байна. Ийм нөхцөлд хүүхэд өөрийгөө илэрхийлэх сурч хөгжих боломжоо алддаг төдийгүй нийгмийн үнэт зүйл болох хүнлэг чанар алдагддаг.

Харин сургууль бүрт "тэгш хамруулах клуб "-г байгуулан идэвхтэй хөгжүүлж бие биенээ ойлгож дэмжихэд сургах нь хамгийн наад захын шийдэл гэж бодож байна.

Тусгай хэрэгцээт хүүхдийн хөгжлийг хамгийн ихээр хязгаарлаж буй нэг хүчин зүйл бол сургалтын болон олон нийтийн орчны хүртээмжгүй байд л юм. Өнөөдрийн байдлаар нийслэл болон аймгийн сургуулиудын дийлэнх нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээнд нийцсэн шат, зам,тусгай тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдаагүй байна. 2022

онд хийсэн Хүүхэд хамгааллын үндэсний судалгаанд тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдийн талаас илүү хувь нь сургалтын орчиндоо саадтай тулгардаг гэж хариулсан байна. Хүүхэд танхимд орохын тулд хэт өндөр шат давах шаардлагатай байвал эсвэл сурах хэмжигдэхүүн нь тэдэнд тохироогүй бол боловсролын тэгш эрхийн тухай ярих боломжгүй юм. Орчны хүртээмжийг шийдвэрлэхгүйгээр хүүхдэд "адилхан боломж "олгож байгаа мэтээр ярих нь хоосон уриа лоозон болж хувирна. Энэ нь зөвхөн хичээлд хамрагдах эрхэд нь бус нийгмийн идэвхтэй оролцоонд нь ч хүчтэй саад болдог.

Үүнийг шийдвэрлүүлэхийн тулд бид шинээр баригдах болон засвар хийгдэх сургууль цэцэр лэгийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй стандартаар төлөвлөх журам байдаг хэдий ч бодит амьдрал дээр хэрэгжиэлтгүй учраас үүнийг илүү дэмжих хэрэгтэй гэж бодож байна.

Эдгээр асуудлууд хоорондоо уялдаа холбоогүй мэт боловч зайлшгүй нэгнээсээ харилцан хамааралтай байна.

Тусгай хэрэгцээт хүүхдийн хөгжлийг дэмжих нь зөвхөн нэг хүүхдийн амжилт биш та бидний ирээдүйн хүнлэг нийгмийн чанарыг тодорхойлох чухал алхам билээ. Багахан тус дэм зөв ойлголт нь тэдний ирээдүйг гэрэлтүүлэх том гэрэл болж чаддаг. Иймээс хүүхэд бүрт мөрөөдлөө биелүүлэх боломжийг олгоход туслах нь бидний хамтын үүрэг мөн.

**Д.УРАНГОО**
1-р сургууль, 12г анги

# Хүүхэд хамгаалал миний нүдээр

Дэлхий дээрх хамгийн ариун нандин үнэт зүйл бол хүүхэд. Хүүхэд гэдэг бол зөвхөн өнөөдрийн инээмсэглэл биш, маргаашийн гэрэл гэгээ, ирээдүйн гэрэлт итгэл билээ. Тийм ээ тэднийг хамгаалах, хайрлан өсгөх, зөв хүн болгон төлөвшүүлэх нь зөвхөн эцэг эхчүүдийн үүрэг биш, бүхэл бүтэн нийгмийн, бүх хүн төрөлхтөний хамтын хариуцлага юм.

Би хүүхэд хамгааллын тухай бодохоор хамгийн түрүүнд өөрийн амьдралдаа харсан зүйлс санаанд ордог. Бага насанд минь миний ээж, аав маань дулаахан хувцас өм-сгөн, халуун хоолоор цатган, сургуулийн жилд явахад минь өглөө бүр хүргэж өгч, тарахад минь халуун дулаан хайр энэрлээр тосдог байсан. Энэ бол энгийн мэт боловч үнэн хэрэгтээ хүүхэд хамгааллын үндсэн илэрхийлэл. Хүүхдийг хоолтой, хувцастай, сургуультай байлгах нь хамгийн энгийн хамгаалалт. Гэхдээ энэ бүхнийг хүртэж чадахгүй олон хүүхэд бий. Энэ тухай бодохоор сэтгэл минь хөдөлж "Би юу хийж чадах вэ?" гэсэн асуулт үргэлж сэтгэлд хадаатай үлддэг. Хүүхэд хамгаалал гэдэг ойлголт зөвхөн хү-чирхийллээс хамгаалах биш хүүхдийн сэтгэл зүйг ойлгох тэдэнд сонсогдох боломж олгох, мөрөөдлийг нь дэмжих өө-рийгөө илэрхийлэх орон зай бүрдүүлэхийг ч хэлдэг.

Тиймээс хүүхэд хамгаалал гэдэг миний бодлоор гурван том баганад дээр тогтдог гэж үздэг. Нэгдүгээрт гэр бүлийн халуун хайр. Эцэг эхийн анхаарал дэмжлэг нь хамгийн наад захын хамгаалалт. Хоёрдугаарт сургуулийн орчин, багш

нэр хүүхдийг зөв хүн болгон төлөвшүүлэхийн үүрэгт тэдэнд хамгаалалт өгөхөө мэдэхгүй. Гурвуулаагаа ... лагаа. Энэ үгэнд бодогдуулсаар бүхэн хүүхдийн төлөө үүргээ болгож өгөх нь хамгаалалтын чухал хэсэг.

Өнөөдөр мэдээллийн эрин үед хүүхдүүдийн аюул гэр үйлс цахим орчинд олон эрсдэл нуугдаж байна. Хуурамч найз, дарамт-лал, гэмт хэргийн уриалга гэх мэт. Энэ бүхэн хүүхэд хамгааллын шинэ сорилт болсон. Миний өнцгөөс харахад хүүхдийг зөвхөн гудамжинд хамгаалах биш цахим орчинд ч хамгаалах нь зайлшгүй хэрэгтэй. Тэдэнд цахим соёл, зөв хэрэглээ-ний талаар зааж, эрсдлийг мэдрэх чадвар суулгах нь эцэг эх, багш нарын хамтын үүрэг. Хүүхэд хамгаалал бол зөвхөн өнөөдрийн асуудал биш, ирээдүйн баталгаа юм. Хэрэв өнөөдөр бид хүүхдүүддээ анхаарал хандуулж, итгэл өгч чадвал маргааш тэд эрүүл мэндээ анхаарч, эрүүл саруул, ухаалаг, зөв хүн болж төлөвшинө. Харин хамгаалалтгүй хайраар дутагдсан хүүхдүүдийн дотор зөрчил гуниг үлдэж тэр нь нийгэмд сүүдэр болж үлдэнэ. Энэ бол бидний ирээдүйд хэзээ ч үл хүсэх дүр зураг.

Эцэст нь тэднийг итгэлтэй мөрөөдлөө дагаж явахад нь дэмжих нь бидний хийх ёстой ажил. Учир нь хүүхдийн инээмсэглэл бол бидний ирээдүйн замын гэрэл юм. Тэгж л ирээдүйн Монгол улс итгэл-тэй, гэрэлтэй, хүчит нийгэм болж хөгжинө.

**Т.СЭРГЭЛЭН**
2-р сургууль, 12а анги

# Хүүхэд хамгаалал миний нүдээр

Хүүхэд бол ирээдүйн нийгмийг тодорхойлох хүмүүс буюу нийгмийн голь юм. Тиймээс хүүхэд бидний эрх , аюулгүй байдал, хөгжил нэгт тавигдах ёстой гэж би бодож байна. Хүүхэд бүр аюулгүй орчинд өсөх эрхтэй. Үүнд гэр бүлийн үүрэг их чухал хүүхдийг боловсрол эзэмшүүлэхийн тулд эхлээд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлж дараа нь ерөнхий боловсролын сургуульд сургаж тэгээд их дээд сургуульд сургах хэрэгтэй. Дан сур гэж шаардалгүй хажуугаар нь цуг хөгжилдөж хайрлаж дуртай чиглэлээр нь явуулж хүүхэдтэйгээ ярилцах хэрэгтэй Үүнд бас дан гэр бүл гэлгүй сургууль бас маш чухал. Сургууль бол зөвхөн хичээл заадаг газар биш харин хүүхдэд хүмүүжил, хөгжил, боловсролыг олгох орчин юм Багш, сургуулийн ажилтан хүүхдийн эрхийг хүндэтгэж, гадуурхалт, дээрэлхэлтээс хамгаалах, аюулгүй орчныг бүрдүүлэх нь чухал. Мөн ар гэрийн асуудалтай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд тохирсон орчин, хичээл заах арга ,хэрэгслийг бэлтгэх шаардлагатай. Миний дүгнэснээр хүүхэд хамгаалал гэдэг бол зөвхөн нэг байгууллагын биш, бүх хүмүүс ба нийгмийн хамтын ажиллагаа. Хүүхэд бүр хайрлагдаж, аюулгүй, эрх чөлөөтэй, тэгш боломжтой орчинд өсөх нь чухал гэж бодож байна. Маш олон хүүхдүүдийн эмтэрсэн сэтгэл шархалсан зүрхийг засахын тулд би юу хийж чадах билээ гэж боддог байсан хэдий би одоо сурагч ч гэсэн ирээдүйд мянга мянган хүүхдэд туслахын тулд би одооноос хичээх болно.Ямар нэгэн асуудалтай хүүхдүүдэд тусалж дуу хоолойгоо нэгтгэдэг хүмүүст гүнээ талархаж байна.

**М.БУЛГАНТАМИР**
2-р сургууль, 9в анги

Хүүхэд хамгаалал миний нүдээр

Оршил Хүүхэд бол улс орны ирээдүй, нийгмийн хамгийн үнэт баялаг юм. Хүүхэд бүр эрүүл, аюулгүй орчинд өсч, сурч боловсрох, хайр халамж хүртэх, өөрийн дуу хоолойгоо илэрхийлэх бүрэн эрхтэй. Гэвч дэлхий дахинаа болон манай улсад хүүхдийн эрх зөрчигдөх, хамгаалал дутмаг байх тохиолдол харамсалтайгаар байсаар байна. Хүүхэд хамгаалал гэдэг нь зөвхөн төр засгийн үүрэг биш, харин гэр бүл, сургууль, нийгмийн бүх гишүүдийн хамтын оролцоотой хэрэгждэг хариуцлагатай үйл явц юм. Миний нүдээр хүүхэд хамгаалал гэдэг бол зүгээр нэг хууль дүрэм биш, харин хүн бүрийн сэтгэл, хайр, анхаарал, итгэл дээр тулгуурласан хамгийн ариун, хүнлэг үйл хэрэг юм. Хүүхэд хамгааллын тухай ойлголт Хүүхэд хамгаалал гэдэг нь хүүхдийн эрхийг хүндэтгэж, тэднийг аливаа хэлбэрийн хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрах байдал, дарамт шахалтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах тогтолцоо, үйл ажиллагааны цогц юм. Хүүхэд хамгаалал нь зөвхөн хүчирхийллээс хамгаалах төдий бус, харин тэднийг бүх талаар хөгжих, аюулгүй орчинд амьдрах, сэтгэл санааны хувьд тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэдэг.

Миний бодлоор хүүхэд хамгаалал нь гурван түвшинд хэрэгжих ёстой. 1. Гэр бүлийн түвшин: Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдэдээ анхаарал халамж тавьж, сэтгэл санааг нь дэмжих, итгэлцлийг бий болгох. Хүүхэдтэйгээ ярилцаж, санал бодлыг нь сонсох нь хамгааллын хамгийн анхан шат юм. 2. Сургуулийн түвшин: Сургуулийн орчинд хүүхэд аюулгүй байх ёстой. Багш, ажилтнууд хүүхдийн эрхийн талаарх мэдлэгтэй, ёс зүйтэй байх нь чухал. Хүүхдийг гадуурхах, дарамтлах, дээрэлхэх үзэл суртал байх ёсгүй. 3. Нийгмийн түвшин: Төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран хүүхдийн эрхийг хамгаалах бодлого хэрэгжүүлэх, хууль журмыг чанд мөрдөх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь нэн шаардлагатай. Иймээс хүүхэд хамгаалал бол ганц байгууллага, эсвэл нэг гэр бүлийн асуудал биш, харин нийт нийгмийн хамтын хариуцлага юм. Өнөөгийн нөхцөл байдал ба тулгамдсан асуудлууд Өнөөдөр дэлхий даяар, тэр дундаа манай оронд ч хүүхдийн эрх зөрчигдөх, хамгаалал хангалтгүй байх олон шалтгаан бий. Зарим гэр бүлд эдийн засгийн хүндрэлийн улмаас хүүхэд анхаарал халамж дутмаг орчинд амьдарч байна. Зарим тохиолдолд хүүхэд гэр бүлийн хүчирхийлэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдлын хохирогч болдог. Сургууль, цэцэрлэгийн орчинд ч мөн хүүхдүүд бие биедээ дээрэлхэх, гадуурхах үзэл гаргах нь түгээмэл болсон. Энэ нь хүүхдийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж, айдас, гуниг, өөрийгөө үнэлэх чадвар буурах зэрэг сөрөг үр дагавар авчирдаг. Хүүхэд хамгаалал сул байснаар тэдний боловсрол, хөгжлийн чанар, ирээдүйн итгэл алдагдаж, улмаар нийгэмд итгэх итгэл сулрах аюултай. Хүүхэд хамгааллын тогтолцооны сул тал нь зөвхөн төрийн хяналт хангалтгүй байгаагаас бус, олон нийт, иргэдийн хандлага, ойлголт дутмаг байгаатай ч холбоотой. Зарим хүмүүс хүүхдийн эрх зөрчигдөж байгааг "хүүхэд хүмүүжүүлэх арга" гэж ойлгодог нь буруу. Жишээлбэл, "хүүхдийг зодож хүмүүжүүлнэ", "томчуудын үгнээс гарахгүй байх ёстой" гэх хуучин үзэл өнөө ч байсаар байна. Гэвч ийм

хандлага нь хүүхдийн эрхийг ноцтой зөрчиж, тэдний сэтгэл зүй, ирээдүйд сөргөөр нөлөөлдөг. Иймээс хүүхэд хамгааллын асуудлыг зөвхөн хуулиар бус, соён гэгээрүүлэх, олон нийтийн боловсрол, мэдээллээр хангах замаар шийдвэрлэх нь чухал. Хүүхэд хамгаалалд миний байр суурь, санал Миний нүдээр хүүхэд хамгаалал гэдэг нь хайр, итгэлцэл, ойлголт дээр тулгуурласан харилцаа юм. Хүүхдийг хамгаална гэдэг нь тэднийг хүчирхийллээс хол байлгах төдий бус, харин тэднийг сонсох, дэмжих, итгэх гэсэн үг. Нэгдүгээрт, гэр бүлийн оролцоо хамгийн чухал. Эцэг эх хүүхдэдээ "чи үнэ цэнэтэй хүн" гэдгийг мэдрүүлэх, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх нь хамгааллын үндэс юм. Хүүхэдтэйгээ ярилцаж, санаа зовнилыг нь ойлгож, хамтдаа шийдвэр гаргах дадал бий болгох хэрэгтэй. Хоёрдугаарт, сургууль, боловсролын байгууллагууд хүүхэд хамгааллын орчин бүрдүүлэх үүрэгтэй. Багш, ажилтнууд хүүхдийн дуу хоолойг сонсож, хүндэтгэлтэй харилцах, ялгаварлан гадуурхахгүй байх, дээрэлхэлтийн эсрэг бодлого хэрэгжүүлэх шаардлагатай. Гуравдугаарт, нийгмийн оролцоо зайлшгүй. Хүүхдийн эрхийг хамгаалах төрийн бус байгууллагууд, сайн дурынхан, олон нийтийн хэвлэл мэдээлэл бүгд мэдээлэл түгээж, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулах ёстой. Хүүхэд хамгааллын талаарх мэдлэгийг өсгөх сургалт, хөтөлбөрүүдийг байнга зохион байгуулах нь үр дүнтэй. Миний бодлоор хүүхэд хамгаалалд технологийн аюулгүй байдал ч мөн багтана. Өнөөдөр хүүхдүүд цахим орчинд их цаг зарцуулдаг болсон. Иймээс кибер дээрэлхэлт, буруу мэдээлэл, цахим мөлжлөгөөс хамгаалах талаар хүүхдэд мэдлэг олгох, эцэг эхийн хяналт сайжруулах шаардлагатай.

Мөн сэтгэл зүйн дэмжлэг нь хамгааллын чухал хэсэг. Хүүхэд айдас, гуниг, ганцаардлыг мэдрэхэд хэн нэгэн түүнийг сонсож, ойлгож, дэмждэг байх хэрэгтэй. Сургуулиудад сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг багш, мэргэжилтнүүдийн тоог нэмэгдүүлэх нь зүйтэй. Хүүхэд хамгааллын бодит үр дүн гарахын тулд төр, эцэг эх, багш, нийгмийн байгууллагууд хамтран ажиллах ёстой. Хүүхдийн асуудалд хөнгөн хандах бус, хүн бүр хариуцлагатай оролцох нь хамгааллын тогтолцоог бэхжүүлнэ. Дүгнэлт Хүүхэд хамгаалал бол зөвхөн хууль дүрмийн хүрээнд хязгаарлагдах ойлголт биш, харин хүн бүрийн сэтгэл, хандлага, ухамсартай холбоотой хүнлэг үйл хэрэг юм. Хүүхэд бүрийн аз жаргал, итгэл, инээд бол нийгмийн хөгжил дэвшлийн илэрхийлэл. Хэрвээ бид хүүхдүүдээ хамгаалж адвал, ирээдүйдээ итгэлтэй, ухаалаг, хайр энэрэлтэй иргэдийг төлөвшүүлж чадна. Миний үдээр хүүхэд хамгаалал гэдэг нь хүн бүрийн оролцоо, хайр халамж, итгэл дээр тогтсон ийгмийн хамгийн ариун үнэт зүйл юм. Хүүхэд хамгаалах нь тэдний эрхийг хүндэтгэхээс элдэг. Хүүхэд бүрийн дуу хоолойг сонсож, сэтгэлийг нь ойлгож, итгэлийг нь хүлээж цвал бид ирээдүйгээ хамгаалж байгаа хэрэг юм. Тиймээс хүүхдэдээ хайртай, ааралтай, итгэлтэй байж, хамгаалах орчныг хамтдаа бүрдүүлье. Учир нь өнөөдрийн эд маргаашийн эх орон, гэрэлт ирээдүй юм.

**Э.БОЛОРМАА**
МБС, 1-р курс

"Хүүхэд хамгаалал миний нүдээр"

Хүүхэд гэдэг нь эх дэлхийн амьдрах урам итгэл, ирээдүйн найдвар, эх орны маргаашийн гэрэлт баялаг. Гэтэл хүүхэд бүхэн хүсэлтэй аз жаргалтай амьдарч, эрхээ эдлэх чадах байна уу гэвэл харамсалтай нь тийм биш. Миний нүдээр харвал хүүхэд хамгаалал бол зөвхөн төрийн бодлого биш, харин гэр бүл, сургууль олон нийтийн хамтын хариуцлага юм.

Монгол улсын үндсэн хуульд "Хүүхдийн эрхийг хамгаалах нь төрийн үүрэг" гэж заасан байдаг. Мөн Хүүхдийн эрхийн тухай хуульд хүүхэд бүр эрүүл өсөж бойжих, эрүүл аюулгүй орчинд өсөх, өөрийн үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй гэж тодорхойлсон. Энэ нь цаасан дээрх заалт биш, харин амьдрал дээр бодитой хэрэгжих ёстой баталгаа юм. Гэвч амьдрал дээр хүүхдийн эрх зөрчигдөх тохиолдол цөөнгүй. Зарим гэр бүлд архидалт, ядуурал, хайхрамжгүй байдал нь хүүхдийн хамгааллыг хамгийн том аюул болж байна. Жишээ нь: гэртээ хайр халамжгүй өсөн хүүхэд сэтгэл санааны хүчирхийлэлд өртөж, өөрийгөө үнэлэх итгэлээ алдана. Зарим хүүхэд сургуулийн орчинд дээрэлхүүлж, үл тоомсорлол, ялгаварлалд өртөж байна. Энэ бүхэн хүүхдийн зүрх сэтгэлд сорви үлдээж, ирээдүйн хүн чанар, амьдралын хандлагад сөргөөр нөлөөлдөг. Миний бодлоор хүүхэд хамгааллын хамгийн эхний алхам бол гэр бүл. Ээж аавын хайр, халамж бол хамгийн хүчтэй хамгаалалт юм. Хүүхдүүдтэйгээ ярилцаж, тэдний санаа бодлыг сонсож, цагаа өгөх нь ухаалаг байдлаар өсгөдөг гэр бүлд хүчирхийлэл биш, хайр ургадаг.

“Хүүхэд бол цэцэг шиг” гэдэг үг бий. Энд хүүхэд хүмүүн дунд нийгэм хамгаалж ургана. Тэр цэцэг шиг л тунгалаг хэвээрээ үлдэнэ. Гэр бүлийнхэн, сургуулийнхан бусад хүүхэд хамгаалалын эрх хамгаалж бусдын зовлон шиг ойлгох ёстой бий, харин хүүхдийн хамгаалал байдлыг хангахад анхаарал хандуулах, өөрсдөө хамгаалах нийгмийн орчин бий байх ёстой. Багш нар зовлон хэцүү зааж зөвлөгөө хүүхдийн өмнөөс асуудлыг шийдэж, эрүүл аюулгүй болон хариуцлагатай тэдэнд мэдлэгийг байх учиртай. Өнөөдөр ч маргааш ч хүүхэд хөгжих анхаарал байх ёстой хүүхдэд зайлшгүй хэрэгтэй. Хүүхэд хамгаалал нь зөвхөн цагдаа, сургууль, төрийн байгууллагаар хэрэгжүүлэгдэхгүй, нийгмийн оролцоо ч хэрэгтэй ёстой.

Эцэст нь миний уриалга бол “Хүүхдийг хамгаалах үйлсийг хамтдаа хийе хэмээн”. Энд өнөөдөр хүүхдийн ирээдүйг хамгаалснаар маргаашийн нийгэм илүү гэгээлэг илүү тунгалаг, илүү хүчтэй болно. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль бол бидний баримтлах зүйл, харин хайр халамж бол тэр хүүхдийн ирээдүйг гэрэлтүүлэх болох хүч юм.

Хүүхэд бол ирээдүйн эзэд. Тэдний хамгаалал нь зөвхөн хүүхдийн асуудал биш, бүх нийтийн ирээдүйн асуудал гэдэг нь миний нүдэнд тун тод харагдана.

1-р сургууль 11е ангийн сурагч: Даваажавын Халиунаа.

**Д.ХАЛИУНАА**
1-р сургууль, 11е анги

# Хүүхэд хамгаалал миний нүдээр

"Хүүхэд бол өнөөдрийн хамгийн чухал, үнэ цэнэтэй баялаг" гэж Манай улс 1989 онд НҮБ-ын "Хүүхдийн эрхийн конвенц"-ийг анх дэлхийд 1990 онд соёрхон баталсан байна.

Хүүхдийн эрхийн конвенцид хүүхдийн эрхийн тухай заалтуудыг "хүүхэд байхын ач тус" гэж "Хүүхдийн амьд хөгжлийг хамгаалах, эрүүл өсч бойжих, хөгжих боломж олох, мэдээлэл хүртээмжтэй байх, оролцооны эрхийг хамгаалал" гэж байдаг.

Энэ бүгдийг харахад хүүхдийн өсөж бойжих гэр орчин нь сургууль болох гэр бүл болоод эрүүл орчинд аюулгүй байдал хангагдаагүй бол хүүхдийн сэтгэл зүй, хүмүүжил, цаашдын төлөвшилд сөрөг үр дагавар үүсдэг.

Тухайлбал, судалгаагаар манай улсын сурагчдын 30 орчим хувь нь сургууль дээр үе тэнгийнхний хүчирхийлэлд өртөж байсан бол гэр бүлийн орчинд үүсдэг үл ойлголцол, хүчирхийлэл нь хүүхдийн өөртөө итгэх итгэл болон нийгмийн харилцаанд муу нөлөөтэй нь тогтоогдсон байна.

Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд сургууль, хүүхдийн оролцоог хангах, санал бодлыг нь сонсох "Аюулгүй сургуулийн зөвлөл" ажиллуулах шаардлагатай. Энэ нь зөвхөн дүрэм журам тогтоох бус, харин багш сурагчдын хамтын оролцоонд тулгуурласан, хүүхдийн эрхийг хамгаалах тогтолцоо болох юм.

Гэр бүл нь ч хүүхдээ зөвхөн хувцаслуулах биш, ойлгож сонсож, итгэлцэл бүхий эрүүл амьдралыг бүрдүүлэх нь хамгаас чухал. Ялангуяа, цахим хэрэглээнд "Гэр бүлийн цахим дүрэм" байгуулснаар хүүхэд өөрөө хариуцлагатай хэрэглэгч болж төлөвших боломжтой.

Дүгнэж хэлэхэд, хүүхдийн аюулгүй байдлыг хангах нь зөвхөн гэр бүл эсвэл сургуулиас хамаарах бус, бүх нийгмийн хамтын хариуцлага, ухамсартай иргэнийг төлөвшүүлэх үндэс болно.

**Д.ТУНГАЛАГТАМИР**
Цээл сум, 12а анги

### Хүүхэд хамгаалал миний нүдээр

**Хүүхэд хамгаалал гэж яг юу вэ? Энэ нь зөвхөн хүчирхийллээс хамгаалах тухай ойлголт уу, эсвэл хүүхдийн аз жаргалтай ирээдүйг бүтээх түлхүүр үү?**

Хүүхэд гэдэг бол өнөөдрийн баяр баясгалан, маргаашийн ирээдүй.

Өнөөдөр хүүхдүүдийг хэрхэн хайрлаж, хамгаалж байгаа нь маргаашийн нийгмийн дүр төрхийг тодорхойлно. Миний нүдээр хүүхэд хамгаалал гэдэг нь зөвхөн хүүхдийг хүчирхийллээс хамгаалах тухай биш, харин хүүхэд эрхээ эдэлж, аюулгүй, хайр халамж дүүрэн орчинд өсөж бойжих бүх нөхцөлийг хангах тухай ойлголт юм.

Амьдралд өдөр бүр харж болох жижиг дүр зургууд надад үүнийг сануулдаг. Зарим хүүхэд сургуулийн гадаа инээд баяртай гүйж тоглож байхад, нөгөө нэг нь ганцаараа буланд гунигтай зогсож харагдана. Заримд нь эцэг эхийн хайр энхрийлэл дүүрэн оногддог бол, зарим нь үл хайхралд, ширүүн үгийн сүүдэрт амьдардаг.

Энэ бүхэн хүүхэд хамгааллын хэрэгцээ яагаад зайлшгүй чухал болохыг харуулдаг. Хүүхэд зөвхөн бие махбодын хувьд бус, сэтгэл санааны хувьд ч хамгаалагдах эрхтэй.

Миний бодлоор хүүхэд хамгааллын хамгийн том асуудал бол үл хайхрал.Хүүхдийг зөвхөн идэж ууж, хувцаслаж байвал болно гэж үзэх нь түгээмэл.
Гэвч хүүхэд сонсогдох, санал бодлоо илэрхийлэх, сэтгэл санааны дэмжлэг авах эрхтэй.

Хамгийн гол нь хүүхэд сонсогдох эрхтэй. Хүүхдийн хэлсэн үгс жижиг мэт боловч тэдний сэтгэлийн гүнээс урган гардаг үнэн билээ. Тэднийг сонсохгүй өнгөрөх нь хамгийн ноцтой үл хайхрал юм.
Хүүхдийн хамгаалал бол номын хуудсан дээрх үг биш, амьдрал дээр заавал биелэх ёстой амлалт.
Тэгвэл эдгээр Асуудлыг шийдэхэд олон талын оролцоо хэрэгтэй.
Нэгдүгээрт,гэр бүл хүүхдийн хамгийн анхны бат хамгаалалт бөгөөд эцэг эхийн хайр, анхаарал, сонсох сэтгэл нь хамгааллын үндэс болдог.
Хоёрдугаарт,сургууль бол зөвхөн мэдлэгийн уурхай бус, харин хүүхэд эрх тэгш, найрсаг уур амьсгалд хөгжих орон зай байх ёстой.
Гуравдугаарт,нийгэм бүхэлдээ хүүхдийн эрхийг дээдэлдэг, хүчирхийллийг тэвчдэггүй соёлыг эрхэмлэх шаардлагатай.
Үүнээс гадна хүүхдүүд бид өөрсдөө ч хамгааллын нэг хэсэг. Бид найзаа шоолохын оронд дэмжих, гуниглахад нь хажууд нь сууж сонсох, баярлахад нь хамт инээх нь

хамгааллын хамгийн энгийн хэрнээ хамгийн үнэ цэнтэй хэлбэр юм. Миний нүдээр хүүхдийн хамгаалал гэдэг бол хайр, итгэлцэл, хүндэт сэтгэл дээр бүтдэг нандин гүүр.

Ирээдүйд би хүүхэд хамгаалал бүрэн хэрэгжсэн нийгмийг төсөөлөх дуртай. Тэр нийгэмд хүүхэд бүр сурч боловсрох эрхээ бүрэн эдэлж, тоглохдоо айдасгүй, мөрөөдлөө чөлөөтэй ярьдаг. Тэнд хүүхдийн нулимс далдхан урсахгүй, харин инээмсэглэл ил тод цуурайтна. Томчууд бидний үгийг сонсож, бидний мөрөөдлийг үнэлдэг.

Хүүхдийг хүчирхийлэх, үл хайхрах тухай ойлголт зөвхөн өнгөрсөн цагт үлдсэн байдаг. Хүүхдийг хамгаалах нь өөрсдийн ирээдүйг хамгаалж буй ариун үйл гэдгийг хүн бүр ухамсарласан байдаг.

Тиймээс хүүхэд хамгаалал бол ганц байгууллага, ганц айлын хариуцлага биш. Энэ бол гэр бүл, сургууль, төр, иргэн бүрийн хамтын тангараг. Хүүхдийг хамгаалах үйл хэрэг бол зөвхөн хүүхдийн төлөө бус, хүн төрөлхтний ирээдүйн төлөө хийж буй хөрөнгө оруулалт юм.

Энэ үйлсэд та,би,бид бүгд хамтдаа оролцох учиртай.

Хүүхдийг хамгаалж чадвал бидний ирээдүй гэрэлтэй, маргаашийн тэнгэр цэлмэг байх болно.

**Өнөөдөр биш бол хэзээ? Бид биш бол хэн**

Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 12б ангийн сурагч
О.Бямбацэрэн

# Хүүхэд хамгаалал миний нүдээр

Сайн байна уу? Таны өдрийн амар амгаланг айлтгая. Өнөөдрийн Монголын нийгэмд шуугиан дэгдээж олон хүний гашуун нулимс дуслуулж буй асуудал бол "Хүүхдийн хүчирхийлэл" билээ. Энэ удаагийн эсээд бид [illegible] өөрийн дуу хоолойгоор хүрэх [illegible].

Хүүхдийн сэтгэл гэдэг хайраар дүүрэн ширхэг тэрхүү [illegible] үнэ цэнэтэй зүйл. Тэд бол өнөөдрийн ба ирээдүйн бахархал болох тодорхой [illegible] Монголын эзэд билээ. Гэвч би улам тойрноо харахад бүх хүүхэд адилхан аз жаргалтай аюулгүй орчинд өсөж торниж чадахгүй байгааг өөрийн нүдээр сэтгэл шимшрэн харсан зогсдог. Хүүхэд хамгаалал гэдэг миний нүдээр бол тэдний гарыг атгаж мөрөөдлийг нь дэмжиж, аливаа аюулаас хамгаалж, хайраар дүүргэн өсгөх ариун үйлс билээ.

Өнөөдөр Монголын нийгэмд хаа нэгтээ гэр бүлийн хүчирхийлэлд өртөж, хайрнаас дутаж, хүйтэн хаалганы цаана уйлж буй бяцхан зүрхнүүд байсаар л байгаа гэдэгт би итгэлтэй байна. Тэдний нүдэнд харагдах гуниг бол нийгмийн өвдөлт билээ. Таны эрх бусдын эрхээр хязгаарлагддагийг та мэдэх үү? Таны хэлсэн үг тухайн хүнд ямар сэтгэлзүйн дарамт өгч байгааг та мэдэхгүй шүү дээ. Мөн түүнээс гадна нэгэн чимээгүй дайсан байгаа тэр нь "Цахим орчин" таны нийтэлсэн зүйл хэн нэгэнд сэтгэлзүйн дарамт өгөн түүнийг уйлуулаад байж болох хамгийн муу үр дүнд хүргэж болзошгүй. Манай улсад сэтгэлзүйн дарамтанд орон амиа хорлосон тохиолдол цөөнгүй байгаа.

Хүүхэд хамгаалал миний нүдээр манай улсад маш сул байгаа. Учир нь: Зөвхөн хуулийн байгууллага үүрэг хүлээсэн бүхий зүйлс хүүхдийн эрхийг дангаараа хамгаалж чадахгүй, иргэд бидний туслалцаа тэдний хоосон орон зайг нөхөж чадвал манай улсад хүүхдийн эрх зөрчигдөх нь эрс буурна гэж бодож байна. Монголчууд бид эвтэй байхдаа хүчтэй!

Хүүхэд бол бидний толь гэдэг, таны хэр сайн эцэг эх вэ гэдэг таны хүүхдээс харагдана. Хүний өөрийн гэлтгүй бүх хүүхдийг хайрлан туслалцааны гараа сунгаж байгаарай. Хүн бүр хүүхэд хамгаалагч.

**А.ЦЭЛМҮҮНХАНГАЙ**
3-р сургууль, 11б анги

Хүүхэд хамгаалал [illegible] хүүхэд

Хүүхэд бүр аливаагийн эхэнд байдаг тэдний хамгаалал нь [illegible] хамгийн ариун үүрэг юм [illegible]. Миний хувьд "хүүхэд хамгаалал" гэдэг нь зөвхөн [illegible] хэрэгтэй биш, харин хүүхэд бүрийн ялгаварлалгүй, ижил боломжтойгоор амьдрах эрхийг бүрдүүлэхэд энэ [illegible] хамгийн чухал ач нь тусгай хэрэгцээтэй хүүхдүүдэд зориулсан боловсрол юм.

Бүх хүүхдийн [illegible] нь өөр өөр байдаг.

Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн хувьд суурь боловсрол эзэмших зам нь бусдаас илүү саадтай байдаг. Гэхдээ энэ нь тэд бага үр [illegible] гэсэн үг биш юм. Харин ч бид тэдэнд тохирсон сургалтын арга, орчин бий болговол бусадтай адил суралцаж, мөрөөдлөө биелүүлэх гадна. Миний бодлоор тусгай хэрэгцээт боловсрол гэдэг нь яг энэ боломжийн хаалт нээдэг зүйл юм. Жишээ нь, сонсголын бэрхшээлтэй хүүхдэд дохионы хэл заах, хараагүй бэрхшээлтэй хүүхдэд тусгай ном ашиглуулах, хөдөлгөөний хүндрэлтэй хүүхдэд зориулсан тохирсон анги танхимтай байх нь бүх хүүхэд хамгаалалын нэг хэлбэр гэж би боддог. Энэ бүгд нь тэдний нийгмийн [illegible] болон дэмжлэг, итгэлтэй хүн болж өсөхөд тусалдаг. Гэхдээ үүнийг хэрэгжүүлэх боломжгүй газар байна. Энэ нь одоо орон нутагт (эцэг эх болон) хүүхдүүд юм. Жишээ нь манай Цээл сум гэхэд хөгжлийн бэрхшээлтэй буюу тусгай хэрэгцээт боловсролын 18 хүүхэд байдгаас 18 нас хүрсэн 6, аймагт байдаг 4, Улаанбаатарт байдаг 2, сургуульд хамрагдаж байгаа 2, сургуулийн насны хэрнээ сургуульд хамрагдаагүй -1, бага насны 3 гэх тоон судалгаа байдаг. Манай суманд эдгээр хүүхдүүдэд тохирсон сургалтын арга, суралцах орчин нөхцөл хангагдаагүй, мөн дээрх нь эдгээр сурагчдад тохирсон тусгай багш, [illegible] хүүхдэд зам гаргах тэдгээр [illegible] сонсголын бэрхшээлтэй сурагчид зориулсан [illegible] дохио нь манай сум төдийгүй аймагт ч хангалтгүй байгаа. Эдгээрийн зохицуулалт тэд [illegible] хамрагдах боломж [illegible] гадна энэ бүхэн зөвхөн боловсролын хоцрогдол бус тэдний мөрөөдлийн хязгаарлалт, өөрсдөө итгэх итгэлийг нь алдуулж байдаг. Харин бидний айх ёстой зүйл бол энэ хязгаарлалт аригаа.

Энэ хязгаарлалтын аримахан тул одоо орон нутагт тусгай хэрэгцээт боловсролын [illegible] багштай болж тэдэнд тохирсон орчин нөхцөл бүрдүүлбэл тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн боловсролд тулгарч буй "хязгаарлалт" гэдэг үг ална болж тийм боломж, итгэл мөрөөдөлтэй ирээдүй бий болно.

Тусгай хэрэгцээтэй боловсрол гэдэг нь ерөөсөө тусгай биш, харин тэгш боломж олгох тухай юм. Тэдэнд тусалбал тэд [illegible] [illegible] гарна.

**Г.МИНЖИНСОР**
Цээл сум, 12а анги

## Хүүхэд хамгаалал миний нүдээр

Хүүхдийн инээд бол гэр бүлийн аз жаргал, нийгмийн хөгжил, ирээдүйн гэрэл гэгээ юм. Хүүхэд хамгаалал гэдэг нь надад зөвхөн хууль, журам биш, харин хүн бүрийн зүрх сэтгэлд байх ёстой хайр, халамжийн нэр мэт санагддаг. Хүүхэд гэдэг бол өчигдрийн үргэлжлэл бус, маргаашийн итгэл найдвар билээ. Би өөрийн нүдээр олон янзын хүүхдийг харж байсан. Хөдөөний талд малын бэлчээр дээр тоглон гүйж буй жаахан хүүхэд заримдаа сургуульд явж чадахгүй хоцордог.

Тэр үед би боддог: "Хүүхдэд хамгаалал гэдэг нь зөвхөн аюулаас холдуулах биш, боловсролоор хамгаалах явдал юм." Хотын гудамжинд сургуульд яарч яваа хүүхэд олон нийтийн сүлжээнд доромжлолд өртөж, сэтгэлээр унахыг би сонссон. Тэр үед би ойлгосон: "Хүүхдийг хамгаална гэдэг нь зөвхөн биеийг нь бус, сэтгэлийг нь хамгаалах хэрэгтэй юм байна." Өрх гэрийн амьдралд зарим хүүхэд эцэг эхийн анхаарал, хайр халамжаар дутаж, ганцаардахыг би харсан. Тэгэхэд бодсон минь: "Хүүхэд хамгаалал хамгийн эхэнд гэр бүлээс эхэлдэг. Хүүхдийн сэтгэл дулаан орчинд л бүрэн хамгаалагдана."

Хүүхэд хамгаалал миний нүдээр бол дулаан гарыг атгах, инээмсэглэлээр дэмжих, хажууд нь хамт алхах явдал юм. Энэ бол төр, эцэг эх, багш, нийгмийн ажилтан гэлтгүй хүн бүрийн үүрэг Миний нүдээр хүүхэд хамгаалал бол ганцхан бодлого, хууль биш. Энэ бол итгэл, хайр, дулаан орчин. Хүүхэд бүр хамгаалагдсан орчинд өсөхөд Монголын ирээдүй илүү гэрэлтэй, аз жаргалтай болно

**М.ЭНХ-ИЛҮҮЖИН**
МБС, 1-р курс

**Хүүхэд хамгаалал миний нүдээр**

Би бол өдөр хоногийг аргацааж шоронгийн наран дээр өдөржин шаналжин өшөө хорсол,уйтгар гуниг тээж хэвтэх хүний амь хөнөөсөн алуурчин.

Би 2025 оны хоёрдугаар сарын наймны өдөр чанга дэглэмтэй хорих ангид хувиарлагдаж ирлээ.Хаалга татан өрөөндөө орвол хар багийн найз минь сууж байх нь тэр."Хаана юу хийж яваад халтираад ийшээ ороод ирлээ"гэж гайхсан шинжтэй надаас асуулаа.Гайхаж шаналахтай зэрэгцэн "Найз нь эхнэр,гурван сайхан охины хамт амьдардаг эгэл жирийн аав хүн байлаа.Эхнэр бид хоёр хоёулаа ажил хийдэг,бидний амьдрал боломжын сайхан аж төрдөг байсан сан.

Нэгэн өглөө хичээлдээ явах гээд аавыгаа үнсээд гарсан охин минь эргэж ирсэнгүй.Хичээлээ тараад гэр лүүгээ алхаж байсан охиныг минь хулгайлж эзэнгүй газар аваачин эрэмдэглэн хүчирхийлж бах тавааа хангаж явсныг нь би даан ч мэдээгүй юм.Эрэл сурал болж энд тэндгүй охиноо хайлаа.Хаана байнаа үр минь гэж хаа сайгүй хайхад,охин минь эзэнгүй хашааны модон жорлонд эрээн алаг биетэй болчихсон,эцэж хөшсөн,эрэмдэг зэрэмдэг болчихсон хэвтэж байх нь тэр.Охин минь өнгөрсөн тэр өдрөөс хойш миний амьдрал хөмрөөд ирэх шиг л болсон.Хар тамхиндаа мансуурч хүний сайхан үрийг хайрлах ч үгүй хөнөөж,хөнөөх хөнөөхдөө бүр хүчиндэж хөнөөдөг,хүн дүрст араатнууд,адгуусныас дор амьтад,амьд явах ч эрхгүй хүмүүс байх юм.Охиныг минь онц хэрцгийгээр хөнөөчихөөд арзайтлаа инээгээд,хээл хахуул өгч хэдхэн жилийн ял авчихаад "Ах нь ирэх жилийн ерөнхийлөгчийн өршөөлөөр нарснаасаа гараад нартын амьдралд шилжинэ дээ"гэж ёожилж хэлсэн үгийг нь би тэвчсэнгүй халаасанд явсан хурц тонгоргоороо зүрхэн тушаа газар нь бүлж орхисон юм.Тэгээд л ийшээ халтираад ороод ирлээ дээ гэхэд хэсэг дуугүй сууж байснаа найз минь:"Энэ монгол улсад эмэгтэй хүн болж төрснөөс Египедэд нохой болж төрсөн дээр. Ямар ч хүүхдийн сайн сайхны төлөө,ялангуяа эмэгтэй хүүхдийн төлөө хууль,төрийн бодлогогүй улс юмдаа."Гэмт этгээд хохирогчийг арван зургаан насанд хүрээгүй лавтайгаар эндүүрэн үйлдсэн бол нэгэнтэйгээ зөвшөөрөлцөн ойлголцоод эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөж болно"энэ хуулийг ямар гээч мал нь батлаа вэ?

Хүчингийн хэргийн хуулийг чангалахгүй бол хүний сайхан үрсийг хүссэн зоргоороо хүчирхийлж эцэс сүүлд нь хэдэн халтар төгрөгөөр эрх мэдэлтэнд хахуул өгөөд л энэ бузар үйлдлийг намжаадагаа хэзээ болих вэ?Энэ хуулиа шинэчлэн батлах хүртэл хэдэн аавын эрдэнэ болсон охин хүчирхийлүүлж,хэд нь амь насаа алдаж,хэд нь амиа хорлох бол. Энэ булхай үйлдлийг хийхийг завдсан,хийсэн этгээдийг бүх насаар нь нарсанд шар махтай нь хатаах хэрэгтэй.Ийм бузар зүйлийг хэрхэв ч тэвчиж болохгүй энэ бол эх орны халдашгүй дархан байдлаас илүү том асуудал гэж яриагаа дуусгаад найз минь цаашаа хараад хэвтээд өгөв. Би айж байна энд байх хугацаандаа эхнэр,хоёр охинд минь муу зүйл тохиолдох вий гэхээс хамаг биеийн хар хөлс цутгаж,санаа зовсоор өдөр хоногийг арай ядан өнгөрөөж тэднийгээ санан бэтгэрч байна.Энэ бузар зүйл надаар миний охиноор дуусгавар болог.Үрс бүхэн жаргалтай айх айдасгүй өсөж торниг.

4р сургуулийн 12в ангийн сурагч О.Жамбалдорж

## Тусгай хэрэгцээт хүүхдийн асуудлууд

"Тусгай хэрэгцээт хүүхэд" гэж хэн бэ? тусгай хэрэгцээт хүүхэд гэдэг нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй төдийгүй өөр өөрийн онцлогтой , илүү дэмжлэг ойлголт хэрэгтэй хүүхдүүд юм.

Монголын нөхцөлд тусгай хэрэгцээт хүүхдэд тулгардаг олон бэрхшээлүүдээс хөндөхгүй өнгөрч боломгүй хамгийн сэтгэл эмзэглүүлэм асуудал нь боловсролын хоцрогдол , тэгш хүртээмжгүй байдал болоод байна. Хэдий хүүхэд өөрөө бүхий л чадлаараа хичээж байвч асран хамгаалагчийн халамж дутуу, анги хамт олны төвөгшөөсөн хандлага мөн нийгмээрээ сонжин харах харцанд урам зориг нь мохсоор хүмүүстэй харилцахаас зайлсхийж өөрийгөө тусгаарлаж орхидог. Тэдний асуудлыг шийдвэрлэх нь зөвхөн гэр бүл төдийгүй нийгмийн нийтлэг зорилт байх учиртай.

Харин сурагч миний өнцгөөс тусгай хэрэгцээт хүүхдийн боловсрол,амьдралд тулгарах саад бэрхшээлийн нэлээдгүй хувийг нийгмийн хандлага өөрчилж чадна.Тэдгээр хүүхдүүдэд хамгийн ихээр нөлөөлж чадах нь гэр бүл болон анги хамт олон. Иймд энэ асуудалд хамгийн үр дүнтэй шийдэл нь мэдлэг боловсрол хангагдсаны дээр энэрэх сэтгэлтэй багш , хүмүүс, ажилчдыг чиглүүлэх явдал гэж бодож байна. Зарим сургуульд сурагчдын биеийн онцлогт тохирсон чанарын шаардлага хангасан орчин мэргэжлийн багш ажилчид төнөг төхөөрөмж дутмаг байдаг. Шалтгаан нь энэ асуудалд чиглэсэн хууль тогтоомж дутмагдаа биш хуулийн биелэлт хэрэгжилт хангагдахгүй байгаад юм. Дурьдвал 2022оны 12.21 өдрөөс тэгш хамран сургах боловсролын талаар баримтлах чиглэл 2020 оны 9 сараас "Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхэд үзүүлэх эрүүл мэнд боловсрол нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл мөн сум дүүрэг сургууль бүрд хүүхэд хамгааллын баг ажиллаж байна.

Төрөөс энэ мэтчилэн анхаарал тавьж бодлого чиглэлээ хандуулж байгаа бол хувь хүн, бүлгийн хүрээнд бид юу хийж чадах вэ? Хүүхдийн эрхийг хамгаалах хөдөлгөөн өрнүүлэх эсвэл найз нөхөд хүрээллээрээ тэдэнд аюулгүй мэдрэмж төрүүлэх ч маш том тус болж чадна. Багахан анхаарал халамж сэтгэлд тод гэрэл болон тусдаг шүү дээ.

Та бидний амьдралд тулгарах саад бэрхшээл бүрийг зөвхөн төр шийдвэрлэх ёстой хэмээн хүлээн суусчаас нийгмийн нэгж болсон бид өөрсдөө гэрэл түгээж яагаад болохгүй гэж ? Нийгэм нь хүнийг хүн болгон бүтээдгийн нэгэн адил хүн нь нийгмийг бүтээдэг…..
К.Маркс

**Э.ЭРХСАРАН**
1-р сургууль, 12г анги

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын ерөнхий боловсролын
нэгдүгээр сургуулийн 10е ангийн сурагч У.Нямжаргал

Хүүхэд хамгаалал миний нүдээр

Хүүхэд хамгаалал гэж бодохоор олон янзын бодол миний толгойд эргэлддэг. Заримдаа энэ нь хууль дүрэм мэт санагддаг. Харин миний хувьд хүүхэд хамгаалал гэдэг бол зөвхөн нэг бичиг цаас дээр үлдэх ойлголт биш, харин хүн бүрийн зүрх сэтгэлд оршдог хайр, энэрэл, хариуцлага, итгэлцэл юм. Миний нүдээр хүүхэд хамгаалал гэдэг нь хүүхэд бүрийн инээмсэглэл, мөрөөдөл, аюулгүй байдлыг хадгалж үлдэх баталгаа болоод зогсохгүй хүмүүн нийгмийн жинхэнэ хэмжүүр гэж хэлж чадна.

Хүүхэд бол ирээдүйн эзэд. Томчуудын нүдээр бол хүүхэд өхөөрдөм, гэнэн хамгаалагдах болох ч тэдний өөрсдийнх нь нүдээр хамгаалал гэдэг нь "Та миний дуу хоолойг сонсож байна уу?" "Миний мөрөөдлийг дэмжиж байна уу?" "Намайг хайрлаж, надад итгэж байна уу?" гэх асуултууд байдаг.

Тэдэнд хамгийн хүндээр тусдаг зүйл бол үл тоомсорлол гэж би боддог. Хүүхдийн санал бодлыг сонсохгүй өнгөрөх, мөрөөдлийг нь үл тоох, сэтгэлийг нь ойлгохгүй байх нь хамгийн том шарх үлдээдэг. Иймээс хүүхэд хамгаалал гэдэг нь зөвхөн махбодын аюулгүй байдлыг хангах бус, сэтгэл санаанд нь итгэл төрүүлэх орчныг бий болгох явдал юм.

Өнөөдрийн нийгэмд хүүхдийн эрх зөрчигдөх олон асуудал байсаар байна. Зарим хүүхэд гэр бүлдээ үл хайхрагдах, зарим нь сургуулийн орчинд дээрэлхүүлэх, зарим нь ядуурал, хөдөлмөрийн дарамтад өртөх жишээтэй. Мөн цахим орчинд хүүхдүүд дарамтлал, хуурмаг мэдээлэл болон хүчирхийллийн шинжтэй агуулгад өртөх өндөр эрсдэлтэй байдаг.

Энэ асуудал зөвхөн нэг гэр бүлийн зовлон биш, харин нийгмийн асуудал юм. Хүүхдийг хамгаалах нь төрийн байгууллагын хариуцлагаас гадна бас эцэг эх, найз нөхөд, багш, олон нийтийн хамтын хариуцлага байх ёстой.

Хүүхдийг хамгаалах хамгийн эхний үүрэг бол гэр бүл. Эцэг эх хүүхдээ зөвхөн өсгөхөөс гадна тэдний сэтгэлийг сонсож, мөрөөдлийг нь хүндэтгэж, алдаа гаргасан ч ойлгож дэмжих хэрэгтэй. Хүүхдэд хамгийн том хамгаалалт бол хайр ба итгэл. Сэтгэл санаагаар тайван, ойлгогдож байгаагаа мэдэрч байгаа хүүхэд л өөрийгөө жинхэнэ хамгаалагдсанаар мэдэрдэг.

2. Сургууль

Хүүхэд өдөрт хамгийн олон цагийг сургуульд өнгөрөөдөг. Тиймээс сургуулийн орчинд ялгаварлан гадуурхах, дээрэлхүүлэх, дээрэлхэх, үл тоомсорлох байдал гарвал хүүхдийн хамгаалал алдагдаж буй хэрэг. Багш нар хүүхэд бүрийн онцлогийг хүндэтгэж, ялгаварлалгүйгээр хөгжүүлэх орчныг бүрдүүлбэл жинхэнэ хамгаалал бий болно.

3. Нийгэмд

Хүүхэд хамгаалал бол зөвхөн гэр бүл, сургуульд хязгаарлагдахгүй. Нийгэмд хүүхдийн эрхийг дээдэлдэг соёл, хамтын оролцоо, төрийн бодлогын хэрэгжилт маш чухал. Хууль дүрэм бодит амьдрал дээр хэрэгжихээс гадна хүүхдийн дуу хоолой бодлого боловсруулах түвшинд хүртэл тусгаж чадвал хүүхэд хамгаалал бодитоор хэрэгжинэ.

Мөн хүүхэд хамгаалал гэдэг зөвхөн томчуудын үүрэг биш. Бид өөрсдөө ч нэгнийгээ хамгаалж, ойлгож, дэмжих хэрэгтэй. Хүүхэд хүүхдийг дээрэлхэх бус, харин туслаж, хүндэлж, хамтдаа өсөх нь хамгааллын нэг хэлбэр гэж би бодож байна.

Жишээлбэл, найзынхаа ганцаардах үед нь түүнтэй ярилцах, хэн нэгнийг шоолж байвал түүний талд зогсох нь хамгааллын жижиг боловч хүчтэй алхам юм. Бидний хоорондын итгэлцэл, эв нэгдэл биднийг гадны аливаа аюулаас хамгаалж чадна гэдэгт би итгэлтэй байна.

Би ирээдүйд хүүхдийн эмч болохыг хүсдэг. Энэ бол зөвхөн өвчнийг эмчлэх мөрөөдөл биш. Харин хүүхдийн дуу хоолойг сонсож, сэтгэл зүйн хувьд түшиг болж чаддаг эмч болох юм. Хүүхдэд зөвхөн эм тариа бус итгэл найдвар өгч чаддаг эмч байхыг мөрөөддөг.

Миний бодлоор хүүхэд хамгааллын хамгийн том баталгаа бол хүүхдүүдэд мөрөөдлөө биелүүлэх боломж олгох явдал. Эрүүл, аюулгүй, хайр дүүрэн орчинд өссөн хүүхэд л ирээдүйн нийгмийг гэрэлтүүлэх хүчтэй иргэн болж төлөвшинө.

Хүүхэд хамгаалал миний нүдээр бол хууль дүрмээр бичигдсэн үгээс хамаагүй өргөн утгатай ойлголт. Энэ бол хайр, энэрэл, итгэл дээр тогтсон хамтын хариуцлага. Хүүхэд бүрийн инээмсэглэл, мөрөөдөл хамгаалагдах ёстой. Тэр үед бид зөвхөн хүүхдээ хамгаалж байгаа биш, харин улс орныхоо ирээдүйг хамгаалж байна гэсэн үг.

Хүүхэд хамгаалал бол бидний ирээдүйг гэрэлтүүлдэг итгэл найдварын гэрэл. Энэ гэрлийг хүн бүр хамтдаа асааж, хамгаалж явах учиртай.

**У.НЯМЖАРГАЛ**
1-р сургууль 10е анги

# Хүүхэд хамгаалал миний нүдээр.

Хүүхэд хамгаалал гэж ярихаар бидний нүдэнд юу харагддаг вэ? Гудамжны аюул, танихгүй хүнээс ирэх эрсдэл, үе тэнгийн дээрэлхэлт гэх мэт зүйлсийг тоочих байх. Цаг үе улам цовуун болж, улс оронд минь аймшигтай, сэтгэл сэртхийлгэм үйл явдлууд их болсон.

Ухамсартай хэн бүхэн нь энэ бүхний эсрэг тэмцэж, бас, хариу арга хэмжээ авч байгаа боловч ой түймэр гарсан мэт бага хэмжээний ус их галыг унтрааж чадах нь юу л бол...

Энд тэндгүй л худал, үнэн нь мэдэгдэхгүй мэдээлэл зөвлөгөөнүүд хөвөрсөөр. Энэ бүхний дунд өнө олон мэдээллээр залхсан, аль хэдийн "дожирсон" хүмүүс ч зөндөө байгаа. Ямар үед хаах ёстойг мэдэхийн хувьд мэддэг ч тийм зүйл тохиолдож байгаагүй учир тодорхой нухацтайгаар хүлээж авдаггүй.

Бид анзаардаггүй ч хүчирхийлэл гэдэг зүйл эргэн тойрны хаанаас ч бараг олж болно. Зөвхөн бие махбод гэхээс илүү сэтгэлзүйн, үгэн хүчирхийлэл хүүхдийн насан туршийн шарх сэдэв болж чадна. Илүү их хохирол ч үүсгэж чадна. Хүүхдийн сэтгэл хөдлөлийг үгүйсгэх, бусадтай байнга харьцуулж, ичээвтэр байдалд оруулах зэрэг хамгийн энгийнээр тогтмол анхаарал халамж тавихгүй, хайрлахгүй байх. Бэртээ үгүйлж айдастай, үнэ цэнэгүй

[illegible] тоглож ч их хүүхэд хүрээлэлд [illegible] ч илүү хохирол амсана. Ялангуяа [illegible] [illegible] хүүхдүүд [illegible] дуйн сүх хэрэгцээ, хувийн [illegible] ч бий.

Ялангуяа бидний аав ээж нар "Ган I" үеийн хүмүүс хүмүүжсэн бөгөөд ч хэл газар дээрээ тэдний өөрсдөө хүүхдүүд биш гэж үү. Хүүхдүүд бидэнд зүгээр л хүмүүжлийнхээ сонсдог хүн их, хэзээ үедээ ичиж санаа зовохгүйгээр дэмжих хүн, тэвчээр. Гэвч бидний аав ээж тийм зүйлсийг "хэрэггүй зүйл", "тэнэг" гэх зүгээр нэрлэдэг нь [illegible]. Гэхдээ тэр хэндээ буруу өгөх аргагүй. Тэд чинь хэзээ цагийн үзэл содон хав [illegible] үеийн хүүхдүүд. Нэг ёсондоо, мөн л хохирогчид.

Бид энэ цикийн үргэлжлүүлэгч биш, тасалдал нь байх хэрэгтэй.

Хүүхэд хамгаалал нь зөвхөн хүүхдийн аврах тухай биш, харин ирээдүйд хүчирхийлэгчдийн "үйлдвэрлэхгүй" байх тухай юм. Хайр халамжинд өссөн хүүхэд хэзээ ч муу зүйл хийж сурахгүй билээ.

**Б.БОЛОР-ЭРДЭНЭ**
1-р сургууль, 11а анги

**Хүүхэд хамгаалал миний нүдээр**

Би 10-р ангид сурдаг нэгэн сурагч. *Өдөр бүр ангидаа орж ирэхдээ би найз* нөхдийнхөө инээмсэглэлийг хардаг. *Гэвч тэр инээмсэглэл бүрийн ард ямар нэгэн* нууц гуниг, эсвэл үл хамгаалагдсан *сэтгэл байж болохыг бодохоор, "Хүүхэд* хамгаалал гэж юу вэ?" гэсэн асуулт үргэлж бодолд эргэлддэг.

Ихэнх хүн хүүхэд хамгааллыг зөвхөн биеийн аюулгүй байдал гэж ойлгодог. Гэвч миний нүдээр энэ ойлголт илүү өргөн хүрээтэй. Хүүхэд хамгаалал гэдэг нь хүүхэд бүрийн эрхийг хүндэтгэж, тэгш боломж олгож, хайр халамж, сэтгэл зүйн тайван байдлыг хангах явдал юм.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 2 дугаар зүйлд энэхүү хууль нь Монгол Улсын Үндсэн хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулиудаас бүрдэнэ гэж заасан байдаг. Мөн эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад дүрэм, журам, актууд ч хамаарна. Хэрэв эдгээр хууль бүрэн хэрэгжиж чадвал хүүхэд хамгаалал бодитой оршиж, хүүхэд бүр аз жаргалтай өсөх боломжтой. Гэвч бодит байдал дээр энэ бүхэн зөвхөн цаасан дээр үлдэж, амьдрал дээр хангалттай хэрэгждэггүй нь харамсалтай.

Дээрх хуулиудаас Хүүхдийн эрхийн тухай хуулийн 4.1.1-д "Хүүхдийг ялгаварлан гадуурхагдахгүй байх" гэж заасан байдаг. Гэвч энэ эрхийн хэрэгжилт үнэхээр бүрэн хангагдаж байна уу?

- Манай сумын сургуулийн жишээгээр авч үзье. Цэцэрлэгт явсан хүүхдүүд өөрийгөө илүү илэрхийлж чаддаг бол цэцэрлэгт яваагүй хүүхдүүд болон хөдөө малчин айлын хүүхдүүд нь бүрэг ичимхий, дуугүй хэвээр үлддэг. Ингэснээр жил бүр ижилхэн хүүхдүүд уралдаан тэмцээнд оролцож, бусдад хөгжих боломж бараг олддоггүй.
- Эцэг эхийн хандлагаас ч ялгаа үүснэ. Зарим эцэг эх хүүхдээ дэмжин "Чи чадна" гэж урамшуулдаг бол нөгөө хэсэг нь "Чи чадахгүй" гэж үгээр дарамталж, тэмцээн уралдаанд оруулахгүй, хүүхдийн итгэлийг мохоодог. Энэ бол хүүхдийн сэтгэл зүйн хамгаалалд халдсан хамгийн том зөрчил.
- Мөн найзуудын дунд ялгаварлал бий. Зарим хүүхдийг авьяас, үзэмжээр нь өргөмжилдөг бол заримыг нь шоолж, үл тоодог. Энэ нь хүүхдийг дотогшоо болгож, өөрийгөө үнэ цэнгүй мэтээр бодоход хүргэдэг.

Энэ бүхэн нийлээд "хүүхдийн эрх" зөвхөн бичиг цаасан дээр үлдэж, амьдрал дээр олон хүүхэд бодитоор хамгаалагдахгүй байна гэдгийг харуулж байгаа юм.

Манай ангид нэг найз бий. Тэр маш ухаалаг, зөөлөн сэтгэлтэй хөдөөгийн малчин айлын охин. Гэвч ичимхий, өөрийгөө илэрхийлж чаддаггүй учир ямар ч уралдаан тэмцээнд ордоггүй. Эцэг эх нь ч түүнийг "Хичээлдээ л явж байвал болоо доо" гэсэн шиг харж, бусад талаар дэмждэггүй. Тэр охин үнэндээ тэмцээн уралдаанд оролцох их дуртай ч хүсэл мөрөөдлөө ил гаргаж чадахгүй, дотроо нуусаар явдаг. Түүний орхигдсон мөрөөдөл надад хүүхэд хамгаалал гэдэг нь зөвхөн хууль, дүрэм журам биш, харин хүний зүрх сэтгэлээс эхэлдэг гэдгийг ойлгуулсан. Тэр мөчид би хүүхэд хамгаалал гэдэг нь зөвхөн "чи эрхтэй" гэж бичсэн хууль биш, харин итгэл, урам, хайр гэдгийг гүнзгий ойлгосон.

Хүүхэд хамгааллыг бодит болгохын тулд дараах алхамууд зайлшгүй хэрэгтэй гэж би боддог.

1. Хууль хэрэгжүүлэх – Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан заалтуудыг сургууль, багш, эцэг эх, төр засаг бүх түвшинд хэрэгжүүлэх.

2. Тэгш боломж олгох – Сургууль бүр бүх хүүхдэд дор хаяж жилд нэг удаа өөрийгөө сорих боломж олгох, зөвхөн нэг хэсэг хүүхдэд давуу эрх олгохгүй байх.

3. Эцэг эхийн хандлагыг өөрчлөх – Эцэг эх хүүхдийн хичээл зүтгэлийг үнэлж, зөвхөн амжилтаар хэмжихгүй байх. "Чи чадна" гэж итгүүлэх нь хамгааллын хамгийн хүчтэй арга.

4. Сэтгэл зүйн хамгаалалт – Хүүхэд гэртээ, сургуульдаа сэтгэл тайван, шүүмжлэлгүй орчинд өсөх. Энэ нь хүүхдийн бүтээлч сэтгэлгээ, өөртөө итгэх итгэлийг хамгаална.

5. Хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх – Хүүхдийн дуу хоолойг сонсож, шийдвэр гаргах үйл явцад оролцуулах. Жишээлбэл, сургуулийн дүрэм, арга хэмжээнд хүүхдийн санал бодлыг тусгах.

Эцэст нь дахиад хэлье. Хүүхэд хамгаалал бол зөвхөн хууль биш. Энэ бол хүүхдийн инээмсэглэл, мөрөөдөл, итгэл найдвар. Тиймээс би томчууд, багш нар, эцэг эх, нийгмийн бүх гишүүдэд хандаж хэлмээр байна.

1. Хүүхдийн эрхийг ялгаварлалгүйгээр хамгаалъя.
2. Хүүхэд бүрт адилхан боломж олгоё.
3. Хүүхдийн мөрөөдлийг дэмжицгээе.
4. Хүүхдийн дуу хоолойг сонсъё.
5. Хүүхдийн сэтгэл зүйг хамгаалж, итгэлийг нь хөсөрдүүлэлгүй байцгаая.

Учир нь хүүхэд бүр аз жаргалтай инээмсэглэх эрхтэй. Тэр инээмсэглэл өнөөдрийн аз жаргал төдийгүй, Монголын гэрэлт ирээдүй байх болно.

Цээл сумын ЕБС-ийн 10а ангийн сурагч А.Дэлгэрцэцэг

**А.ДЭЛГЭРЦЭЦЭГ**
Цээл сум, 10а анги

Хүүхэд хамгаалал миний нүдээр

Хүүхэд хамгаалал гэх үг бидний хувьд зөвхөн хууль дүрмийн нэг хэсэг биш, хүүхдийн итгэлцлийн орон зай юм. Бидний өдөр тутмын харилцаа, хамгаалал мэдрэмж байдаг, халамжийн талаар бичсэн дүрэм ч үнэн хэрэгтээ олон хүүхдүүд гэртээ, сургуульдаа сэтгэлийн гүн ганцаардал [illegible] мэдэрч байна.

Хүүхэд хамгаалал, хайр халамж гэдэг нь зөвхөн бичиг баримтад хэвлэгдсэн хоосон үгс биш. Бидний санаа, бидний мэдрэмж, асуудал, зөвлөгөө анхаарч үзэх нь хамгийн чухал юм. Үүгээр олон томчууд хамгийн чухал зүйл болох үүнийг алдагдуулдаг. Ажил, амьдрал, завгүй байдал нь тэднийг биднээс холдуулж харин бидэнд дэлгэц, гар утас, цахим орчин л хамт үлддэг. Энэхүү хоосон орон зай нь бидний сэтгэл зүйн хувьд эмзэг болгож, цахим орчны аюул болон үе тэнгийнхний дээрэлхэлтийн олон ул мөр үлдээх болсон.

Хүүхэд бидний энэ чимээгүй зовлон үргэлж дагаж явдаг. Биднийг үл анзаарах, хүүхдийн асуудлыг үл тоомсорлох бүрт, эрүүл аюулгүй, хүчирхийллээс ангид байх эрх маань дахин дахин зөрчигддөг. Бидний хувьд хүүхэд хамгаалал бол зөвхөн тусгай хэрэгжүүлэх хууль, журам төдий биш бодит хүүхэд бүрийн нүдэнд харсан айдас итгэл хоёрын оршихуй юм. Бидний мэдрэх бүр гэр анзаарагдахгүй өнгөрөхвий гэх цээрэл мөн эцэг эх гэрч үзээд бидний сонсох байх гэж, итгэх үүний найдвар хоёр холилддог.

Хүүхдийн эрхийн зөрчил, хүчирхийлэл бол алслагдсан үл мэдэх хэрэг биш. Энэ бол хэрэг айлын хаалганы цаана, бидний таних гэр бүл дотор, сургуулийн чимээгүй буланд, хүүхэд бүрийн сэтгэл дотор "Яг одоо" өрнөж буй бодит асуудал юм. Бидний дуу хоолой энэ үнэнийг илчилж, хүчирхийллээс ангид байх, хайр халамж хүртэх эрхээ эргүүлэн авахыг хүсэж байна.

Хүүхэд хамгаалал гэдэг нь бидний хувьд үг төдий бус [illegible] ирээдүйг минь [illegible] сайхан [illegible] бий болгоосой гэж хүсэж байна.

**Э.БАТСАЙХАН**
1-р сургууль, 11а анги

*"Хүүхэд хамгаалах миний нүдээр"*

Сайн байцгаана уу? өнөөдөр би та бүхэнд " Хүүхэд хамгаалал миний нүдээр" гэсэн сэдвээр бодлоо хуваалцах гэж байна. Миний бодлоор хүүхэд хамгаалал гэдэг нь зүгээр нэг хууль дүрэм биш. Энэ нь хүүхэд бүрийг хайрлаж сонсож, аюулгүй орчинд өсгөж хүмүүжүүлэх, тэдний хүсэл мөрөөдлийг биелүүлэхэд туслалцаа дэмжлэг үзүүлэх ойлголт гэж боддог. Бид хүүхдийг зөвхөн хүчирхийллээс хамгаалах бус, тэдний эрх чөлөөг, бие сэтгэл зүйн асуудал хийгээд бүхий л тал дээр нь туслан дэмжиж нийгэмд зөв боловсон иргэн хойч бий болоход нь нийгмийн талаас дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Хүүхдийн ертөнцийг би бэх түсээгүй цагаан цаастай адилтгана. Эмзэгхэн хэрнээ энгэлхэн тэр үнэт эрдэнийг нандигнан хайрлах үүргийг томчууд хүлээдэг. Харамсалтай нь өнөөгийн нийгэмд хүүхэд бид эрхээ хангалттай эдэлж чадахгүй байна. Хаа сайгүй үйлдэгдэх хар дарсан зүүд мэт хүчирхийллүүд, бяцхан зүрхний ирээдүйн итгэл найдварыг унтрааж чадах томчуудын буруутай үйлүүд.

Эх орны ирээдүй хойч болсон хүүхдүүд бид ийм л нийгэмд төлөвшсөөр буй нь харамсалтай. Юуны өмнө " Гэр бүл" гэдэг хүүхдийн төлөвших , аюулгүй амьдрах ертөнц юм. Эцэг эхийн хайр зөвхөн хоол унд, хувцас хунар өгөхдөө биш харин хүүхдээ ойлгож сэтгэлийг нь сонсож, итгэж бүх л зүйлд туслахад оршдог. Хүүхдүүдээ алдаа гаргасан үед үгээр зэмлэж загнах биш учрыг нь ойлгуулж зөв замыг зааж өгөх нь эцэг эхийн зүгээс биднийг хайрлах сэтгэлийн илрэл мөн болов уу гэж би боддог. Хүний хамгийн эмзэг асуудал сэтгэл зүй, үл хайхрал, бие махбодын хүчирхийлэл байдаг. Бид л энэ нийгмийн харанхуй талыг гэрэлтүүлж ирээдүйн сайн сайхныг бүтээх их үйлсийн эзэд юм. Харин эцэг эхийн хараа хяналт сул хүүхэдтэйгээ нээлттэй ярилцаж чадахгүй, бидэнд тулгамдаж буй асуудлын талаар мэдээлэл дутмаг учраас монголчуудын хэлдгээр өнгөрсөн борооны хойноос цув нөмрөв гэгчээр олон янзын үл мэдэгдэх хэрэг зөрчилд өртсөний хойно асуудлыг шийдвэрлэх нь нэгэнт оройтсон байдаг. Бид өөрсдөө нийгэмд идэвх оролцоо, дуу хоолойгоо нэгтгэн нийгмийн зохисгүй үйлдлийг эсэргүүцэхийн тулд зарим нэгэн зарчмыг даган биелүүлэх хэрэгтэй. Нийгэмд эзлэх бидний байр суурь,

хамгаалагдах хууль дүрэм нилээн өндөр түвшинд байдаг нь бахархууштай. Эдгээрээс цухас дурьдвал:

- ***Хүүхэд хамгаалалд дараах зарчмыг баримтлана***

1. Хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол, аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавих
2. Хүүхдийн үзэл бодол, саналаа илэрхийлэх эрх, оролцоог хангах
3. Хүүхдийн нөхцөл байдал, ялгаатай онцлогийг хүлээн зөвшөөрөх, хүүхдийн нэр төрийг хүндэтгэх гэх мэт олон төрлийн хууль зарчимууд байдаг. Хүүхдийн эрх бол хүн бүрийн эрх юм.

Харин сургууль бол хүүхдийн хоёр дахь гэр. Бид сургууль дээрээ мэдлэг олж авахаас гадна найз нөхөдтэй болж, хамтдаа өсөж торнидог. Гэвч заримдаа хүүхдүүд бие биенээ дээрэлхэх, шоолох, гадуурхах тохиолдол гардаг. Энэ үед багш нар, найзууд хамгаалж, дэмжиж чаддаг байх нь маш чухал. Томчууд бол хүүхэд бидний тольны тусгал юм. Хүүхдүүдийг зөвхөн эцэг эх, багш нар биш бүх хүмүүс хайрлаж хамгаалдаг байх ёстой гэж үздэг. Хэрвээ ямар нэгэн үл мэдэгдэх хүмүүс хүүхдүүдийг дээрэлхэж, дарамталж байгааг хараад чимээгүй өнгөрөх биш хүн бүр иргэнийхээ үүргийг биелүүлж туслах нь хүүхэд хамгаалалтын нэг хэсэг гэж боддог. Эцэст нь хэлэхэд миний нүдээр "Хүүхэд хамгаалал" гэдэг нь хүүхэд бүр айдасгүйгээр инээмсэглэж, мөрөөдлөө биелүүлэх боломжтой байхыг хэлдэг. Хүүхдийг хамгаалж чадвал бид илүү гэрэлтэй, аз жаргалтай ирээдүйг хамтдаа бүтээнэ.

*Эх дэлхийн бяцхан үрс мөнхөд амар амгалан байж, гэгээн тунгалаг сэтгэлээрээ гэрэлт ирээдүйг гийгүүлж байг.*

Биднийг хамгаалж өгвөл, маргааш бид бусдыг хамгаалж чадна.

Овог нэр: Б. Хонгорзул

Сургууль: МБС

Анги: Компьютер оператор

**Б.ХОНГОРЗУЛ**
МБС, 3-р курс

"Хүүхэд хамгаалал миний нүдээр"

Хүүхэд гэдэг бол гэрэлтсэн ирээдүй, тэдгээрийн инээд хөгжил бол бидний дууны хамгийн үнэтэй аялгуу, дуу хоолой нь [illegible], харин хамгаалалт шаардлагатай хүүхдүүд олон бий. Миний нүдээр бол хүүхэд хамгаалал гэдэг нь зөвхөн [illegible] хамгаалах төдий зүйл биш, харин хүүхэд өөрийгөө илэрхийлэх, мөрөөдлөө биелүүлэх, аюулгүй тайван орчинд өсөж хүмүүжих боломжийг бүрдүүлэх тухай ойлголт юм.

Эхлээд гэр бүлээс эхэлье. Гэр бүлийн дулаан уур амьсгал бол хүүхдийн хамгийн том хамгаалалт. Хүн бүрийн хайранд өссөн хүүхэд өөртөө итгэлтэй, бусдыг хайрлах чаддаг хүн болж төлөвшдөг. Харин маргаан, үл ойлголцол дунд өссөн хүүхэд айдастай, өөрийгөө үнэлж чадахгүй болох нь олонтаа. Тиймээс хүүхдэд зөвхөн хоол ундаар бус, хайр, анхаарал, итгэлээр хамгаалах нь хамгийн чухал. Хоёрдугаарт, сургуулийн орчин хүүхдийн хамгаалалд онцгой нөлөөтэй. Сургууль зөвхөн мэдлэг олгодог газар биш, харин хүүхэд хүнтэй харилцах, өөрийгөө илэрхийлэх, мөрөөдлөө дагах талбар юм. Дараагийнх, дээрэлхэлтгүй, багш сурагчдын харилцаа харилцан хүндэтгэл дээр тогтсон байвал хүүхэд өөрийгөө хамгаалсан үнэ цэнэтэй хүн гэдгээ мэдэрнэ. Гуравдугаарт нийгмийн оролцоо зайлшгүй. Гудамжинд үлдэж байгаа хүүхдийн тоо бус, харин анхаарч, туслах гаргадаг нийгэм бол хүүхэд бичигдэж зүйл биш, хүн бүрийн үйлдэлд орших сэтгэлтэй үнэт зүйл.

Миний нүдээр хүүхэд хамгаалал гэдэг бол хайр, хүндлэл, итгэлээр бүтдэг том цогц ойлголт. Хүүхэд бүр өөрийгөө хамгаалж, дуу хоолойгоо илэрхийлж гаргадаг нийгэмд бид ирээдүйгээ баталгаатай болгож чадна. Хүүхэд хамгаалах нь зөвхөн тэдний төдийгүй, бид бүгдийн ирээдүйг хамгаалж буй гэсэн үг юм.

"1-р сургууль 12г Б.Маргад-Эрдэнэ."


**Б.МАРГАД-ЭРДЭНЭ**
1-р сургууль, 12г анги

## Хүүхэд хамгааллын бодлого миний нүдээр

Хүүхэд бол гэр бүлийн баяр баясал төрүүлэгч үнэт үндэс-ний ирээдүй. Ирээдүйг хамгаална гэдэг нь өнөөдөр хүүхдүүд-ийг хамгаалж тэдэнд зөв орчин нөхцөл бүрдүүлэхтэй шууд холбоотой. Тиймээс хүүхэд хамгааллын бодлого бол зөвхөн төр засгийн баримт бичиг бус, хүн бүрийн өдөр тутмын амьд-ралд хамааралтай, зайлшгүй хэрэгтэй үнэт зүйл гэж би хардаг.

Өнөөгийн нийгэмд хүүхдүүд олон төрлийн сорилт, эрсдэлтэй тулгарч байна. Зарим хүүхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртөх зарим нь сургуулийн орчинд дээрэлхүүлж, үл тоомсорлогдох тохиолдол бий. Мөн гудамжинд гарах үед замын хөдөлгөөний аюул, буруу нөхцөлд өртөж болох эрсдэл өндөр. Үүн дээр нэмээд цахим орчинд хүүхдүүдийг төөрөгдүүлэх, залилан хийх, дээрэлхэх тохиолдол ч цөөнгүй. Эдгээрийг харгалзан үзвэл хүүхэд хамгааллын бодлого бодит хэрэгцээтэй маш чухал гэдэг нь тодорхой. Миний хувьд хүүхэд хамгааллын бодлого дараах хэдэн зүйлд онцгой анхаарах хэрэгтэй гэж боддог.

1. Гэр бүлийн орчинд хамгаалах – эцэг эх хүүхдээ хайрлаж тэдэнд зөв хүмүүжил, аюулгүй уур амьсгал бүрдүүлэх нь хамгийн эхний алхам юм. Үүнд эцэг эхийн боловсрол, хандлага харилцааны соёл чухал үүрэгтэй.

2. Сургууль дээр хамгаалах – Сургууль бол хүүхдийн ихэнх

цахим орчноос гадна. Тиймээс урьдчилан, сэрэмжлүүлэх ойлголтыг тэгшлэн зохих, багш нар хүүхэд бүрийн онцлогт зөв дадал үйлдэл төлөвшүүлэх нь хамгаалалтын нэг алхам юм.

3. Олон нийтийн орчинд хамгаалах - Хүүхдийн аюулгүй тоглох талбай, олон нийтийн үйлчилгээ, соёлын байгууллагаар хангах нь нийтийн бүх иргэний үүрэг.

4. Цахим орчинд хамгаалах - Интернэт бол хүүхдүүдийн мэдлэгийн эх сурвалж төдийгүй эрсдэлтэй талбар. Тиймээс хүүхэд, эх, багш нар зөв хэрэглээний талаар сургах нь хамгаалалтын шинэ чухал хэсэг юм.

Би өөрийнхөө нүдээр хүүхэд хамгааллын бодлогыг харахад зөвхөн хуулийн заалт бус хүн бүрийн ухамсар хандлага дээр тулгуурлах ёстой гэж боддог. Хүүхэд хамгааллын бодлого бол улс орон бүрийн ирээдүйг хамгаалах хамгийн том хөрөнгө оруулалт юм. Миний нүдээр энэ бодлого нь хүүхэд бүрийг аюулгүй, аз жаргалтай, итгэл дүүрэн өсч торниход зориулагдсан байх ёстой. Хүүхдийг зөвхөн төр хамгаалах биш, гэр бүл, сургууль, нийгэм нийтээрээ хамтдаа хамгаалбал л энэ бодлого бодит амьдрал дээр хэрэгжинэ.

Ирээдүйд би ч гэсэн эргэн тойрныхоо хүүхдүүдийг хайрлан халамжилж хамгаалж чаддаг хүн байхыг хүсдэг. Хүүхэд хамгаалсан нийгэм гэрэлтэй, итгэлтэй ирээдүйтэй нийгэм болохыг итгэнэ.

12а ангийн сурагч Д.Буян-Өлзий

**Д.БУЯН-ӨЛЗИЙ**
1-р сургууль, 12а анги

Save the Children

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Аризона төв, 4-р давхар
+976-11-329365, +976-11-329371
+976-11-329361

mongolia.secretary@savethechildren.org
www.savethechildren.mn
Save the Children in Mongolia
Save the Children MN  Savethechildren.mongolia